

# Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс

Эмхэтгэсэн: Emma L. Clark, Жавзансүрэнгийн Мөнхбат

Редактор: С. Дуламцэрэн, J. E. M. Baillie,  
Н. Батсайхан, Р. Самъяа, M. Stubbe

Өмнөх үг: И.Эрдэнэбаатар

Проф. Р. Самъяа

Удиртгал: Проф. С. Дуламцэрэн



ДЭЛХИЙН БАНК



Royal Netherlands Embassy





Энэ номыг хэвлэх ажлыг Дэлхийн Банк, Нидерланд-Монголын Итгэлийн сангийн Байгаль орчны шинэчлэл төслөөр санхүүжүүлэв.

Энэ номонд дурьдсан үр дүн, тайлбар, дүгнэлт зэргийг зөвхөн зохиогчид дэвшүүлсэн тул Олон Улсын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, Дэлхийн Банкны гүйцэтгэх захирал, засгийн газрын төлөөлөгчийн үзэл бодлын илэрхийлэл байх албагүй юм.

Энэ номонд орсон мэдээ баримтын нарийвчлалыг Дэлхийн Банк хариуцахгүй. Уг номонд дүрсэлсэн газрын зургуудын улс төрийн хил, өнгө будаг, нэршил, бусад мэдээлэл аливаа нутаг дэвсгэрийн хууль эрх зүй, эсвэл улс төрийн хил, хязгаарын бүрэн бүтэн байдал, түүнийг баталгаажуулсан баримт бичиг нь Дэлхийн Банканд хамааралгүй юм.

Монгол улсын хөхтөн амьтны хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл номыг гаргахад Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (ДБХХ) нь өөрсдийн мэргэжилтэн, шаардлагатай мэдээ баримт болон бусад техник ажиллагааны туслалцаа үзүүлсэн болно. ДБХХ-ны дэмжлэг туслалцаагаар хэвлэгдэж буй энэ номны мэдээ баримт нь ДБХХ-ны үзэл бодлыг төлөөлөгүй болно.

Нийтлүүлсэн: Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Регентс Парк, Лондон, NW1 4RY

Зохиогчийн эрх: © Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг болон номыг гаргахад дэмжлэг үзүүлсэн байгууллагууд болон хүмүүс 2006. Бүх эрх хамгаалагдсан. Уг номны тодорхой нэг хэсгийг худалдааны бус зориулалттай ашигласан тохиолдолд эх сурвалжийг нь дурдаж талархал илэрхийлсэн байх ёстой.

ISBN: 978-99929-0-234-5.

Ишлэл: Clark, E. L., Мөнхбат, Ж., Дуламцэрэн, С., Baillie, J. E. M., Батсайхан, Н., Самьяа, Р., Stubbe, M. (эмхтгэгчид ба редакторууд). (2006). *Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс*. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 1. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот (Монгол, Англи хэлээр).

Түлхүүр үг: Улаан данс, устах эрсдэл, хөхтөн амьтан, Монгол улс, хамгааллын төлөв, ховордлын гол шалтгаан.

Хэвлэлийн газар: ADMON хэвлэлийн газар, Улаанбаатар хот.

Нүүр хавтасны зураг:

Баданга хүдэр (*Moschus moschiferus*) гэрэл зургийг R. Reading; Шар үнэг (*Vulpes vulpes*) гэрэл зургийг R. Reading; Хавтгай тэмээ (*Camelus bactrianus ferus*) гэрэл зургийг R. Reading; Соотон алагдаахай (*Euchoreutes naso*) гэрэл зургийг M. Stubbe; Аргаль хонь (*Ovis ammon*) гэрэл зургийг R. Reading; Монгол хулан (*Equus hemionus*) гэрэл зургийг M. Stubbe.

Зураач: А. Хүрэл-Эрдэнэ, Б. Гантулга

Энэ номонд орсон хөхтөн амьтны зүйлийн тухай нарийвчилсан мэдээлэл нь Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн санд орсон болно. Энэ мэдээлэл олон нийтэд нээлттэй тул дараах хаягаар хандана уу:

Улаанбаатар хот, Монгол Улсын Их Сургууль  
Биологийн Факультет, Амьтан Судлалын тэнхим  
Н. Батсайхан

Утас: +976 99181899

Электрон шуудан: batsaikhan@biology.num.edu.mn эсвэл microtusb@yahoo.com

Энэ ном нь цөөн тоогоор хэвлэгдэх бөгөөд электрон хувилбарыг ЛАСН-ийн номын сангийн интернэт хуудас (<http://library.zsl.org>) эсвэл [www.regionalredlist.com](http://www.regionalredlist.com) хаягаар дамжуулан авах боломжтой тул дээрх хаягийг онцгойлон дурдав.



# ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>3</b>
<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>5</b>
<b>УДИРТГАЛ</b>	<b>7</b>
<b>ТАЛАРХАЛ</b>	<b>9</b>
<b>ТАНИЛЦУУЛГА</b>	<b>13</b>
<b>ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ХОЛБООНЫ УЛААН ДАНСНЫ АНГИЛАЛ БА ШАЛГУУРЫГ АШИГЛАН БҮС НУТГИЙН ТҮВШИНД ҮНЭЛЭХ ЗААВАРЧИЛГАА</b>	<b>15</b>
<b>АРГА АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКИЙН ТЭМДЭГЛЭГЭЭ</b>	
Нэр томъёо, ангилбар	17
Бүс нутгийн тархац	18
Зүйлийн тархацын зураг	18
Гар зураг	19
<b>ЗҮЙЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА</b>	<b>21</b>
<b>МОНГОЛЫН ХӨХТӨН АМЬТНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ</b>	<b>23</b>
<b>МОНГОЛЫН ХӨХТӨН АМЬТНЫ ТАРХАЦ</b>	<b>27</b>
<b>МОНГОЛЫН ХӨХТӨН АМЬТАНД УЧИРЧ БҮЙ АЮУЛ ЗАНАЛ</b>	<b>29</b>
<b>ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ</b>	
Мэрэгчтэн	31
Туулайтан	74
Зараатан	79
Шавьж идэштэн	81
Гар далавчтан	88
Махчтан	98
Туурайтан	119
Туруутан	122
<b>НОМ ЗҮЙ</b>	<b>139</b>
<b>ХАВСРАЛТ</b>	
I. ДБХХ-ны Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг зүйлийн ховордлын зэрэглэлийг үнэлэхэд ашигладаг А-Е хүртлэх шалгуурын товч тайлбар (IUCN, 2001-ын товч тайлбар)	<b>154</b>
II. Жагсаалт 1: Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн семинарын үеэр үнэлэгдсэн Монгол орны хөхтөн амьтны зүйлүүд Жагсаалт 2: Монголд тохиолдох боломжит зүйлүүд	<b>155</b>



## ӨМНӨХ ҮГ

Монгол орны байгаль цаг уурын эрс тэс нөхцөл, экосистемийн онцлог байдал нь манай орны амьтан, ургамлын аймгийн зүйлийн элдэв хэлбэрийн өвөрмөц байдлыг илэрхийлдэг.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөл болон хүний хүчин зүйлийн элдэв нөлөөгөөр Монгол орны экосистемийн төлөв байдалд сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөл нь цөлжил, хөрсний доройтол, усны нөөцийн хомсдол, биологийн элдэв хэлбэрийн ховордол, байгалийн гамшгийн давтамжийн өсөлт зэргээр илэрч байна.

Энэ нь та биднээс уул ус, ургамал, амьтнаа шүтэн хамгаалж, агуулан арвижуулж ирсэн түүхэн уламжлал хийгээд өнөө цагийн шинжлэх ухааны ололт, үндэслэлийг сайтар уялдуулан ажиллахыг зүй ёсоор шаардаж байна.

Монгол орны ховордсон ба ховордож устаж болзошгүй ургамал, амьтны төрөл зүйлүүдийг бүртгэн багтаасан Улаан номыг 1987, 1997 онуудад хэвлэн гаргасан билээ.

Дэлхийн Банк, Нидерландын Вант улсын Засгийн газрын дэмжлэгээр ‘Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан’ төслийн хүрээнд Монгол орны сээртэн амьтдын **Улаан данс** цувралын түрүүч болох хөхтөн амьтны Улаан дансыг бэлтгэн гаргалаа. Үндэсний эрдэмтэн судлаачид, гадаадын зарим эрдэмтдийн оролцоотой бүтээсэн энэхүү **Улаан данс** нь манай орны хөхтөн амьтны тархац, ховордолтын зэрэг, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, хамгаалах арга хэмжээг олон улсын жишгээр боловсруулж тусгасан бүтээл болжээ.

Уг бүтээл нь салбарын хэмжээнд баримтлах шинжлэх ухааны байгууллагын зөвлөмжийн шинжтэй үндсэн баримт бичиг бөгөөд байгаль хамгааллын бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачид, байгаль хамгаалагчид, оюутан, сурагч, байгальд элэгтэй иргэн бүрийн сэтгэлд нийцнэ гэдэгт гүнээ итгэж байна.

МОНГОЛ УЛСЫН

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД



И. ЭРДЭНЭБААТАР



## ӨМНӨХ ҮГ

Эдийн засгийн хөгжилд амьтан, ургамлын аймаг, хөрс илүүтэй өртдөгийг мэдэрсэн хүмүүсийн санаачилгаар XIX зууны эхээр байгаль хамгааллын хөдөлгөөн үйлдвэржсэн орнуудаас анх үүсэж эхэлжээ. Эх орныхоо ургамал, амьтны аймаг, байгалийн нөөц баялгийг хайрлан хамгаалах үйл ажиллагаанууд XXI зуунд аж үйлдвэрийн хөгжил эрчимжихийн хэрээр түүнийг даган идэвхжиж байна.

Е. О. Wilson ‘Биологийн Олон Янз Байдал’ (1988) бүтээл дэлхий нийтийн анхаарал татаж хамгийн сайн борлогдсон бүтээл болсноос хойш биологийн олон янз байдал хэмээх нэр томъёог өргөнөөр хэрэглэх болжээ. Энэ нэр томъёо нь тухайн нутгийн биологийн олон янз байдлыг илэрхийлээд зогсохгүй дэлхийн өнцөг булан бүрт дэлхийн хүрээлэн буй орчны асуудлыг шийдвэрлэх арга замыг нэгтгэн сайжруулахад хамтран ажиллаж буй хүмүүсийн мэдлэгийг нэмэгдүүлж байна. Үүний нэг жишээ бол 1992 онд Бразилын Рио де Жанеро хотод батлагдсан Биологийн Олон Янз Байдлын Конвенци юм. Энэ конвенцийн үр дүнд хүний нийгмийн хөгжил нь байгаль хамгаалал, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нягт уялдаатай гэдгийг нийгэм, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн хөгжлөөрөө ялгаатай улс орнуудад хүлээн зөвшөөрсөн байна.

Аж үйлдвэрийн хөгжил алгуур явагдаж буй Монгол орны газар нутгийн ихээхэн хэсэг нь бараг хөндөгдөөгүй унаган төрхтэй байгаа нь эртний уламжлалт нүүдлийн ахуй нь байсаар байгаатай холбоотой юм. Өнгөрсөн зууны турш Монгол орны малын тоо толгой байнга өсөж, XX зууны эхээр 10 орчим сая байсан бол хувьчилснаас хойш малын тоо эрчимтэй өсөж 1990-ээд оны эцэст 33.6 саяд хүрсэн байна. Энэ байдал нь нэлээд нутгийн бэлчээрийг талхлагдалд оруулж, 2001-2002 онд 58.2 сая га бэлчээрийн газар байгаа гэж үнэлсний 44,7 хувь нь доройтож (Цэрэндаш, 2005), 1.2 сая га тариалангийн талбайн 46,5 хувь нь атаршиж орхигдсон байна (Аваадорж, 2005). Монголд нүүрлэж буй бэлчээрийн доройтол нь ургамлын бүрхэцийг багасгаж, хөрсний бүтэц, чанарыг муутган улмаар газар нутгийг цөлжүүлж байна. Үүнээс гадна дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөл, үлийн цагаан оготно (цайвар үлийч) болон царцааны хэт олшролоос үүдэн бэлчээрийн ургамал сүйтгэгдэж байгаа зэрэг нөлөө сөрөг өөрчлөлтийг авчирч байна гэж ихэнх хүмүүс үздэг. Гэвч газар тариалан болон хадлан авахад хэрэглэгдэж буй тохиромжгүй арга техник, бараг менежментгүйгээр мал аж ахуйг эрхлэх, байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт, ашигт малтмалын олзворлолт зэрэг хүний үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин болон экосистемүүдэд сэргээгдэхээргүй хохирол бий болгох гол шалтгаан болж байгааг төдийлөн анхаарахгүй байна. Түүнчлэн үйлдвэржилт, химийн бодисын зохисгүй ашиглалт нь хэдэн мянган га ойд нөлөөлж ихээхэн хэмжээний газар нутгийг доройтуулжээ.

Монгол орны газар нутгийн ихэнх нь хуурай бүс нутагт хамаардаг ба эх газрын уур амьсгалтай учраас усны нөөц хамгийн чухал асуудлын нэг болдог. Ус бол амьдралын эх булаг учраас хүн мал хязгаарлагдмал усны нөөцийг дагаж төвлөрөн, голын гульдрил дагуух хөрсний элэгдэл, ургамал бүрхэвчийн доройтол, хөрсний нягтаршлыг үүсгэж байна. Эдгээр нөлөөлөл нь хуурайшлыг улам ихэсгэж, хөрсний ус шингээх чадварыг бууруулж, улмаар хөрсний чийгийн агууламжийг багасгаж тал хээрийн гол, горхи, булаг, шанд ширгэж хатахад хүргэж байна.

Зүйлүүд устах болсон үндсэн шалтгааны нэг бол байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт юм. Хүн ямар нэгэн хэрэгцээгээ хангахын тулд ургамлыг ашиглах, амьтныг агнаж буй шууд нөлөөлөл болон амьдрах орчин доройтсоноор тухайн амьтанд хэрэгцээтэй байгалийн нөөцийг хомсдуулах, амьд биесийн хоорондын холбоог өөрчлөх гэх мэт дам нөлөөллийг агуулдаг. Дам нөлөөллийн улмаас бүлгэмдэл бүхэлдээ устах аюулд хүрч болдог. Амьд биесийн статусыг болон ховордуулах шалтгаануудын нөлөөллийг удаан хугацаанд тандан судлах нь байгаль хамгаалах үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол орны гуурст дээд ургамал болон сээр нуруутан амьтдын зүйлүүдийн тархац, популяцийн тоо хэмжээ, амьдралын эргэлтийн талаар нэлээд мэдээлэл хуримтлагджээ. Гэсэн хэдий ч бичил биес, доод ургамал, сээр нуруугүй амьтанд судалгаа бага хийгдсэн бөгөөд хараахан судлагдаагүй зүйлүүд ч байна. Хүний хэрэгцээг хангадаг эдийн засгийн ач холбогдол бүхий ургамал, амьтны зүйлүүд нь биологийн олон янз байдлын чиг хандлагыг харуулах нэг илтгэгч болж чадахын зэрэгцээ байгаль орчныг хамгаалах бодлого боловсруулах, бодит үйл ажиллагааг төлөвлөхөд тус болдог.

Зүйл үүсэх эволюцийн процесс сая сая жил үргэлжилдэг боловч үүссэн зүйл асар богино хугацаанд устдаг гэдгийг бид мэддэг. Үүний нэг жишээ нь Монголын зэрлэг адуу тахь юм. Монголд амьдардаг байсан энэ зүйлийг XIX зууны сүүлээр шинжлэх ухаанд шинээр нээсэн ч XX зууны дунд үед байгальд утсан юм. Тахь адууг дэлхийн олон орны засгийн газар, төрийн бус байгууллагууд, байгальд элэгтэй хүмүүсийн олон жилийн нөр их зүтгэлийн ачаар уугуул нутагт нь сэргээн нутагшуулж чадлаа. Энэ ажил дэлхийн байгаль хамгааллын түүхэнд үнэхээр үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Дэлхийн нэлээд олон орон өөрийн биологийн олон янз байдлыг хамгаалах мөрийн хөтөлбөрийг шинжлэх ухаанч хандлагаар боловсруулсан байдаг. Тэрхүү хөтөлбөр нь Монголд хийгдэж байгаагүй бөгөөд 'Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны Улаан дансны ангилал, шалгуур' (IUCN, 2001)-аар амьтан, ургамлын ангилал зүйн томоохон бүлгийн хамгааллын статусыг тогтоох, ховордож буй зүйлүүдийн хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэлийг боловсуулах, биологийн олон янз байдлын мэдээллийн сан байгуулах шаардлагатай байсан. Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийг Дэлхийн Банкнаас санхүүжүүлж дээрх ажлууд хийгдсэн юм. Монгол орны хөхтөн амьтны бүх зүйлийн устах эрсдэлийн үнэлгээний үр дүн энд байгаа бөгөөд бүх хөхтөн амьтны хамгааллын арга хэмжээг сайжруулахад дээрхи үр дүнг ашиглахад хялбар байх болно.

*Профессор Р.Самъяа*  
*Монгол Улсын Их Сургууль*

## УДИРТГАЛ

Монгол улсад 128 зүйл хөхтөн амьтан бүртгэгдээд байна. Тэдний дотор монголын болон Төв азийн эндемик эртний үлдэс зүйл, Монголд төдийгүй дэлхийд ховордсон махчтан, тууртан, гар далавчтан, мэрэгчдийн зүйл олон. Монголчууд эртнээс нааш нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйн зэрэгцээгээр ан авын ажил эрхэлсээр иржээ. Монгол орны амьтны 45 хувь нь уламжлалт агнуурын өргөн ач холбогдолтой амьтад юм. Үүний тод жишээ нь уул ус, ургамал, ан амьтныг хамгаалах, зохистой ашиглах тухай 1206 онд гарсан Чингис хааны Их засаг хууль юм. Монголд XIII зууны сүүлчээр анхны сүлд тахилгат дархан газрууд бий болж, төрөөс ёсчлон тогтоож байжээ. Улаанбаатар хотын дэргэдэх Богдхан уул бол 1778 оны зарлигаар албан ёсоор дархалсан дэлхийн ууган дархан газруудын нэг болно. Одоо монгол орны байгалийн бүх бүслүүрээс оролцсон, улсын нутаг дэвсгэрийн 13,5 хувийг эзлэх Улсын тусгай хамгаалалтай 56 газар ажиллаж байна. Байгаль орчны төр, олон нийтийн байгууллагын тогтолцоо, сүлжээ бүрэлдлээ.

Байгаль, орчин, ан амьтан хамгаалах асуудлаар Монгол улс олон улсын хэмжээнд ч зарчимч идэвхтэй бодлого баримталдаг. НҮБ-ийн Ерөнхий ассамблей 1962 онд Монгол тэргүүтэй хэдэн улсын санаачлан оруулсан эдийн засгийн хөгжил, байгаль орчин тогтоолын төслийг баталсаны дотор ан амьтны баялгийг хамгаалах асуудал чухал байр эзэлдэг. НҮБ-ийн ‘Байгаль орчин, хөгжил’ олон улсын бага хуралд 1993 онд Монгол улсын засгийн газрын Ерөнхий сайд оролцож монгол орны нутаг дэвсгэрийн 30 хувийг тусгай хамгаалалтай газар болгож, Монгол улсыг олон улсын онцгой хамгаалалтай дэлхийн шим мандлын тусгай бүс газар болгохоор санал оруулсан билээ. Монгол улс Олон улсын хэмжээнд ховор ургамал, амьтныг хил дамнуулан худалдаалах конвенци (ХЗОХК), Нүүдэлдэг зүйлийн конвенци (НЗК), Биологийн элдэв хэлбэрийн конвенци (CBD) болон бусад конвенцид гишүүнээр элслээ. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн 1990 оноос хойш Монголын нийгэм, эдийн засгийн бүтэц өөрчлөгдсөнтэй уялдан ан амьтны баялаг, элдэв хэлбэрийг хамгаалахад ихээхэн бэрхшээл тохиолдох болов. Олон хөхтөн амьтны нөөц сүүлийн хэдэн жилийн дотор хууль бус агнуурын нөлөөгөөр эрс багаслаа. Монголын хөхтөн амьтны элдэв хэлбэр, нөөц баялгийг хамгаалах асуудал эрс хурц тавигдах боллоо.

Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан семинараар судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд, их сургуулиуд, байгаль орчныг хамгаалах засгийн газрын хэрэгжүүлэх агентлагууд, төрийн бус байгууллагууд оролцож, Монгол орны бүх хөхтөн амьтдын мэдээлэл хуримтлагдсан үр дүнгээс Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс болон ховордож буй зүйлүүдэд хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэлийг гаргахад хүргэсэн юм. Монгол орны хөхтөн амьтанд нүүрлэж байгаа дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд устах эрсдэл, ховордлын шалтгааныг өргөн цар хүрээтэй авч үзсэн. Монгол улсын өмнөх улаан номноос нэлээд өөр бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ‘ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуур’-аар (IUCN, 2001) Монголын хөхтөн амьтны хамгааллын статусыг үнэлэн бусад бүс нутагтай эхний удаа харьцуулж байна. Мөн Монгол орны биологийн олон янз байдлыг хамгаалахаар хийгдсэн ажил олон байдаг бөгөөд энэ ажил нь Монголын хөхтөн амьтны статусыг өөрчлөн сайжруулахад суурь болж, цаашид Монгол орны бүх сээр нуруутан амьтдыг хамруулна гэдэгт найдаж байна.

*Профессор С. Дуламцэрэн  
Шинжлэх Ухааны Академи*



## ТАЛАРХАЛ

Энэ номыг Монголын хөхтөн судлаачдын биет оролцоо туслалцаа, дэмжлэггүйгээр бүтээх боломжгүй байсан.

Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс ном нь Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн хуралд оролцсон судлаачдын хамтын бүтээл юм. Энэ ажилд хувь нэмрээ оруулсан бүх оролцогчдод баярласан талархсанаа илэрхийлье. Үүнд (үсгийн дарааллаар): Д. Авирмэд, Я. Адъяа, Яд. Адъяа, С. Амгаланбаатар, Ж. Ариунболд, J. E. M. Baillie, Д. Базардорж, Н. Батсайхан, С. Баярхүү, А. Болд, А. Bräunlich, В. Бүүвэйбаатар, E. L. Clark, В. Collen, О. Ганбаатар, П. Ганхуяг, С. Дорждэрэм, Д. Доржготов, С. Дуламцэрэн, Ж. Жаргал, S. R. V. King, Д. Лхагвасүрэн, Н. Мiх, Ж. Мөнхбат, Ц. Мөнхзул, О. Мөнхтогтох, Б. Мөнхтуяа, Д. Нандинцэцэг, Б. Нямбаяр, Ё. Онон, М. Отгонбаатар, Ш. Оюунчимэг, Д. Өсөхжаргал, Р. Самъяа, С. Сүхтулга, С. Сүхчулуун, С. Сэргэлэн, Х. Тунгалагтуяа, L. Simpson, M. Stubbe, D. Tinnin, С. Цогт, Б. Чимэддорж, С. Шар. Хурлын зарим хэсэгт оролцсон дараах хүмүүс Ж. Батболд, Б. Баяртогтох, Г. Ганзориг, D. Craighead, Ц. Дамдин, О. Доржраа, Д. Доржготов, А. Fine, Б. Лхагвасүрэн, Б. Мөнхцог, Г. Наранбаатар, К. Olson, Э. Оюунгэрэл, Л. Пүрэвсүрэн, Н. Reynolds, S. Ross, Ц. Туяа, М. Цогбадрах, Д. Цэнджав, О. Шагдарсүрэн нарт талархалаа илэрхийлье.

J. E. M. Baillie, E. L. Clark, В. Collen, Ж. Жаргал, S. R. V. King, Ж. Мөнхбат, Ш. Оюунчимэг, L. Simpson нар Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн семинарыг гурван өдөр зохион байгуулав. Проф. Р. Самъяа удирдах зөвлөлийн уулзалтуудыг удирдсан. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагууд, Монгол улсын Академийн хүрээлэнгүүд, Монголын Засгийн Газрын төлөөлөгч Байгаль Орчны Яам оролцсон бөгөөд хурлын явц үйл ажиллагаанд байнгын туслалцаа үзүүлсэн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд талархсанаа илэрхийлье. С. Дуламцэрэн, Н. Оюундарь, Б. Баяртогтох, Б. Лхагвасүрэн, Б. Чимэд-Очир, Б. Цэцэг, S. R. V. King, Б. Нямбаяр, Я. Адъяа, Н. Батсайхан нар удирдах зөвлөлд ажиллав. Семинар зохион байгуулах үеийн үйлчилгээг хариуцан гүйцэтгэсэн Хустайн Байгалийн Цогцолборт Газрын хамт олонд талархсанаа илэрхийлье.

Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс номыг хянан тохиолдуулсан болон энэ номонд орсон холбогдох мэдээллийг өгсөн: Яд. Адъяа, Л. Амгалан, С. Амгаланбаатар, J. E. M. Baillie, Д. Базардорж, Ж. Батболд, Н. Батсайхан, J. Berger, А. Болд, А. Bräunlich, О. Ганбаатар, С. Davids, Б. Доржготов, С. Дуламцэрэн, С. Feh, J. Hare, В. Huffman, Ж. Жаргал, Р. Kaczensky, S. R. V. King, Б. Лхагвасүрэн, Д. Лхагвасүрэн, Б. Мижиддорж, Н. Мiх, О. Мөнхтогтох, К. Olson, Н. Reynolds, Р. Самъяа, Г. Шенброт, L. Simpson, А. Stubbe, М. Stubbe, Х. Тунгалагтуяа, Д. Цэнджав, С. Шар, С. Walzer, Т. Wacher нарт талархалаа илэрхийлье. Мөн ангилал зүйн болон таксономын талаар үнэтэй зөвлөгөө өгч хянасан David Mallon, Richard Reading, David Tinnin, Samuel Turvey нарт онцгойлон талархал илэрхийлье.

Энэ төслийн бүх үе шатны гол арга хэмжээг чадварлаг зохион байгуулсан Шаравын Оюунчимэгт талархалаа илэрхийлье.

Энэ ном бол Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийн үр дүн бөгөөд Дэлхийн Банкны үүсгэл санаачлага, санхүүгийн дэмжлэгтэйгээр Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН) (Монгол улсад Степ Форвард Программ төлөөлж байгаа) болон Монгол Улсын Их Сургууль, Монголын Шинжлэх Ухааны Академи, Байгаль Орчны Яам, Дэлхийн Байгаль Хамгааллын Холбоо (ДБХХ), бусад орон нутгийн болон олон улсын олон байгууллагатай хамтарч хэрэгжүүлсэн. Иймд бид Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төсөлд чухал хувь нэмрээ оруулсан дараах байгууллагуудад тусгайлан талархалаа илэрхийлэхийг хүсч байна.

**Бээжин дэх Нидерланд улсын элчин сайдын яамны санхүүжилтээр Дэлхийн Банк** нь Монголын биологийн төрөл зүйлийн мэдээллийн сан төслийг үүсгэн санаачилсан төдийгүй Монгол улсын хөхтөн амьтны Улаан дансыг хэвлэн нийтлэх боломжийг бүрдүүлэн санхүүгийн тусламж үзүүлсэн юм. Мөн түүнчлэн энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад удирдамж, зөвлөмж өгч байсан Tony Whitten-д гүн талархалаа илэрхийлж байна.

**Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (ДБХХ)** уг номыг туурвих болон холбогдох мэдээ материалыг эмхэтгэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн юм. ДБХХ нь өөрсдийн гаргасан ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуурыг ашиглуулж, техникийн туслалцаа болон мэдээллээр ханган мэргэжилтнүүдээ оролцуулсанд тус байгууллагад талархалаа илэрхийлье. ДБХХ-ны Дэлхийн Хөхтөн Амьтдын Үнэлгээний багийнханд (ДХАҮ) хөхтөн амьтдын тархацын анхдагч зургаар хангасан явдалд талархсанаа илэрхийлье.

**Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН)** Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийн хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулсан Jonathan Baillie (Төслийн удирдагч), Emma Clark (Төслийн зохицуулагч), Joanne Oscock (Төслийн зохицуулагч), Ben Collen (техникийн зөвлөгч) нар бүгд ЛАСН-ийн ажилтнууд болно. Түүнчлэн уг төслийг удирдан чиглүүлж үнэтэй хувь нэмрээ оруулсан ЛАСН-ийн Байгаль хамгааллын хөтөлбөрийн захирал Glyn Davies-д талархаж байгаагаа илэрхийлье.

**Степ Форвард Программ (СФП)** нь Их Британий Дарвины Санаачлага Байгууллагын (ИБ ДСБ) санхүүжилтээр Монголд 2003 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй хөтөлбөр юм. Энэхүү байгууллагын үйл ажиллагааг Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэгээс удирдан зохион байгуулдаг бөгөөд энэ төсөл нь Монгол Улсын Их Сургуультай хамтран ажилладаг. Энэ төслийн бүх ажилтнуудад, ялангуяа зөвлөгөө өгч, удирдан чиглүүлж байсан Sarah King-д болон мэдээллийн эх үүсвэрийг эмхэтгэхэд өөрийн зүтгэл гаргасан Жавзансүрэнгийн Мөнхбат, төслийн үйл ажиллагааг чадварлаг зохион байгуулсан Шаравын Оюунчимэг, ажлын хэсгийн уулзалтыг удирдан зохион байгуулахад чухал үүрэг гүйцэтгэж орчуулга хийсэн Жамсранжавын Жаргал, ажлын хэсэгт тодорхой үүрэг гүйцэтгэсэн Lucy Simpson нарт талархаж байгаагаа илэрхийлье.

**Монгол Улсын Их Сургууль (МУИС)** нь хурал уулзалтыг удирдан зохион байгуулж, Степ Форвард Программ болон Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийг хэрэгжүүлж буй байгууллага юм. Монгол Улсын Их Сургууль энэ төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцааг харамгүй үзүүлж байгаа билээ. Уг төслийг удирдан чиглүүлэн, дэмжиж тусалсан Равчигийн Самъяа, Амьтан судлалын тэнхимийн бүх

хөхтөн судлаачдад, ялангуяа Нямсүрэнгийн Батсайхан, Сэтэвийн Шар, Осорын Шагдарсүрэн нарт тусгайлан талархалаа илэрхийлье.

**Монголын Шинжлэх Ухааны Академийн (ШУА)** судлаачид семинарын явцад идэвхтэй оролцож, мэдлэгээ хуваалцан энэ номыг гаргахад хувь нэмрээ оруулсанд талархал илэрхийлж байна. Энэ төсөлд мэдлэг, ур чадвар, хувь нэмрээ оруулсан биологичдод, ялангуяа семинарт оролцогч нарт талархалаа илэрхийлэхийн дашрамд Сандуйн Дуламцэрэн, Бадамжавын Лхагвасүрэн, Цэцэг Балжинова нарт талархалаа онцлон илэрхийлье.

**Байгаль Орчны Яам (БОЯ)** төслийн хэрэгжилт болон үйл ажиллагааны үндсэн зорилтыг дэмжиж, удирдах зөвлөлийн хуралд оролцож байсанд талархсанаа илэрхийлье. Мөн семинарын үйл ажиллагаанд Байгаль Орчны Яамыг төлөөлөн оролцсон Янсанжавын Адъяа, Наваан-Юндэнгийн Оюундарь, Балдангийн Доржготов, Цэрэндашийн Дамдин нарт гүн талархалаа илэрхийлье.



## ТАНИЛЦУУЛГА

Газрын тогтоцоороо олон хэв шинжтэй, өргөн уудам Монгол оронд хөхтөн амьтад эртнээс баялаг байсаар иржээ. Харин сүүлийн 20 жил монголын нийгэм, эдийн засаг эрс өөрчлөгдөн шинэчлэгдсэн энэ хугацаанд аргаль хонь (*Ovis ammon*), халиун буга (*Cervus elaphus*), Монгол тарвага (*Marmota sibirica*) зэрэг олон хөхтөн амьтдын тоо толгой хурдацтайгаар цөөрсөн байна. Улаан данс ном гаргахаас өмнө хөхтөн амьтны тоо толгой цөөрч байгааг хэдхэн зүйлд л тодорхой байсны зэрэгцээ Монгол орны нийт хөхтөн амьтдын хамгааллын статус огт тодорхойгүй байлаа.

Улаан данс номонд Монгол оронд байгаа бүх уугуул хөхтөн амьтны статусыг Монгол орны хэмжээнд үнэлэн гаргасан бөгөөд зүйл тус бүрийн дэлхийн болон бүс нутгийн тархац, хамгаалагдсан байдал, ховордлын гол шалтгаан зэрэг мэдээллийг хамтатган багтаасан юм. Зүйлийн үнэлээг хийхдээ тоон мэдээлэл ашиглан тухайн зүйлийн устах эрсдэлийг Анхааралд өртөхөөргүй, Ховордож болзошгүй, Эмзэг, Устаж болзошгүй, Устаж байгаа, Байгальд устсан, Устсан зэргээр ангилдаг 'ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуур'-ыг ашигласан (IUCN, 2001). Энэ үнэлгээг Монгол орны хөхтөн амьтдыг судалдаг дэлхийн нэртэй эрдэмтэд оролцсон 70 гаруй судлаачид 2005 оны аравдугаар сарын 31-ээс арваннэгдүгээр сарын 4-ний хооронд зохион байгуулагдсан Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан семинарын үед хийсэн юм.

Энэ номонд Монгол орны ховордож байгаа болон элбэг хөхтөн амьтад бүгд орсон бөгөөд тус орны хөхтөн амьтны бүх зүйлийн статусыг тодорхойлон үнэлсэн билээ. Монгол орноос олдсон бүх хөхтөн амьтны талаар гол мэдээлэл агуулсан нэгэн лавлах бичиг болсон. Эмзэг, устаж байгаа, устаж болзошгүй гэсэн ангилалд орсон зүйлүүд нь Улаан дансны ховордож устах эрсдэлтэй зүйлүүд юм.

Улаан данс номыг гаргахад оролцсон мэргэжилтэнүүд нь Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн нэгэн бүрдэл хэсэг болох хөхтөн амьтны мэдээллийн санг баяжуулахад тусалсан юм. Зүйлийн тархац, экологи, амьдрах орчны байдал, ховордлын шалтгаан, хамгааллын арга хэмжээ зэргийг багтаасан энэ мэдээллийн санг Монгол улсын их сургуулийн Амьтан судлалын тэнхимээс авч болно. Мэдээллийн санд Монгол улсын бүх загасны мэдээлэл агуулагддаг бөгөөд ойрын ирээдүйд тус мэдээллийн санд Монгол орны бүх сээр нуруутан амьтдын мэдээллийг оруулах болно. Хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэлд ховордож байгаа бүх хөхтөн амьтны зүйлийн мэдээллийг нарийвчлан тусгаж, цаашдын төлөвлөгөөг оруулсан билээ. Энэ хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл нь тусгайлан хэвлэгдэж байгаа бөгөөд электрон хувилбарыг Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэгийн номын сангаар дамжуулан авч болно (<http://library.zsl.org>), [www.regionalredlist.com](http://www.regionalredlist.com).

Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс ном нь байгаль хамгааллын нөхцөл байдал хойшид сайжирч байгаа эсэхийг үнэлэх анхны үндэс суурь болсноороо Монголын байгаль хамгаалагчдад чухал ач холбогдолтой юм. Энэ номонд ховордож байгаа хөхтөн амьтдын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг эмхэтгэн гаргасан бөгөөд шийдвэр гаргагчдад чухал ач холбогдолтой төдийгүй тухайн зүйлийг хамгаалах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах, нэн тэргүүнд тодорхойлон гаргаж ирэхэд хамгийн хэрэгцээтэй мэдээллийг агуулсан болно.

Энэхүү Улаан данс нь сүүлийн үед нэлээд хэмжээний зүйл эрсдэн ховордож байгааг харуулсан. Улаан данс гарсан явдал нь байгаль хамгааллын үнэлгээ, урт хугацааны байнгын тандан судалгаа хийхийн ач холбогдлыг харуулж чадсан төдийгүй зүйлүүд мэдэгдэлгүйгээр устахаас сэргийлж чадах ач холбогдолтой болохыг харуулдаг.

Улаан данс нь бэлчээр талхлагдлаар бий болсон орчны доройтол болон хэт ашиглалт (худалдаа арилжааны зориулалтай) гэх мэт Монгол орны хөхтөн амьтдын ховордлын гол шалтгаануудыг анхаарч үзэх ач холбогдлыг харуулсан. Эдгээр ховордлын гол шалтгаанууд хууль эрх зүйн орчин, эдийн засгийн бодлого, бүх нийтийн боловсролоор дамжуулан арилгах боломжтой юм. Цаг уурын өөрчлөлтөөс бий болсон хөхтөн амьтны ховордлын шалтгааны үр дагаврыг арилгах нь нэлээд төвөгтэй юм. Эцэст нь хэлэхэд Улаан данс нь одоо байгаа мэдлэгийн түвшнийг тодорхойлсноороо цаашид нэн тэргүүнд ямар судалгаа шаардлагатай болохыг тодорхойлоход тус дөхөм болно. Маш бага судлагдсан атлаа сонирхолтой бүлгийн хөхтөн амьтныг хамгаалан судлах ажлууд хойшид ихээхэн дэлгэрэх анхны алхамыг энэхүү ном бүрдүүлсэн юм.

## **ДБХХ–НЫ УЛААН ДАНСНЫ АНГИЛАЛ БА ШАЛГУУРЫГ АШИГЛАН БҮС НУТГИЙН ТҮВШИНД ҮНЭЛЭХ ЗААВАРЧИЛГАА**

Улаан данс нь ховордож буй зүйлүүдийг онцлон анхаардаг бөгөөд бараг 60 жилийн түүхтэй бичиг баримт ном (Baillie, Groombridge, 1996). Эдгээр данс ангилал зүйн хувьд өөр хоорондоо ялгаатай зүйлүүдийн устах эрсдэлийг үнэлэх чухал арга хэрэгсэл болсон төдийгүй ховордож буй зүйлд тавих анхаарлыг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалахад нэн түрүүнд хийх шаардлагатай ажлыг тодорхойлох анхны арга хэмжээ болдог (Lamogeuх нар, 2003). Зүйлийн хамгааллын зэргийг тодорхойлдог анхны харьцангуй хийсвэр арга зүйг 1994 онд зүйлийн дэлхийн хэмжээнд устах эрсдэлийг ангилан стандартчилж, тоон шалгуурт оруулсан илүү бодитой аргаар сольсон байна (Mace, 1994). Шинэ шалгуурыг анх удаа 1996 оны ‘ДБХХ-ны Улаан дансны ховордож буй зүйлүүд’ номонд ашигласан байна (Baillie, Groombridge, 1996). ‘ДБХХ-ны Улаан дансны ангилал ба шалгуур’-ыг (IUCN, 2001) олон улсын стандартыг хангасан гэдгийг хүлээн зөвшөөрч дэлхийн олон орнууд ба янз бүрийн байгууллагууд нийтээрээ ашиглаж байна.

Монгол улсын хөхтөн амьтны Улаан дансыг Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн семинараар ‘ДБХХ-ны Улаан дансны бүс нутгийн түвшний шалгуурын удирдамж: 3.0 Хувилбар’-ын дагуу хийж гүйцэтгэсэн (IUCN, 2003). Энэ удирдамжаар бүс нутгийн хэмжээнд устах эрсдэлтэй зүйлийг үнэлдэг бөгөөд дэлхийн хэмжээний үнэлгээнд тусгагдаагүй заалтуудыг оруулсан байдаг. Жишээ нь: бүс нутгийн хэмжээнд улс хооронд нүүдэллэдэг зүйлийг, эсвэл зөвхөн нэг оронд хязгаарлагдмал популяцитай боловч тухайн популяцийн тоо толгой нь өөр орноос нүүдэллэн ирэх бодгалиудаас хамааралтай зүйлийг үнэлж болдог. Бүс нутгийн устах эрсдэлийн үнэн зөв үнэлгээг гаргахад удирдамж нь хоёр чухал онцлогтой байдаг. Нэгдүгээрт: Бүс нутгийн хэмжээнд устсан (БНУ) болон Үнэлэх боломжгүй (ҮБ) (Хүснэгт 1) гэсэн 2 ангилал нэмэгдэж орж ирдэг. Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн ангилал дэлхийн хэмжээнд тархсан боловч тухайн бүс нутагт олдохгүй болсон зүйлээр илэрхийлэгдэнэ. Үнэлэх боломжгүй гэсэн ангилал үнэлгээ хийхэд боломжгүй зүйлээр илэрхийлэгдэнэ. Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийн семинараар тухайн зүйлийн Монголын популяци нь дэлхийн популяцийн нэгээс бага хувиас тогтож, бүс нутгийн тархац нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн нэгээс бага хувьд тохиолдож байгаа бол үнэлэх боломжгүй гэсэн ангилалд оруулсан. Хоёрдугаарт: удирдамж нь хоёр шатны үйл явцаас бүрдэнэ. ‘ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуур’-аар (IUCN, 2001) эхлээд тухайн популяцийг дэлхийн популяцийн төлөөлөл гэж үзэн бүс нутгийн популяцийн мэдээлэлд үнэлгээ хийдэг (Хавсралт I-ээс нарийвчлан харна уу). Тухайн популяцид бүс нутгийн гадна байгаа популяци нөлөө үзүүлж байвал үнэлгээг өөрчилдөг. Жишээ нь бүс нутгийн хэмжээнд ховордож байгаа тухайн зүйлийн популяци нь хөрш зэргэлдээ орноос нүүдэллэн ирдэг бодгалиудаар тэтгэгддэг бол тухайн популяцийн бүс нутгийн устах эрсдэл буурах тул үнэлгээ буурна. Харин бүс нутгийн тоо толгой буурч, тухайн популяци хөрш нутгийн популяцийн бодгалиудаас сэлбэгдэх боломж үгүй бол үнэлгээ нь ховорлын дээд ангилалд шилжин орно. Хэрэв хөрш зэргэлдээх улсаас популяцид нөлөөлж буй гэсэн мэдээлэл байхгүй бол тухайн үнэлгээнд ямарч өөрчлөлт хийгдэхгүй (IUCN, 2003 нарийвчлан харна уу). Ингэснээр тухайн зүйлийн Улаан дансны ангиллыг тэр бүс нутагт илүү бодитой тодорхойлж чадна.

Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийн семинараар хөхтөн амьтдын зүйлийн бүс нутгийн үнэлгээг хийхдээ үнэлгээг ахиулах, бууруулах тохиолдол гараагүй. Учир нь хөрш зэргэлдээх орны популяциас бодгалиудын нүүдэллэн ирдэг талаарх нотолгоо бага байсан бөгөөд хөрш зэргэлдээх орны популяцийн нөлөөлж байгаа эсэх нь тодорхойгүй байгааг үндэслэсэн билээ.

Хүснэгт 1. Улаан дансанд ашигладаг ангиллын тодорхойлолт (IUCN, 2001 болон 2003).

<b>Устсан (EX)</b>	Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг Устсан гэсэн ангиллаар үнэлдэг. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчныг тохиромжтой цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд, тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг Устсан гэсэн ангилд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
<b>Байгальд устсан (EW)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржүүлж байгаа, эсвэл тухайн зүйлийн популяцийг (популяциудыг) түүхэн тархац нутгийн гадна байгалийн нөхцөлд нь байлгаж байгаа бол Байгальд устсан гэсэн ангилалд оруулдаг. Тухайн ангилал зүйн нэгжийн бодгаль байж болох амьдрах орчин тохиромжтой цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд, мөн тухайн зүйлийн уугуул нутагт судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд Байгальд устсан гэсэн ангилд оруулна. Судалгааг тухайн зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
<b>Бүс нутгийн хэмжээнд устсан (RE)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийн хамгийн сүүлийн бодгаль үхсэн, эсвэл үзэгдэхээ байсан бөгөөд дахин энэ нутагт шилжин ирэх боломжгүй тохиолдолд Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн ангилалд оруулдаг. Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн ангилалд тухайн зүйлийг оруулахаас өмнө цаг хугацаанд ерөнхий дүрэм тавих боломжгүй. Энэ нь зүйлийн талаарх судалгаа хэр хийгдсэнээс хамаарах болно.
<b>Устаж байгаа (CR)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-гаас Е хүртэлх аль нэг шалгуураар Устаж байгаа гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл туйлын их байгааг илтгэн Устаж байгаа гэсэн ангилалд хамааруулна.
<b>Устаж болзошгүй (EN)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-гаас Е хүртэлх аль нэг шалгуураар Устаж болзошгүй гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл маш их байгааг илтгэн Устаж болзошгүй гэсэн ангилалд хамааруулна.
<b>Эмзэг (VU)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-гаас Е хүртэлх аль нэг шалгуураар Эмзэг гэсэн ангиллаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгааг илтгэн Эмзэг гэсэн ангилалд хамааруулна.
<b>Ховордож болзошгүй (NT)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийг А-гаас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг гэсэн ангиллаар үнэлэх боломжгүй боловч ойрын ирээдүйд устаж, ховордож байгааг илтгэсэн дээрх ангиллын аль нэгрүү шилжин орж болзошгүй зүйлийг Ховордож болзошгүй гэсэн ангилалд хамааруулна.
<b>Анхааралд өртөхөөргүй (LC)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийг А-гаас Е хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож болзошгүй зэрэг ангиллын аль нэгээр үнэлэх боломжгүй байгаа тул Анхааралд өртөхөөргүй зүйл гэсэн ангилалд хамааруулна. Өргөн тархац нутагтай, элбэг зүйл энэ ангилалд хамаарна.
<b>Мэдээлэл дутмаг (DD)</b>	Тухайн ангилал зүйн нэгжийн популяцийн төлөв байдал болон тархацыг үндэслэн устах эрсдэлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээлэл хангалтгүй байгаа нөхцөлд Мэдээлэл дутмаг гэсэн ангилалд хамааруулна. Тухайн зүйлийн элбэгшил, тархацын талаар мэдээлэл дутмаг байж болно. Мэдээлэл дутмаг гэсэн ангилал нь устах, ховордох эрсдэлийг илэрхийлсэн ангилал биш юм. Зүйлийг энэ ангилалд оруулах нь тухайн зүйлийн талаар илүү мэдээлэл хэрэгтэй байгааг илэрхийлдэг төдийгүй тухайн зүйлийн талаар ирээдүйд судалгаа хийгдэж, тухайн судалгаа нь тэр зүйлийг устах эрсдэлтэйг нотлох боломжтой байж болно. Байгаа мэдээллийг ашигтайгаар хэрэглэх нь чухал байдаг. Тухайн зүйлийг Мэдээлэл дутмаг мөн устах эрсдэлтэйг илэрхийлсэн ангиллын алинд нь хамааруулахаа маш анхааралтай шийдэх хэрэгтэй. Хэрэв тухайн зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал, тухайн зүйлийг олон жилийн тэртээд судалсан бол тэр зүйлийг ховордох, устах эрсдэлтэй ангилалд оруулах нь зайлшгүй зөв зүйтэй шийдвэр юм.
<b>Үнэлэх боломжгүй (NA)</b>	Бүс нутгийн хэмжээнд үнэлэх шаардлага хангаагүй ангилал зүйн нэгжийг Үнэлэх боломжгүй гэсэн ангилалд хамааруулна.

## АРГА АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКИЙН ТЭМДЭГЛЭГЭЭ

*Нэр томъёо, ангилбар*

Энэ номонд орсон Монгол улсын хөхтөн амьтдын зүйлийн жагсаалт нь тус орны болон олон улсын Хөхтөн судлаачдын нэлээд олон удаагийн уулзалтын үр дүнд гаргасан. Улаанбаатарт болсон эхний уулзалтаар Дуламцэрэн (1968), Mallon (1985), Wilson, Reeder (1993), Tinnin нар, (2002) зэрэг бүтээлүүд болон ДБХХ-ны дэлхийн хөхтөн амьтны үнэлгээний (IUCN-GMA, хийгдэж байгаа) жагсаалтуудыг нэгтгэн хянаж хөхтөн амьтны зүйлийн жагсаалтын анхны хувилбарыг гаргасан юм. Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийн семинарын үед яригдсан ангилал зүйн маргаантай асуудлыг профессор М. Stubbe тэргүүтэй 20 судлаачид хамтарч шийдвэрлэсэн. Семинарын дараагаар дахин хуралдаж Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн болон Улаан дансны баримтлах зүйлийн жагсаалтыг эцсийн байдлаар батлан гаргасан.

‘ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуур’-ыг (IUCN, 2001) зөвхөн байгальд зэрлэг байдлаараа уугуул нутагтаа байгаа болон түүхэн тархац нутагт нь сэргээн нутагшуулж байгаа популяцид (сэргээн нутагшуулсан Тахь адуу гэх мэт) хэрэглэсэн. Усны булга *Mustela vison* Schreber, 1777; Бор харх *Rattus norvegicus* (Berkenhout, 1769); Заарт харх *Ondatra zibethicus* (Linnaeus, 1766); Гэрийн хулгана *Mus musculus* Linnaeus, 1758 зэрэг Монгол оронд шинээр нутагшиж байгаа дөрвөн зүйл хөхтөн амьтныг Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс номонд оруулаагүй билээ.

Мазаалай баавгайн *Ursus arctos gobiensis* Sokolov, Orlov, 1992 ангилал зүйн статусыг улам тодорхой болгох шаардлагатай байсан хэдий ч тухайн зүйлийг энэ номонд Хүрэн баавгайн *Ursus arctos* Linnaeus, 1758 биеэ даасан салбар зүйл гэж үзэн үнэлгээ хийсэн. Ангилал зүйн хувьд шийдэгдээгүй байдлыг үл харгалзан энэ салбар зүйлийг Монгол оронд хамгааллын чухал ач холбогдолтой, тодорхой зүйл гэж үнэлсэн. Oakenfull нарын (2000) генетик судалгааны саяхны мэдээг харахад Тахь адуу нь адуутай үржилд орж байсан гэсэн мэдээлэл байдаг ба адуутай удам төрлөөрөө ойр холбоотой боловч түүнийг биеэ даасан зүйл гэж үзсэн байна. Энэ номонд зөвхөн байгальд зэрлэгшиж байгаа тахь адууны популяцид үнэлгээ хийсэн болохоор тахь адууг *Equus ferus przewalskii* (Groves, 1986) гэсэн латин нэрээр оруулсан. Хавтгай тэмээ болон гэрийн тэмээтэй популяциудын хооронд генетик солилцоо байдаг хэдий ч орчин үеийн генетик судалгаа хавтгай тэмээ нь биеэ даасан зүйл байж болохыг харуулж байна (Нан нар, 2002). Улаан данс болон түүнтэй холбоотой баримтанд хавтгай тэмээг *Camelus bactrianus ferus* Przewalski, 1878 гэсэн латин нэрээр оруулсан бөгөөд түүний зэрлэг популяцид үнэлгээ хийснийг илэрхийлнэ. Улаан дансанд орсон хөхтөн амьтны зарим зүйлийн хувьд Монгол оронд тохиолдох нэг болон хэд хэдэн тодорхой салбар зүйлийг оруулсан. Жишээ нь Монгол бөхөн *Saiga tatarica mongolica* Bannikov, 1946 гэсэн салбар зүйлийг Улаан дансанд оруулсан юм. Дээр өгүүлсэн зүйлүүдээс бусад тохиолдолд үнэлгээг зүйлийн түвшинд хийсэн.

Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн семинараар баталсан зүйлүүдийг буюу 2005 оны байдлаар Монгол оронд тохиолдож байсан зүйлүүдийг Монгол улсын хөхтөн амьтны улаан данс болон түүнтэй холбоотой баримтанд оруулсан

болно (Хавсралт II, Жагсаалт 1). Семинарын дараагаар Монголд тохиолдож болох боломжит зүйлийг тэдгээрийн тархац нь тэлсэн, хилийн ойролцоо тохиолдсон гэсэн мэдээлэл дээр үндэслэн нэмж оруулав. Монголд тохиолдож болох эдгээр зүйлүүдийг семинарын дараа Жагсаалт 1-д нэмж оруулан (+) нэмэх тэмдэгээр тэмдэглэсэн бөгөөд уг тэмдэг бүхий зүйлүүдэд семинарын үеэр үнэлгээ хийгээгүй болно. Монгол оронд тохиолдох боломжтой зүйлүүдийг Монгол орноос илрүүлээгүй тул тухайн зүйл олдсон нотолгоо бий болтол тэр зүйлийг боломжит зүйлийн жагсаалтанд оруулах болно (Хавсралт II, Жагсаалт 2).

### *Бүс нутгийн тархац*

Зүйл тус бүрийн тархацыг Монгол орны тодорхой бүс нутгаар ялган зааж гаргав. Ингэхдээ нэгэнт хэвшсэн Монгол улсын физик газар зүйн зургийг үндэслэн Цэгмид (1969), Грубов (1982), Рачковская (1993), Банников (1954) нарын ургамал, хөхтөн амьтны газар зүйн мужлалын зургаар сэлбэн баяжуулж, Н. Батсайхан (хэвлэгдээгүй мэдээ) цэгцлэн хянасан билээ (Зураг 1). Энэ 16 бүсэд хуваасан зураг хөхтөн амьтны тархалтыг ургамлын газарзүйтэй холбон урьдынхаас арай тод томруун харуулна гэж үзлээ.



Зураг 1. Монгол орны Хөхтөн амьтдын тархацын зургийг тайлбарлахад ашиглах Монгол орны газар зүйн мужууд (Цэгмид, 1969; Грубов, 1982). 1 = Хөвсгөлийн уулс, 2 = Хэнтий нуруу, 3 = Хангайн нуруу, 4 = Монгол Дагуурын хээр, 5 = Их хянганы уулс, 6 = Монгол Алтайн нуруу, 7 = Төв халхын хээр, 8 = Дорнод Монгол, 9 = Их нууруудын хотгор, 10 = Олон нуурын хөндий, 11 = Умард говь, 12 = Дорнод говь, 13 = Говь Алтай нуруу, 14 = Зүүнгарын говь цөл, 15 = Алтайн өвөр говь цөл, 16 = Алашань говь цөл.

### *Зүйлийн тархацын зураг*

Монголын хөхтөн амьтны одоогийн тархацын дижитал зургийг ДБХХ-ны Дэлхийн Хөхтөн Амьтдын Үнэлгээний багийнхнаас (IUCN-GMA, хийгдэж байгаа) авсан. Тэр тархацын зургийг Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн семинарт оролцогчид дахин хянасан юм. Тархацын зургийг өөрчилсөн шалтгааныг тэмдэглэн баримтжуулж, Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн санд оруулсан. Тархацын зурагт улсын хил орчмоор тархсан зүйлүүдийг оруулсан хэдий ч энэ мэдээллийг семинараар нарийвчлан тогтоох боломжгүй байсан тул зөвхөн өргөн тархацтай зүйлүүдийн тархцыг энэ зургаар үзүүлсэн болно. Тархацын зургийг семинараар сайжруулан, газрын зураг хийдэг ArcView 3.0 хувилбарын

компьютерийн программыг ашиглан зүйлийн баялаг, ховордож буй зүйлийн баялаг, бага судлагдсан зүйлийн нягтшил өндөр байгаа газрыг тогтоон гаргасан. Зүйл бүрийн тархацын зургийг Монгол улсын тусгай хамгаалалтай газрын зурагтай давхцуулан тухайн зүйлийн тархацын хэдэн хувь нь тусгай хамгаалалтай газар хамрагдаж байгааг гаргасан. Тусгай хамгаалалтай газрын зургийг ДБХХ-ны тусгай хамгаалалтай газрын менежментийн зургаан ангиллын дагуу хийгдсэн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Дэлхийн Байгаль Хамгаалах Хяналтын Төвийн Тусгай хамгаалалтай газрын дэлхийн мэдээллийн сангийн (<http://sea.unep-wcmc.org/wdpa/>) мэдээлэлд үндэслэн гаргасан. Дэлгэрэнгүй мэдээллийг ‘Тусгай хамгаалалтай газрын менежментийн ангиллын удирдамж’-аас авна уу (IUCN, 1994).

#### *Гар зураг*

Монгол улсын хөхтөн амьтны Улаан данс номонд орсон зүйл бүрийн гар зургийг Монгол улсын Байгалийн түүхийн музейн цуглуулга, болон Ognev (1948), Бобринский нар (1965), Corbet, Ovenden (1982), Görner, Hackethal (1988), Macdonald, Barret (1993), Шенброт нар (1995), Соколов нар (1996), Schober, Grimmberger (1998), Павлинов нар (2002) зэрэг бүтээлүүдээс ашиглав. Зургийг маш сайн зурахыг хичээсэн боловч зарим зүйлийн мэрэгч амьтдыг биетээр нь хараад хээрийн нөхцөлд тодорхойлоход ч хэцүү байдгийн нэгэн адил бэрхшээл зурах үед ч тохиолдож байв. Хөхтөн амьтдын илүү нарийн мэдээллийг Соколов, Орлов (1980) буюу Дуламцэрэн (1970) нарын тодорхойлох бичгүүдээс харна уу.



## ЗҮЙЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА

Wilson, Reeder нарын (1993) сүүлийн үеийн хянан цэгцэлсэн ангилал зүйг баримтлан Улаан дансны хөхтөн амьтдыг дараах загвараар бичлээ. Үүнд:

### **Зүйлийн нэр, зохиогч**

**Түгээмэл нэр** (Монгол, Англи)

**Монгол дахь салбар зүйл** (хэрэв байвал)

**Ижил нэр** (хэрэв байвал)

### **Олон улсын үнэлгээ** (олон улсад устах эрсдэлтэй)

Зүйл бүрийн дэлхийн популяцийн үнэлгээг гаргахдаа ДБХХ-ны '2004 оны ДБХХ-ны Улаан дансны ховордож буй зүйл' номонд орсон үнэлгээг шууд ашиглав (IUCN, 2004). Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийн семинараар одоогийн олон улсын үнэлгээнд өөрчлөлт оруулсан бол нэг дугираг хараар (●) тэмдэглэсэн. Хэрэв ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуурыг (IUCN, 2001) ашиглан зүйлд анх удаа үнэлгээ хийсэн болон ДБХХ-ны Улаан дансны зохиогчдын гаргасан үнэлгээний шийдвэрийг хүлээж байгаа зүйлийг хоёр дугариг хараар (●●) тэмдэглэсэн.

### **Бүс нутгийн үнэлгээ** (Монгол улсад устах эрсдэлтэй)

Монгол орны хөхтөн амьтдын бүс нутгийн үнэлгээг анх удаа 'ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуур: 3.1 Хувилбар' (IUCN, 2001) (Хүснэгт 1-ийн ангилал болон тодорхойлолтыг харна уу) болон 'ДБХХ-ны Улаан дансны Бүс нутгийн түвшний үнэлгээний удирдамж: 3.0 Хувилбар'-ын (IUCN, 2003) дагуу хийв. Хэрэв Монгол оронд эндемик зүйл байвал бүс нутгийн үнэлгээтэй олон улсын үнэлгээ ижил байна.

### **Үнэлгээний үндэслэл**

'ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуур'-ын (IUCN, 2001) үнэлгээг хэрэглэх үндэслэлийг зүйл тус бүрт Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан семинараар гаргасан. Энэ хэсгийг 'ДБХХ-ны Улаан дансны бүс нутгийн түвшний шалгуурын үнэлгээний удирдамж: 3.0 Хувилбар' (IUCN, 2003) болон Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сантай холбож унших хэрэгтэй.

### **Хамгаалсан байдал**

Монгол улсын хөхтөн амьтдыг хамгаалсан хуулиудад Монгол улсын холбогдох хуулиуд (Ан агнуурын тухай хууль, Амьтны аймгийн тухай хууль гэх мэт) болон олон улсын хуулиуд (Зэрлэг ургамал, амьтны ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенц (ХЗОХК): UNEP-WCMC (2006) харна уу) орно. Дээр дурдсан хуулиудад агнуурын хугацаа, гадаадын анчдад агнуулах хэмжээ, зөвшөөрөл зэргийг багтаасан. Зүйл тус бүрийн тархацын хэдэн хувь нь тусгай хамгаалалтай газар нутагт харъяалагдаж буйг тооцон гаргасан. Тусгай хамгаалалтай газарт байгаа бүх зүйлийг Монгол улсын тусгай хамгаалалтай газар нутгийн хуулиар хамгаалдаг.

### **Дэлхийн тархац**

ДБХХ-ны (2004) баримталж байгаа дэс маягаар баруунаас зүүн хүртлэх бүх улсын нэрийг жагсаасан байх ба нэмэлт тодорхойлолтыг зүйлийн мэдээлэлд оруулсан. Одоогийн тархац гэдэг ойлголтонд уугуул тархацынх нь гадна байгаа улс оронд

нутагшуулсан [нутагшуулсан] эсвэл бүс нутагтаа устсанаас дахин нутагшуулсныг [сэргээн нутагшуулсан] гэж тус тус тэмдэглэн оруулсан.

### **Бүс нутгийн тархац**


Зүйл тус бүрийн бүс нутгийн тархацыг өгүүлбэрээр тайлбарлаж Монгол орон дахь тархацын зураг дагалдуулсан. Тархацын зургийг гаргахдаа Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан семинарын явцад ДБХХ-ны Дэлхийн хөхтөн амьтны үнэлгээний зураг (IUCN-GMA, хийгдэж байгаа) дээр үндэслэн судалгааны хэрэглэхүүн, музейн цуглуулга, засгийн газрын болон байгаль орчинг хамгаалах байгууллагуудын баримт мэдээ, мэргэжилтнүүдийн ажиглалт зэрэг шинэ мэдээгээр нэмэн баяжуулсан. Тархацын зургийг сүүлийн үеийн мэдээллээр баяжуулж боломжоороо нарийвчлан хийсэн боловч нэлээд олон зүйлийн тархацын мэдээлэл дутмаг байсныг дурьдах нь зүйтэй. Цаашид судалгаа хийгдэх тусам тархацын зурагт өөрчлөлт орох болно. Тухайн зүйлийн Монгол орны гадна тархсан мэдээллийг шинэчлээгүй болно.

### **Ховордлын гол шалтгаан**

Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сан семинарт оролцогчдын тодорхойлсноор ховордлын гол шалтгаан, түүнийг бүрдүүлж буй хүчин зүйлийг нэгтгэн дүгнэв. Ховордлын шалтгааныг бүрдүүлж буй үйл явц нь нарийн төвөгтэй ба маш олон хүчин зүйлээр илэрсэн. Нарийвчилсан мэдээллийн Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангаас авах боломжтой юм.

## МОНГОЛЫН ХӨХТӨН АМЬТНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ


Монгол орны уугуул 128 зүйл хөхтөн амьтныг үнэлснээс 16 хувь нь бүс нутгийн хэмжээнд ховордлын ангилалд орсны 2 хувь нь Устаж байгаа (УБ), 11 хувь нь Устаж болзошгүй (УБо), 3 хувь нь Эмзэг (Э) (Зураг 2) ангилалд хамрагдаж байна. Ховордож болзошгүй (ХБ) гэсэн ангилалд 6 хувь нь орсон. Монгол орны хөхтөн амьтны 37 хувь нь Мэдээлэл дутмаг (МД) гэсэн ангилалд орж байна. Зөвхөн нэг зүйл шарнад цөөвөр (*Cioper alpinus*) Монгол оронд бүс нутгийн хэмжээнд устсан (БНУ) гэдгийг тогтоов.




Зураг 2. ДБХХ-ны Улаан дансны ангиллаар үнэлсэн нийт 128 хөхтөн амьтны бүс нутгийн хамгааллын төлөв байдлыг хувиар илэрхийлсэн диаграмм. БНУ = Бүс нутгийн хэмжээнд устсан, УБ = Устаж байгаа, УБо = Устаж болзошгүй, Э = Эмзэг, ХБ = Ховордож болзошгүй, АӨ = Анхааралд өртөхөөргүй, МД = Мэдээлэл дутмаг.

Ховордлын төлөв байдал нь Монгол орны хөхтний ангилал зүйн бүлгүүдээр ялгаатай байна (Зураг 3). Монгол орны тууртны (*Artiodactyla*, *Perissiodactyla*) зүйлийн ихэнх нь (11/14 буюу 79 хувь) бүс нутгийн хэмжээний ховордлын ангилалд орж, үлдсэн гурван зүйлийн хоёр нь ховордож болзошгүй гэсэн ангилалд орсон. Цоохор ирвэс (*Uncia uncia*), Ойн булга (*Martes zibellina*), Мазаалай баавгай (*Ursus arctos gobiensis*) зэрэг Монгол орны махан идэшт амьтдын 12 хувь нь ховордлын ангилалд орсон бөгөөд 22 хувь нь ховордож болзошгүй (ХБо), 36 хувь нь анхааралд өртөхөөргүй (АӨ) ангилалд орсон. Мэрэгчдийн 12 хувь нь мөн ховордлын ангилалд орж, ховордож болзошгүй (ХБо) ангилалд 2 хувь, мэдээлэл дутмаг (МД) ангилалд 45 хувь нь орж байна. Жижиг (мэрэгч биш) хөхтөн амьтны зүйлүүд (*Lagomorpha*, *Chiroptera*, *Erinaceomorpha*, *Soricomorpha*) ховордлын ангилалд ороогүй бөгөөд ихэнх буюу 43 хувь нь мэдээлэл дутмаг (МД) ангилалд орсон. Ийм үр дүн гарч байгаа нь жижиг хөхтөн амьтны судалгаа бага байгааг харуулж байна. Хойшид жижиг хөхтөн амьтны нарийвчилсан судалгаа хийвэл ховордлын ангилалд орох зүйлийн тоо ихсэх боломжтой юм.


### Туурган




### Махчтан



### Жижиг хөхтөн (мэрэгч биш)



### Мэрэгчтэн



**Зураг 3.** Монгол улсын хөхтөн амьтны ангилал зүйн 4 бүлгийг хамгааллын зэрэглэлээр харьцуулсан диаграмм. БНУ = Бүс нутгийн хэмжээнд устсан, УБ = Устаж байгаа, УБо = Устаж болзошгүй, Э = Эмзэг, ХБ = Ховордож болзошгүй, АӨ = Анхааралд өртөхөөргүй, МД = Мэдээлэл дутмаг.

Монгол орны хөхтөн амьтны 21 зүйл ховордлын ангилалд орж, 8 зүйл ховордож болзошгүй (ХБо) ангилалд орж байна (Хүснэгт 2). Нэлээд олон тохиолдолд эдгээр зүйлүүдийн салбар зүйл нь Төв Азид эндемик тул тухайн зүйлүүд нь хөхтөн амьтдын олон янз байдлын хамгаалалд чухал ач холбогдолтой юм. Бүс нутгийн хэмжээнд ховордсон Соотон алагдахай (*Euchoreutes naso*), Хулан адуу (*Equus hemionus*), Хавтгай тэмээ (*Camelus bactrianus ferus*), Татаар бөхөн (*Saiga tatarica*), Цоохор ирвэс (*Uncia uncia*) гэх мэт 12 зүйл дэлхийн хэмжээнд ховордсон болон ховордож болзошгүй (ХБо) ангилалд орсон.


Хүснэгт 2. Бүс нутгийн хэмжээнд ховордож байгаа (Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг) болон ховордож болзошгүй хөхтөн амьтад.

Устаж байгаа	Устаж болзошгүй	Эмзэг	Ховордож болзошгүй
Мазаалай баавгай <i>Ursus arctos gobiensis</i>	Монгол тарвага <i>Marmota sibirica</i>	Соотон алагдаахай <i>Euchoreutes naso</i>	Бараан хэрэм <i>Sciurus vulgaris</i>
Тахь адуу <i>Equus ferus przewalskii</i>	Гозоорой зурам <i>Spermophilus alashanicus</i>	Ойн булга <i>Martes zibellina</i>	Евразийн шилүүс <i>Lynx lynx</i>
Халиун буга <i>Cervus elaphus</i>	Евразийн минж <i>Castor fiber</i>	Хар сүүлтий <i>Gazella subgutturosa</i>	Мануул мий <i>Otocolobus manul</i>
	Давжаа алагдаага <i>Allactaga elater</i>	Цаа буга <i>Rangifer tarandus</i>	Саарал чоно <i>Canis lupus</i>
	Зүүнгар даахай <i>Stylodipus sungorus</i>		Хярс үнэг <i>Vulpes corsac</i>
	Сухайн чичүүл <i>Meriones tamariscinus</i>		Шар үнэг <i>Vulpes vulpes</i>
	Цоохор ирвэс <i>Uncia uncia</i>		Зэрлэг гахай <i>Sus scrofa</i>
	Хулан адуу <i>Equus hemionus</i>		Янгир ямаа <i>Capra sibirica</i>
	Хавтгай тэмээ <i>Camelus bactrianus ferus</i>		
	Аргаль хонь <i>Ovis ammon</i>		
	Цагаан зээр <i>Procapra gutturosa</i>		
	Тагаар бөхөн <i>Saiga tatarica</i>		
	Баданга хүдэр <i>Moschus moschiferus</i>		
	Молцог хандгай <i>Alces alces</i>		




## МОНГОЛЫН ХӨХТӨН АМЬТНЫ ТАРХАЦ

Хөвсгөлийн уулс, Хэнтий нуруу, Хангай нурууны хойд хэсэгт 60-аас дээш зүйлийн хөхтөн амьтан нутаглаж байгаа учраас Монгол орны хөхтөн амьтны зүйлийн баялаг нь тус орны хойд нутгаар хамгийн өндөр үзүүлэлттэй байна (Зураг 4). Монгол орны хөхтөн амьтны зүйлийн баялаг нь хойноос өмнө рүүгээ буурч буй чиг хандлагатай байна. Монгол орны өмнөд болон зүүн өмнөд хэсэгт, ялангуяа Говь Алтай нуруу, Алашань говь, Дорнод говь, Дорнод Монгол зэрэг нутгуудад зүйлийн баялаг хамгийн бага байна.




Зураг 4. Монгол орны хөхтөн амьтны зүйлийн баялаг. Бараан өнгө тодрох дутам зүйлийн баялаг ихэснэ.

Монгол орны хойд хэсэгт ховордож байгаа зүйлийн нягтшил илүү их бөгөөд ялангуяа Хангай нурууны хойд хэсэгт хамгийн их байна (Зураг 5). Монгол орны зүүн болон зүүн урд хэсгээр ховордож байгаа зүйлийн тоо харьцангуй цөөн байгаа нь тухайн нутаг нь зүйлийн баялаг бага байдагтай холбоотой юм. Хэдийгээр Зүүнгарын говь, Алтайн өвөр говь зэрэг баруун өмнөд нутгууд зүйлийн баялаг бага байдаг боловч ховордож байгаа зүйл олон байна. Монгол орны төв хэсгийн Төв халхын хээрт ховордож буй зүйлийн тоо нь энэ бүсэд тохиолдсон зүйлийн тоотой харьцуулахад өндөр байгаад нийслэл Улаанбаатарын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөн нөлөөлж байх талтай.



Зураг 5. Монгол орны хөхтний зүйлийн ховордлын байдал. Бараан өнгө тодрох тусам ховордож буй зүйлийн тоо ихэснэ.

Ховордох эрсдэлийн үнэлгээ хийхэд мэдээлэл дутмаг байгаа зүйлүүдийг Мэдээлэл дутмаг (МД) ангилалд оруулсан. Зүйлийн баялаг ихтэй хэрнээ, мэдээлэл дутмаг зүйлийн тоо их байгаа бүс нутгуудыг зүйлийн баялгийн зураг болон мэдээлэл дутмаг зүйлийн тархацын зураг хоорондоо ойролцоо харагдаж байгаагаар зурагдсан (Зураг 6). Хангай, Хөвсгөл, Хэнтий нуруу зэрэг зүйлийн баялаг ихтэй нутгуудад мэдээлэл дутмаг зүйлийн ихэнх нь байна. Алашань говь зэрэг зүйлийн баялаг багатай бүс нутагт мэдээлэл дутмаг зүйлийн тоо цөөн байна (Зураг 6). Алтайн өвөр говь цөл зүйлийн баялагаар бага байгаа боловч ховордож буй зүйлийн тоо олон, мэдээлэл дутмаг (МД) зүйл цөөн байгаа нь цөлийн болон заримдаг цөлийн зүйлүүдийг хамгаалахаар байгуулсан Говийн их дархан газрын А хэсэгт судалгааны ажил харьцангуй сайн хийгдсэнтэй холбоотой.



Зураг 6. Монгол орны хөхтөн амьтны мэдээлэл дутмаг зүйлийн тархац. Бараан өнгө тодрох тусам мэдээлэл дутмаг зүйлийн тоо нэмэгдэнэ.

# МОНГОЛЫН ХӨХТӨН АМЬТДАД УЧИРЧ БУЙ

## АЮУЛ ЗАНАЛ

Үнэлгээнд зүйлийн тоо толгойг буурахад хүргэж буй гол шалтгаанууд түүний үүсгэж буй хүчин зүйлийг (нөөцийн олборлол, агналт зэрэг) тодорхойлон гаргасан, зүйлийн тоо толгойг бууруулж буй (орчны хомсдол буюу санаатайгаар хороох) шууд шалтгааныг анхдагч, хоёрдогч, гуравдагч гэж ангилан гаргав.

Монгол орны ховордож буй хөхтөн амьтдын талаас дээш хувь нь агнуураас үүдэлтэйгээр хорогдож байгааг тогтоосон (57 хувь, Хүснэгт 3-аас харна уу). Агналт халиун буга (*Cervus elaphus*), аргаль хонь (*Ovis ammon*), цагаан зээр (*Procapra gutturosa*), баданга хүдэр (*Moschus moschiferus*), Монгол тарвага (*Marmota sibirica*), цоохор ирвэс (*Uncia uncia*) зэрэг амьтдыг ховордуулах ноцтой шалтгаан болж байна.

Нэг зүйл сухайн чичүүлд (*Meriones tamariscinus*) орчны доройтол нь анхдагч ховордуулах шалтгаан болсон бөгөөд таван зүйл тууртанд хоёрдогч ховордуулах шалтгаан болж байна. Ихэнх тохиолдолд орчны доройтол нь голдуу малын тоо өссөнөөс үүдэлтэй бэлчээрийн талхлагдлаас болсон гэж үзэж байна. Монгол орны ховордож буй хөхтний талаас илүү хувь нь орчны хомсдол, хуваагдал, доройтол зэрэг хоёрдогч шалтгаанын хам үйлчлэлд өртжээ (52 хувь). Гурван туруутныг оролцуулан таван зүйлийн хөхтөн амьтанд уул уурхай, нөөцийн олборлолт зэргээс үүдэлтэй орчны хомсдол ховордлын хоёрдогч шалтгаан болж байна. Ойн мод бэлтгэл, нил тайралтаас үүдэлтэй бусад нөөцийн олборлол нь Евразийн минж (*Castor fiber*), ойн булга (*Martes zibellina*) зэрэг зүйлийг ховордуулж байна. Орчны хуваагдал уудам тархацтай дөрвөн зүйлийн тууртанд хоёрдогч болон гуравдагч ховордлын шалтгаан болж байна.

Цаг уурын өөрчлөлт нь мэрэгч, тууртан, махчтаны хэд хэдэн зүйлийг ховордуулах шалтгаан болсон бөгөөд хойшид улам ноцтой байдал үүсгэнэ гэж тэмдэглэжээ. Эдгээр зүйлүүдийн ихэнх нь Монгол орны өмнөд хэсгийн гандуу хуурай бүс нутагт амьдардаг. Гандуу хуурай нөхцөл байдал нь хүрээлэн буй орчны өөрчлөлт эсвэл хүний идэвхтэй үйл ажиллагааны алинаас нь үүдэлтэй болох нь тодорхойгүй байна. Нөөцийн өрсөлдөөн (голдуу малын тоо толгойн өсөлт), өвчин, бохирдол зэрэг бусад гуравдагч ховордлын шалтгаан зүйл тус бүр дээр харилцан адилгүй нөлөөлсөөр байна.

Хүснэгт. 3. Монгол орны биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн семинарын ажлын хэсгийнхэний гаргасан Монгол орны ховордсон хөхтөн амьтдад шууд нүүрлэж буй ховордлын шалтгааны тойм. Ховордуулах анхдагч шалтгааныг хар, хоёрдогчийг саарал, гуравдагчийг цайвар саарал өнгөөр тэмдэглэв.

Ховорлын зэрэг	Зүйл	Шалтгаан															
		Орчны доройтол	Орчны фрагментаци	Орчны хомсдол	Бохирдол	Өвчин	Шимэгчид	Махчид	Эрлийзжилт	Өрсөлдөгчид	Зориудын эндэл	Гэнэгийн эндэл	Цаг уурын өөрчлөлт	Бусад	Мэдэгдээгүй		
УБ	<i>Ursus arctos gobiensis</i>																
	<i>Equus ferus przewalskii</i>																
	<i>Cervus elaphus</i>																
УБо	<i>Marmota sibirica</i>																
	<i>Spermophilus alashanicus</i>																
	<i>Castor fiber</i>																
	<i>Allactaga elater</i>																
	<i>Stylodipus sungorus</i>																
	<i>Meriones tamariscinus</i>																
	<i>Uncia uncia</i>																
	<i>Equus hemionus</i>																
	<i>Camelus bactrianus ferus</i>																
	<i>Ovis ammon</i>																
	<i>Procapra gutturosa</i>																
	<i>Saiga tatarica</i>																
	<i>Moschus moschiferus</i>																
	<i>Alces alces</i>																
Э	<i>Euchoreutes naso</i>																
	<i>Martes zibellina</i>																
	<i>Gazella subgutturosa</i>																
	<i>Rangifer tarandus</i>																

# ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

## Баг Мэрэгчтэн

### Овог Хэрэмнийхэн

#### 1. *Marmota baibacina* Kastschenko, 1899

**Түгээмэл нэр:** Алтайн тарвага (Монгол), grey marmot, Altai marmot (Англи).

**Ижил нэр:** *M. altaica*, *M. centralis*, *M. kastschenkoi*, *M. ognevi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг


**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Наймдугаар сарын 11-нээс аравдугаар сарын 15-ыг хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Алтайн тарваганы тархац нутгийн 16 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад (Шинжан), Киргизстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны хамгийн баруун зах хязгаарт Ховд аймгийн нутагт Булган, Буянт голын саваар өндөр уулын тагийн нугаар тохиолдоно (Адъяа, 2000).

**Ховордлын гол шалтгаан:** Мах, арьсыг нь хэрэглээний зорилгоор олон улсад худалдаалдаг бөгөөд 2004 онд 66000 толгойг агнасан гэсэн тооцоо бий (Wingard, Zahler, 2006). Малын тоо толгой олширч улмаар бэлчээрийн талхлагдалд орсноос орчны доройтолд хүргэх магадлалтай (тодорхой мэдээ шаардлагатай).




## 2. *Marmota sibirica* (Radde, 1862)

**Түгээмэл нэр:** Монгол тарвага (Монгол), Siberian marmot, Mongolian marmot, tarbagan marmot, Transbaikal marmot (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. s. sibiricus*, *M. s. caliginosus*

**Ижил нэр:** *M. caliginosus*, *M. dahurica* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, A2ad

**Үнэлгээний үндэслэл:** Өнгөрсөн 60 жилийн турш популяцийн тоо толгой нэлээд буурсан билээ. 1990 онд популяцийн тоо толгой 20 сая гэж тооцоолж байсан (Wingard, Zahler, 2006) бол саяхны судалгаагаар 2001 онд таван сая болж 75 хувь болтлоо буурсан байна (Batbold, 2002). 1800 оноос хойш жилд 1,2 сая толгой тарваганы арьс худалдаалдаг байсан бол 2004 оны байдлаар гурван сая тарваганы арьс худалдаалсан байна (Wingard, Zahler, 2006). Nowak (1991) тарваганы нэг үе удмын амьдрах хугацааг зургаан жил гэж тооцоолсон байдаг. Зохисгүй агналтын уршгаар популяцийн тоо толгой сүүлийн гурван үе удмын турш 50 гаруй хувь буурсан учир монгол тарвагыг A2ad шалгуураар үнэлэн Устаж болзошгүй хэмээх ангилалд оруулав. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлджээ.



**Хамгаалсан байдал:** Байгаль Орчны Яамны сайдын тушаалаар 2005, 2006 онд орон даяар тарваганы агнуурыг бүрэн хориглосон. Урьд нь популяцийн тоо толгойноос хамааран наймдугаар сарын 10-аас аравдугаар сарын 15 хүртэлх хугацаанд тарвага агнахыг хуулиар зөвшөөрдөг байсан (БОЯ, 2005). Мөн түүнчлэн орон нутгийн засаг захиргаанд дөрвөн жил тутам судалгаа хийх, энэ зүйлийг хамгаалахын тулд тухайн газар нутгийн агналтыг хаах эрхийг хуулиар олгосон байна. Агнуурын гол нутагт (зөвшөөрөгдсөн тохиолдолд) агнуурын үйл ажиллагаа явуулдаг компанийн өөрсдийн хөрөнгөөр нь жил бүр судалгаа хийлгэсэн байх ёстой (Wingard, Zahler, 2006). Монгол тарваганы тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** *M. s. sibiricus* нь дорнодын тал хээрээс Монгол Алтайн баруун хэсэг хүртэлх хээрээр тархан амьдарна (Wingard, Zahler, 2006). *M. s. caliginosus* нь Монгол орны баруун болон төв, хойд хэсгийн Хангай, Хөвсгөл, Монгол Алтайн нуруудын уулархаг нутгаар тархсан (Адъяа, 2000).

**Ховордлын гол шалтгаан:** Дотоодын болон гадаадын зах зээлд гаргахаар мах, арьс, ардын эмнэлэгт ашиглах зорилгоор агнадаг. Тарваганы тос кортикостероне<sup>2</sup> их хэмжээгээр агуулдаг ба хүүхэд, амьтанд хүнсний нэмэлт тэжээл байдлаар хэрэглэдэг, мөн түлэнхий, хөлдөлт, анемиа, сүрьеэ, арьсны өвчинд хэрэглэж ирсэн уламжлалтай (Адъяа, 2000; Wingard, Zahler, 2006). Өнгөрсөн зууны 1906 оноос 1994 оны хооронд Монголд нийт 104,2 сая тарваганы арьс олзворложээ (Батболд, 1996). Сүүлийн үед


хийгдсэн агнуурын судалгааны мэдээгээр тухайн жилд тогтоосон агнуурын хяналтын тооноос даруй гурав дахин их тарваганы арьс арилжаалагдсан тоо баримт байгаа бөгөөд хууль бусаар 2004 онд бэлтгэсэн 117,000 гаруй тарваганы арьсыг улсын орлого болгожээ (Zahler нар, 2004). Тахал өвчин дэлгэрэх нь тоо толгойн хорогдолын шалтгааны нэг бөгөөд тарвага агнах явцад хүн тарваган тахлын нянгаар халдварладгийг тогтоосон учраас устгахыг оролддог (Batbold, 2002). Гэсэн хэдий ч популяцийн тоо толгой буурах хэрээр тахал гарах давтамж буурдаг байна.

### 3. *Pteromys volans* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Хөхвөр олби (Монгол), Russian flying squirrel, Siberian flying squirrel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *P. v. turovi*

**Ижил нэр:** *P. ognevi*, *P. russicus*, *P. sibiricus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Олбийн тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Финланд, Латви, Эстони, Беларусь, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуурын хээр, Монгол Алтайн баруун хойд хэсгийн ойг нутагт тус тус тархана (Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт байгалийн болон хүний тавьсан түймэр, ойг сийрэгжүүлэн бэлтгэсний уршгаар орчны хомсдол нүүрлэх болов.

#### 4. *Sciurus vulgaris* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Бараан хэрэм (Монгол), Eurasian red squirrel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. v. fusconigricans*, *S. v. altaicus*, *S. v. mantchuricus*. Монгол дахь салбар зүйлийн талаар нарийвчилсан судалгаа шаардлагатай байна.

**Ижил нэр:** *S. mantchuricus*, *S. ognevi*, *S. orientis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** Монгол оронд энэ зүйлийн популяцийн чиг хандлагын талаарх мэдээлэл маш бага байна. Хэдий тийм боловч тархац нутгийн хэмжээнд хараа хяналтгүй агналт маш их тохиолдож байна. Хэрэв популяцийн талаарх мэдээлэл тодорхой болоод, хамгааллын арга хэмжээ авахгүй бол энэ зүйлийг ховордлын А шалгуураар дахин үнэлэх болно. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлджээ.



**Хамгаалсан байдал:** Жил бүрийн аравдугаар сарын 21-ээс дараа оны нэгдүгээр сарын 16 хүртэлх хугацаанд хэрэм агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Хэрэмний тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Сэينت Китс ба Нэвис [нутагшуулсан], Ирланд, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвеги, Швейцарь, Итали, Дани, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Босни Герцеговин, Унгар, Серб Монтенегро, Словак, Финланд, Румын, Македон, Украин, Болгар, Оросын Холбооны Улс, Казахстан [нутагшуулсан], Хятад, Киргизстан [нутагшуулсан], Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон; Гүрж, Армен, Азербайжан зэрэг улсад нутагшуулсан байж болзошгүй.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Хянганы уулсын ойт нутгаар тархана (Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980; Mallon, 1985).


**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын зах зээлд хэрэмний үслэг арьсыг нийлүүлэхийн тулд зүй зохисгүй сувдаглан агнаж байна. Хятадын зах зээлд арьс нэлээд үнэтэй байдаг бөгөөд агнуурын тоо хэмжээ тодорхойгүй байна. Энэ зүйлийн тархацын зарим нутагт байгалийн болон хүний тавьсан түймэр, хушны самар түүх, ойн бусад дагалт баялгийн ашиглалт, мод бэлтгэлээс үүдэлтэй орчны доройтол, хомсдол зэрэг нь хэрогдлын гол шалтгаан болж байна.

## 5. *Spermophilus alashanicus* Büchner, 1888

**Түгээмэл нэр:** Гозоорой зурам (Монгол), Alashan ground squirrel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. a. dilutus*


**Ижил нэр:** *S. dilutus*, *S. obscurus*, *S. siccus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, АЗс

**Үнэлгээний үндэслэл:** Гозоорой зурамны оршин амьдарч байгаа идээшил нутаг нь байнга хумигдаж, орчны доройтолд орж байна. Macdonald (2004) нэг үе удам хоёроос гурван жил үргэлжилнэ гэж бичсэн. Популяцийн бууралт сүүлийн арван жил 50 хувь буурсан гэж үзээд АЗс шалгуураар үнэлэн Устаж болзошгүй зүйлийн ангилалд оруулав. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлджээ.



**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай 2000 оны хуулийн дагуу гарсан Засгийн газрын тогтоолоор (№ 264) 2001 онд ховор зүйл амьтны зэрэглэлд хамруулжээ (Бадам, Алтанзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтад (БОЯ, 1996), Монгол улсын улаан номын удаах хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр оруулжээ (Шийрэвдамба нар, 1997). Гозоорой зурамны тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их, Бага богд, Арц богд, Говь Алтайн Говь гурван сайхан, Өшөг уулсаар тархана (Банников, 1954; Даваа, 1972).


**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөний улмаас бэлчээрийн талхлагдалд орж орчны доройтлыг бий болгож байна (тодорхой судалгаа шаардлагатай). Мөн нөөцийн олборлол (уул уурхай) орчны хомсдолд хүргэж байна.

## 6. *Spermophilus dauricus* Brandt, 1843

**Түгээмэл нэр:** Дагуур зурам, зумбараа зурам (Монгол), Daurian ground squirrel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. d. alaschanicus*


**Ижил нэр:** *S. mongolicus*, *S. ramosus*, *S. umbratus*, *S. yamashinae* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Дагуур зурамны тархац нутгийн 7 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Дорнодын тал хээрээс Хэрлэн голын дунд урсгал (Соколов, Орлов, 1980) хүртэл тархаж байсан бол одоо Төв Халхын хээрт Туул голын хөндийд тохиолдох (Батсайхан, хэвлээгүй мэдээ) болов.


**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөний улмаас бэлчээр талхлагдаж уг зүйлийн амьдрах орчныг доройтуулах боломжтой (тодорхой судалгаа шаардлагатай).

## 7. *Spermophilus erythrognys* Brandt, 1841

**Түгээмэл нэр:** Бозлог зурам, халтар зурам (Монгол), red-cheeked ground squirrel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. e. pallidicauda*, *S. e. brevicauda*

**Ижил нэр:** *S. brevicauda*, *S. pallidicauda*, *S. selevini* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Бозлог зурамны тархац нутгийн 5 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгорын хойд Увс нуурын хотгороос Дорнод говиор дамжаад дорно зүгт Дарьганга хүртэлх цөлөрхөг хээрийн бүсээр тархана (Даваа, 1972).


**Ховордлын гол шалтгаан:** Орон нутагт мах, арьсыг нь ашиглах зорилгоор зохисгүй агнадаг байв. Малын тоо толгой өссөнөөс бэлчээр талхлагдаж орчны хомсдол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Жил дараалсан ган гачиг, булаг, шандны ширгэлт энэ зүйлийн тоо толгой хорогдох шалтгаан хэдий ч, хүний үйл ажиллагаа эсвэл байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 8. *Spermophilus undulatus* (Pallas, 1778)

**Түгээмэл нэр:** Урт сүүлт зурам, сүүлэрхэг зурам (Монгол), long-tailed ground squirrel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. u. undulatus*, *S. u. stramineus*

**Ижил нэр:** *S. altaicus*, *S. evermanni*, *S. transbaikalicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Урт сүүлт зурамны тархац

нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад (Хейлонжянь, Шинжан), Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтий нуруудын ойт хээр, хээрийн бүсээр ихэд тархсан. Өмнө тийш Монгол Алтайн нурууны Аж Богдын нуруунд тохиолдоно (Соколов, Орлов, 1980). Дорноговийн Их нартын чулуу байгалийн нөөц газрын умард нутагт саяхан тэмдэглэгдсэн байна (Reading нар, 2006).

**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын зах зээлд энэ зурамны арьсыг хамгийн олноор буюу жилд 418,400-551,000 ширхэгийг 1958-1960 оны хооронд бэлтгэн нийлүүлж байжээ (Stubbe, 1965). Зурамны арьс бэлтгэл зогссон хэдий ч түүний тоо толгойн бууралтад нөлөөлөх бусад шалтгаан одоогоор тодорхойгүй байна.

## 9. *Tamias sibiricus* (Laxmann, 1769)

**Түгээмэл нэр:** Замба жирх (Монгол), Siberian chipmunk (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *T. s. sibiricus*


**Ижил нэр:** *T. altaicus*, *T. orientalis*, *T. pallasii* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Жирхний тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны хойд хэсгийн Хангай, Хөвсгөл, Хэнтий, Монгол Алтайн ойт нутгаар дэлгэр тархана (Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980; Mallon, 1985).

**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын зах зээлд жирхний арьсыг худалддаг. Хамгийн олноор жилд 2,600-4,400 ширхэгийг 1958-1960 оны хооронд бэлтгэн нийлүүлж байжээ (Stubbe, 1965). Жирхний арьс бэлтгэл багассан хэдий ч, түүний тархацын зарим нутагт байгалийн болон хүний тавьсан түймэр одоогоор гол аюул, занал учруулж байна.

## Овог Унтаахайнхан

### 10. *Dryomys nitedula* (Pallas, 1778)

**Түгээмэл нэр:** Ойн унтаахай (Монгол), forest dormouse (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *D. n. angelus*



**Ижил нэр:** *D. obolenskii*, *D. ognevi*, *D. pallidus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр тус тус



бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Ойн унтаахайн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Герман, Лихтенштайн, Швейцарь, Итали, Австри, Чех, Словен, Хорват, Польш, Босни Герцоговин, Унгар, Серб, Монтенегро, Словак, Грек, Румын, Македон, Латви, Литва, Украин, Болгар, Беларусь, Турк, Оросын Холбооны улс, Молдав, Израиль, Сири, Иран, Ирак, Гүрж, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикистан, Хятад, Монгол, Киргизстан; Ливанд байх боломжтой.

**Бүс нутгийн тархац:** Ойн унтаахайн дэлхийн тархацын зүүн хязгаар болох Зүүнгарын говийн умард хэсэг Булган голын савд томоохон популяци оршдогийг Stubbe (1986a) нарын судлаачид тэмдэглэжээ.

**Ховордлын гол шалтгаан:** Голын шугуйн бургасыг замбараагүй огтлосноос орчны хомсдол бий болж байна.

## Овог Минжнийхэн

### 11. *Castor fiber* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Евразийн минж (Монгол), Eurasian beaver (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. f. birulai*. Евразийн минжний үлдэц популяци дээр хийсэн молекул биологийн судалгаагаар энэ нь салбар зүйл мөн болох нь тогтоогджээ (Ducroz нар, 2003; Durka нар, 2005).


**Ижил нэр:** *C. birulai*, *C. bindai*, *C. flavus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй, *C. f. birulai* салбар зүйл нь Эмзэг D1 нарийвчлан үнэлэгдсэн.

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй B1ab(iii)

**Үнэлгээний үндэслэл:** Байгалийн нөөц баялгийн олборлолтоос үүдэлтэй орчны хомсдол, зохисгүй ашиглалт зэрэг нь ховордох шалтгаан болж байна. Энэ зүйлийн тархац нутгийн талбай 5,000 км<sup>2</sup>-аас бага (ойролцоогоор 2,000 км<sup>2</sup>), зөвхөн гурван байршил нутгаар (хоёр байршил нутагт нь хамгаалах зорилгоор нутагшуулсан) хязгаарлагдаж, идээшил, тархац нутаг нь байнга хумигдаж байгаа зэргийг харгалзан үзээд B1ab(iii) шалгуураар үнэлэн Устаж болзошгүй зүйлийн ангилалд оруулав. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлджээ.

**Хамгаалсан байдал:** *C. f. birulai* салбар зүйлийг Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн (2000) 7.1-д нэн ховор амьтдын жагсаалтад хамруулсан (Бадам, Ариунзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтад оруулсан байна (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор



зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Түүний тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Франц, Нидерланд, Герман, Лихтенштайн, Швейцарь [нутагшуулсан], Норвеги, Австри [нутагшуулсан], Чех, Хорват, Швед, Польш, Унгар, Словак, Финланд, Латви, Литва, Эстон, Украин, Беларусь, Оросын Холбооны Улс, Молдав, Хятад, Монгол. *S. f. birulai* зүйл нь Хятад, Монголд тархсан.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун өмнөд хязгаарын Зүүнгарын говийн умард хэсэгт Булган голын сав газарт Евразийн минжний жижиг автохтон популяци оршдог. Монгол-Германы хамтарсан биологийн экспедици Булган голоос минж барьж, 1974, 1975, 1978 онд Монгол Алтайн нурууны Ховд голд, 1985, 1988, 2002 онд Хангайн нурууны умард нутгийн Тэс голд төв Азийн усны ай савд үлдвэр минжний генийн санг хамгаалах зорилгоор тус тус нутагшуулжээ (Stubbe, Dawaa, 1982; Stubbe, Dawaa, 1986b; Stubbe нар, 1991; Stubbe нар, 2005a). Оросын Холбооны Улсын Воронежийн байгалийн нөөц газраас Ерөө голд минж нутагшуулах оролдлого хийсэн боловч амжилтанд хүрээгүй юм (M. Stubbe, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Зарим нутагт тухайлбал, Тэс гол орчмын иргэд минжний арьсаар эд зүйл хийх, махыг нь хүнс, анхилам үнэрт булчирхайг (үнэртний бүтээгдэхүүнд хэрэглэдэг) ашиглах зорилгоор хууль бусаар агнаж байна. Булган, Ховд голын шугуйн бургасыг нутгийн иргэд огтолж, түлш, эд ахуйн зүйл хийхэд ашиглаж байгаа нь минжний идэш тэжээл, орогнох газрын хомсдолыг бий болгож байна. Орчны хомсдол бий болсноор жижиг популяцийг хооронд нь тусгаарлаж, улмаар инбридингийн боломж, нөхцлийг улам нэмэгдүүлэхэд хүргэж байна. Усны бохирдол мөн ховордлын шалтгаан болно. Хятад улсын нутагт Булган гол дээр барьсан усан цахилгаан станцын далангийн байгууламж минжний шилжилт, суурьшилд саад учруулдаг (M. Stubbe, аман мэдээ).

## Овог Алагдааганыхан

### 12. *Allactaga balikunica* Hsia and Fang, 1964

**Түгээмэл нэр:** Өмнөговийн алагдаага (Монгол),  
Balikun jerboa (Англи).

**Ижил нэр:** *A. nataliae* (Wilson, Reeder (1993) нарын  
бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам,  
тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ  
буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Энэ зүйл алагдааганы  
тархац нутгийн 43 орчим хувь нь улсын тусгай  
хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Хятад, Монгол

**Бүс нутгийн үнэлгээ:** Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь, Дорнод говийн  
нутгаар тархсан. Монгол орны өмнөд хэсэгт говийн алагдаагатай (*A. bullata*) зэрэгцэн  
оршдог (Wilson, Reeder, 1993).

**Ховордлын гол шалтгаан:** Жил дараалсан ган гачиг, булаг шандны ширгэлт, татралт  
энэ зүйлийн тоо толгойг ховордуулах шалтгаан хэдий ч, хүний үйл ажиллагаа эсвэл  
байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан  
тогтоогоогүй байна.

### 13. *Allactaga bullata* Allen, 1925





**Түгээмэл нэр:** Говийн алагдаага (Монгол), Gobi jerboa  
(Англи).

**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац,  
популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага,  
учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй  
байна.

**Хамгаалсан байдал:** Говийн алагдааганы  
тархац нутгийн 21 орчим хувь нь улсын тусгай  
хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь, Дорнод говьд тархана (Соколов нар, 1998). Монгол орны өмнөд нутагт *A. balikunica* зүйлтэй зэрэгцэн оршдог (Wilson, Reeder, 1993).


**Ховордлын гол шалтгаан:** Булаг, шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн тоо толгойг ховордуулах шалтгаан хэдий ч хүний үйл ажиллагаа эсвэл байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

#### 14. *Allactaga elater* (Lichtenstein, 1828)

**Түгээмэл нэр:** Давжаа алагдаага (Монгол), small five-toed jerboa (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *A. e. dzungariae*


**Ижил нэр:** *A. bactriana*, *A. dzungariae*, *A. strandi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, B1ab(iii)

**Үнэлгээний үндэслэл:** Давжаа алагдаага орчны доройтол болон цаг уурын таагүй нөхцлийн улмаас хорогдож байна. Энэ зүйлийн тархац нутгийн хэмжээ нь 5,000 км<sup>2</sup>-аас бага (ойролцоогоор 2,000 км<sup>2</sup>), таваас цөөн хязгаарлагдмал байршил нутагт оршин амьдардаг. Давжаа алагдаага нь цөөн байршил нутагт хязгаарлагдмал тархацтайн зэрэгцээ бэлчээрийн талхлалт амьдрах орчныг нь доройтуулж, улмаар идээшил нутаг нь хумигдаж байгааг харгалзан B1ab(iii) шалгуураар устаж болзошгүй гэсэн ангилалд хамааруулжээ. Хил залгаа улсаас нүүдэл шилжилт, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.



**Хамгаалсан байдал:** Давжаа алагдааганы тархац нутгийн 54 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Турк, Оросын Холбооны Улс, Гүрж, Армен, Иран, Азербайжан, Афганистан, Пакистан, Казахстан, Туркменистан, Киргизстан, Тажикстан, Узбекистан, Хятад, Монгол (Г. Шенброт, аман мэдээ).

**Бүс нутгийн тархац:** Монгол орны хамгийн баруун өмнөд нутгийн Зүүнгарын говийн Бодонч голын адгаас анх тэмдэглэснээс (Stubbe, Chotolchu, 1968) хойш Хонин усны говьд дахин олджээ (Соколов нар, 1998).

**Ховордлын гол шалтгаан:** Булаг, шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн тоо толгойн хорогдолд нөлөөлж байгаа хэдий ч хүний үйл ажиллагаа эсвэл байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 15. *Allactaga sibirica* (Forster, 1778)

**Түгээмэл нэр:** Сибир алагдаага, Шивэр алагдаага (Монгол), Siberian jerboa, Mongolian five-toed jerboa (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *A. s. saltator* (*A. s. semideserta* гэж ч үздэг), *A. s. sibirica*, *A. s. bulganensis* (Шенброт (1991); Шенброт нар (1995); Соколов нарын (1998) бүтээлээс нарийвчлан харна уу).

**Ижил нэр:** *A. alactaga*, *A. mongolica*, *A. semideserta* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Сибир алагдааганы тархац нутгийн 10 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт багтдаг.

**Дэлхийн тархац:** Казахстан, Туркменистан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны ойт хээр, хээр, хуурай хээр, говь цөлийн бүсээр ихэд тархсан (Mallon, 1985). *A. s. sibirica* салбар зүйл дорнод болон умард Монголд, тухайлбал, Сэлэнгэ мөрний ай сав нутгаар, харин *A. s. saltator* (*A. s. semideserta* багтсан) салбар зүйл Монгол орны баруун умард, өмнөд, өрнөд нутагт оршин амьдарна. *A. s. bulganensis* салбар зүйл зөвхөн Зүүнгарын говьд тохиолдоно (Г. Шенброт, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## 16. *Cardiocranius paradoxus* Satunin, 1903




**Түгээмэл нэр:** Таван-хуруут атигдаахай, тарвуу атигдаахай (Монгол), five-toed pygmy jerboa (Англи).

**Олон улсын үнэлгээ:** Эмзэг, A1c

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл



зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Энэ зүйл атигдаахайн тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны умард хилээс Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Умард говь, Алашань говь, Дорнод говь хүртэлх цөл, цөлөрхөг хээрийн бүсэд 52 байршлыг тэмдэглэж байсан бол (Соколов нар, 1996) саяхан энэ тоо 60 болсон байна (Г. Шенброт, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Ган гачиг, ширүүн аадар бороо зэрэг байгалийн гамшигт үзэгдэл энэ зүйлийг ховордуулах шалтгаан нь болдог.

### 17. *Dipus sagitta* (Pallas, 1773)

**Түгээмэл нэр:** Элсч савагдаахай (Монгол), northern three-toed jerboa, hairy-footed jerboa (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *D. s. sowerbyi* (*D. s. ubsanensis* хэмээн үздэг), *D. s. halli*, *D. s. bulganensis* (Shenbrot (1991); Шенброт нар (1995); Соколов нарын (1998) бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).


**Ижил нэр:** *D. halli*, *D. lagopus*, *D. zaissanensis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Элсч савагдаахайн тархац нутгийн 17 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Иран, Казахстан, Туркменистан, Киргизстан, Узбекистан, Хятад, Монгол (Г. Шенброт, аман мэдээ).


**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Алашань говийн цөлөрхөг хээр, цөлийн бүсээр ихэд тархсан (Соколов нар, 1996). Мөн Дорнод говь, Говь Алтайн нуруу, Алтайн өвөр говь, Зүүнгарын говь, Төв Халхын хээр, цөл, цөлөрхөг хээрээр тархсан. Савагдаахайн *D. s. sowerbyi* (*D. s. ubsanensis* багтсан) салбар зүйл Монгол орны баруун умард, төв, өмнөд нутгаар, харин *D. s. halli* салбар зүйл дорнод нутгаар, *D. s. bulganensis* салбар зүйл Зүүнгарын говьд тус тус тархан амьдарна (Г. Шенброт, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Булаг, шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдолд нөлөөлөх хэдий ч, байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 18. *Euchoreutes naso* Sclater, 1891

**Түгээмэл нэр:** Соотон алагдаахай, соотон алагдай (Монгол), long-eared jerboa (Англи).

**Ижил нэр:** *E. alashanicus*, *E. yiwuensis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Устаж болзошгүй, А1с

**Бүс нутгийн үнэлгээ:** Эмзэг, А3с

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн оршин амьдарч байгаа, идээшил нутаг нь орчны доройтолд орж, хүний садаанаас байнга хумигдаж байна. Macdonald (2004) нэг үе удам хоёроос гурван жил үргэлжилнэ гэж бичсэн. Популяцийн бууралт сүүлийн арван жил 30 хувь буурсан гэж үзээд А3с шалгуураар үнэлж эмзэг зүйл хэмээх ангилалд оруулав. Хил залгаа нутгаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлдэв.



**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Соотон алагдаахайн тархац нутгийн 44 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Соколов нар (1996) Алтайн өвөр говь, Алашань говийн цөлийн бүст арван байршлыг тэмдэглэжээ. Монгол улсын өмнөд нутаг энэ зүйл алагдааганы дэлхийн тархацын умард хил болно.


**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлагдлаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Хүний нөлөө, сүйтгэл бага илэрч болно. Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 19. *Pygeretmus pumilio* (Kerr, 1792)

**Түгээмэл нэр:** Зэгэл алагдаганцар (Монгол), dwarf fat-tailed jerboa (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *P. p. potanini*, *P. p. bulatoides*

**Ижил нэр:** *P. aralensis*, *P. minutus*, *P. sibiricus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Зэгэл алагдаганцарын тархац нутгийн 26 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Иран, Казахстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Зүүнгарын говь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Алтайн өвөр говь, Алашань говьд тархана (Соколов нар, 1998). Stubbe, Chotolchu (1968) нар Монгол орны баруун өмнөд хилийн орчим хоёр байршлын цэг тэмдэглэжээ.

**Ховордлын гол шалтгаан:** Бусад зүйл мэрэгчид түүний тархац нутгийн хүрээнд идэш тэжээлийн төлөө өрсөлдөөнд хүргэж болох талтай. Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 20. *Salpingotus crassicauda* Vinogradov, 1924

**Түгээмэл нэр:** Өөхөн-сүүлт атигдаахай, өөхлөг тажигдаахай (Монгол), thick-tailed pygmy jerboa (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. c. crassicauda*, *S. c. gobicus*

**Ижил нэр:** *S. gobicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Эмзэг, A1c

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997).



Өөхөн-сүүлт атигдаахайн тархац нутгийн 19 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.


**Дэлхийн тархац:** Казахстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Соколов нар (1996) Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь, Умард болон Дорнод говийн цөлөрхөг хээр, цөлийн бүст нийт 31 байршлыг тэмдэглэжээ.

**Ховордлын гол шалтгаан:** Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 21. *Salpingotus kozlovi* Vinogradov, 1922

**Түгээмэл нэр:** Козловын атигдаахай, элсний тажигдаахай (Монгол), Kozlov's pygmy jerboa (Англи).




**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Козловын атигдаахайн тархац нутгийн 37 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.




**Дэлхийн тархац:** Хятад (Өвөр Монгол, Шинжан, Гансу, Умард Шаньши, Нингша), Монгол.

**Бүс нутгийн тархац:** Тун бага судлагдсан энэ зүйл атигдаахайг Алтайн өвөр говь, Алашань говь, Дорнод говь зэрэг нутагт нийт 16 цэгт тэмдэглэжээ (Соколов нар, 1996).

**Ховордлын гол шалтгаан:** Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна

## 22. *Stylodipus andrewsi* Allen, 1925

**Түгээмэл нэр:** Монгол даахай, Монголжин даахай (Монгол), Andrews's three-toed jerboa, Mongolian jerboa (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Монгол даахайн тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.




**Дэлхийн тархац:** Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Алашань говь, Умард говь, Дорнод говьд тохиолдоно (Соколов нар, 1998).

**Ховордлын гол шалтгаан:** Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 23. *Stylodipus sungorus* Sokolov and Shenbrot, 1987

**Түгээмэл нэр:** Зүүнгар даахай (Монгол), Mongolian three-toed jerboa (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Устаж болзошгүй, АЗс•.

тархац нутгийн ихэнх хэсэг буюу бүхэлдээ

Монгол оронд тохиолдоно гэж үздэг.

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, АЗс

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн оршин

амьдарч байгаа идээшил нутаг орчны доройтол

болон хүрээлэн буй орчны өөрчлөлтөнд орж

үргэлжлэн хумигдаж байна. Macdonald (2004) нэг

үе удам хоёроос гурван жил үргэлжилнэ гэж бичсэн. Популяцийн бууралт сүүлийн арван

жил 50 хувь буурсан гэж үзээд АЗс шалгуураар үнэлэн устаж болзошгүй зүйл хэмээх

ангилалд оруулав. Хил залгаа нутгаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул

бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлдэв.

**Хамгаалсан байдал:** Зүүнгар даахайн тархац нутгийн 41 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Монгол; Хятадаас олоход боломжтой


**Бүс нутгийн тархац:** Энэ зүйл даахай зөвхөн Зүүнгарын говьд Говийн их дархан газрын Б хэсгээр тархмал (Соколов, Шенброт, 1987; Соколов нар, 1998).

**Ховордлын гол шалтгаан:** Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна. Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалт бий болж үүний уршгаар орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай).

## Овог Шишүүхэйнхэн

### 24. *Allocricetulus curtatus* (Allen, 1925)

**Түгээмэл нэр:** Цомч шишүүхэй, цомч шишүү (Монгол), Mongolian hamster (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Цомч шишүүгийн тархац нутгийн 9 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Хятад, Монгол

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Говь Алтайн нуруу, Төв Халхын хээр, Дорнод говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говиор тархана (Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалт бий болж үүний уршгаар орчны доройтол нүүрлэж болзошгүй байна (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 25. *Cricetulus barabensis* (Pallas, 1773)

**Түгээмэл нэр:** Хөх шишүүхэй (Монгол), striped dwarf hamster (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. b. griseus*, *C. b. obscurus*


**Ижил нэр:** *C. manchuricus*, *C. mongolicus*, *C. obscurus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.



**Хамгаалсан байдал:** Хөх шишүүхэйн тархац нутгийн 9 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны хамгийн өрнөд болон өмнөд нутгийн цөл, цөлөрхөг хээрээс бусад нутгаар ихэд тархсан. Хөх шишүүхэй нь бүрдийн шишүүхэйн *C. sokolovi* тархац нутгийн хүрээнд тохиолддоггүй (Г. Шенброт, аман мэдээ).


**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалт бий болж үүний уршгаар орчны доройтол нүүрлэж болзошгүй байна (тодорхой мэдээ шаардлагатай). Байгалийн болон хүний тавьсан түймрийн улмаас орчны хомсдол нүүрлэдэг.

## 26. *Cricetulus longicaudatus* (Milne-Edwards, 1867)

**Түгээмэл нэр:** Сүүллэг шишүүхэй (Монгол), long-tailed dwarf hamster (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. l. longicaudatus*

**Ижил нэр:** *C. andersoni*, *C. kozhantschikovi*, *C. nigrescens* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.



**Хамгаалсан байдал:** Сүүллэг шишүүхэйн тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны өрнөд болон төв нутгаас дорнод уртрагийн 104° E хүртэлх уудам нутагт тархсан (Дуламцэрэн нар, 1989). Дорнод говьд Их нартын чулуу байгалийн нөөц газрын умард нутагт тэмдэглэгдсэн байна (Reading нар, 2006).

**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Зарим нутагт бусад мэрэгч амьтадтай идэш тэжээлийн өрсөлдөөнд орж болно. Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 27. *Cricetulus migratorius* (Pallas, 1773)

**Түгээмэл нэр:** Бордуу шишүүхэй (Монгол), grey hamster, grey dwarf hamster (Англи).


**Ижил нэр:** *C. isabellinus*, *C. murinus*, *C. ognevi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Бордуу шишүүхэйн тархац нутгийн 33 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.




**Дэлхийн тархац:** Грек, Румын, Украин, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Молдав, Израйль, Ливан, Йордан, Ирак, Иран, Казахстан, Афганистан, Пакистан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань, Дорнод говийн хэд хэдэн газарт тохиолджээ (Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 28. *Cricetulus sokolovi* Orlov and Malygin, 1988

**Түгээмэл нэр:** Бүрдийн шишүүхэй (Монгол), Sokolov's dwarf hamster (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Бүрдний шишүүхэйн тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Хятад, Монгол

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Алашань говь, Дорнод говиос олдсон (Орлов, Мальгин, 1988) бөгөөд Монгол оронд түүний тархацын талаарх судалгаа маш бага хийгджээ.


**Ховордлын гол шалтгаан:** Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 29. *Phodopus campbelli* (Thomas, 1905)

**Түгээмэл нэр:** Орог зусаг, орог зузга (Монгол), Campbell's hamster (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *P. c. campbelli*

**Ижил нэр:** *P. crepidatus*, *P. tuvanicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Орог зусгийн тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны төв, өрнөд болон дорнод нутгийн хээр, хуурай хээр, цөлөрхөг хээрийн бүсээр түгээмэл тархана (Дуламцэрэн нар, 1989).

**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

### 30. *Phodopus roborovskii* (Satunin, 1903)

**Түгээмэл нэр:** Элсний зусаг, элсний зузга (Монгол), desert hamster, Roborowski's hamster (Англи).


**Ижил нэр:** *P. bedfordiae*, *P. praedilectus*, *P. przewalskii* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Элсний зусгийн тархац нутгийн 18 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол.


**Бүс нутгийн тархац:** Говь Алтай нуруу, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь, Дорнод говийн цөл, цөлөрхөг хээрийн бүст ихэд тархсан (Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## Овог Оготныхон

### 31. *Alticola barakshin* Bannikov, 1947

**Түгээмэл нэр:** Говь Алтайн барагчин, хүмж барагчин (Монгол), Govi Altai mountain vole (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Говь алтайн барагчины тархац нутгийн 20 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол (Нон нар, 1995).

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай нурууны хойд хэсгийн зарим нутагт тархсан (Павлинов нар, 2002).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### **32. *Alticola macrotis* (Radde, 1862)**

**Түгээмэл нэр:** Соён барагчин (Монгол), large-eared vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *A. m. vinogradovi*, *A. m. macrotis*. Монгол дахь салбар зүйлийг нягтлан тогтоох судалгаа шаардлагатай.

**Ижил нэр:** *A. altaica*, *A. fetisovi*, *A. vicina*, *A. vinogradovi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Соён барагчины тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Монгол.


**Бүс нутгийн тархац:** Монгол Алтайн нурууны Мөнххайрхан, Хангайн Тарвагатай нуруу (Соколов, Орлов, 1980), Хөвсгөлийн Мөнх Сарьдаг уулсын тагийн хадархаг нутгаар тархмал (Литвинов, 1982; Литвинов, Базардорж, 1992).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 33. *Alticola semicanus* (Allen, 1924)

**Түгээмэл нэр:** Хадны барагчин (Монгол), Mongolian silver vole, Royle's mountain vole (Англи).

**Ижил нэр:** *A. argentatus* зүйлийг хожим салгаж *A. tuvinicus* Ognev, 1950, *A. semicanus* (Allen, 1924) хэмээх хоёр бие даасан зүйл болгожээ. Wilson, Reeder (1993) нар *A. alleni* зүйлийг ижил нэрийн жагсаалтанд оруулсан байна.



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй  
**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй  
**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.



**Хамгаалсан байдал:** Хадны барагчины тархац нутгийн 10 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун болон зүүн умард хэсгээс бусад бүх нутгаар ихэд тархсан.


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 34. *Alticola strelzowi* (Kastschenko, 1899)

**Түгээмэл нэр:** Тавшгар барагчин (Монгол), flat-headed vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *A. s. depressus*

**Ижил нэр:** *A. depressus*, *A. desertorum* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Тавшгар барагчины тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад (Шинжан), Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны зөвхөн баруун умард нутагт орших Монгол Алтайд Ховд орчим тэмдэглэгджээ (Соколов, Орлов, 1980).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 35. *Alticola tuvinicus* Ognev, 1950

**Түгээмэл нэр:** Тува барагчин (Монгол), Tuva silver vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *A. t. kosogol*. Монгол дахь салбар зүйлийг нягтлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *A. argentatus* зүйлийг хожим салгаж *A. tuvinicus* Ognev, 1950, *A. semicanus* (Allen, 1924) хэмээх хоёр бие даасан зүйл болгожээ. Wilson, Reeder (1993) нар *A. baicalensis*, *A. khubsugulensis*, *A. kosogol*, *A. olchonensis* зэрэг зүйлийг ижил нэрийн жагсаалтад оруулсан байна.



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Тува барагчины тархац нутгийн 25 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Монгол.


**Бүс нутгийн тархац:** Монгол Алтайн нурууны баруун умард хэсэг, Хөвсгөлийн уулсаар, Хангайн нурууны хойд хэсгээр тархана (Литвинов, Базардорж, 1992).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 36. *Arvicola terrestris* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Усч оготно, усч бөрөм (Монгол), European water vole (Англи).

**Ижил нэр:** *A. barabensis*, *A. ognevi*, *A. pallasii* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Усч бөрмийн тархац нутгийн 20 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Португал, Андор, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Лихтенштейн, Норвеги, Швейцарь, Люксембург, Итали, Холи Си, Дани, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Босни Герцоговин, Унгар, Словак, Серб, Монтенегро, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Литва, Эстони, Болгар, Украин, Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Израйль, Иран, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Банников (1954) Хөвсгөлөөс арьсыг нь анх олж илрүүлснээс хойш Дуламцэрэн (1970) тэндээс усч оготны гурван байршлыг тэмдэглэжээ. Мөн Монгол Алтайн Ховдод хэд хэдэн байршлыг шинээр илрүүлсэн байна.


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### **37. *Clethrionomys rufocanus* (Sundevall, 1846)**

**Түгээмэл нэр:** Ойн хүрэн оготно, хүрэндүү ойго (Монгол), grey red-backed vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. r. irkutensis*

**Ижил нэр:** *C. kamtschaticus*, *C. latastei*, *C. sibirica* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Ойн хүрэн оготны тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Норвеги, Швед, Финланд, Оросын Холбооны Улс, Хятад (Хелонжянь, Шинжан), Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон (Хоккайдо).

**Бүс нутгийн тархац:** Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулс, Монгол Алтай, Монгол Дагуурын хээр, Их Хянганы уулсын ойт нутагт тархана. Говийн Алтайн нурууны Их Богд орчим тусгаарлагдсан жижиг популяци бий (Lkhagvasuren, Samiya, 2004).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааныг тодруулах баттай мэдээ байхгүй хэдий ч байгалийн болон хүний тавьсан түймрээс орчны хомсдол нүүрлэх боломжтой.

### 38. *Clethrionomys rutilus* (Pallas, 1779)

**Түгээмэл нэр:** Ойн улаан оготно, улаан ойго (Монгол), northern red-backed vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. r. baikalensis*

**Ижил нэр:** *C. alascensis*, *C. tundrensis*, *C. vinogradovi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Ойн улаан оготны тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн Улс, Норвеги, Швед, Финланд, Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөл, Монгол Алтай, Хангай, Хэнтий нурууд, мөн Монгол Дагуурын хээрт тархсан (Дуламцэрэн нар, 1989).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааныг тодруулах баттай мэдээ байхгүй ч байгалийн болон хүний тавьсан түймрээс орчны хомсдол нүүрлэх боломжтой.

### 39. *Ellobius tancrei* Blasius, 1884

**Түгээмэл нэр:** Сохдой оготно, зээрд сохдой (Монгол), Zaisan mole vole (Англи).

**Ижил нэр:** *E. kastschenkoi*, *E. ognevi*, *E. ursulus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Сохдой оготны тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.




**Дэлхийн тархац:** Казахстан, Туркменистан, Узбекистан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун умард, төв болон зүүн өмнөд нутгийн дов толгодоор тархан нутагшина. Их нуруудын хөндий, Нууруудын хөндий, Монгол Алтай нуруу, Умард говь, Төв Халхын хээр, Дорнод говийн цөлөрхөг болон цөлийн бүсэд тархана (Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

#### **40. *Eolagurus luteus*** (Eversmann, 1840)

**Түгээмэл нэр:** Овын шар оготно, шаргал овол (Монгол), yellow steppe lemming (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Бага эрсдэлтэй, хамгааллаас шалтгаалах

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Овын шар оготны тархац нутгийн 50 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархалт:** Казахстан, Хятад, Монгол, (Г. Шенброт, аман мэдээ).

**Бүс нутгийн тархац:** Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн зарим нутагт тархсан (Соколов, Орлов, 1980). Дорнод говийн Их нартын чулуу байгалийн нөөц газрын умард нутагт мөн тэмдэглэгдсэн (Reading нар, 2006) гэх бөгөөд энэ нь одоогоор тодорхойгүй (Г. Шенброт, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

#### 41. *Eolagurus przewalskii* (Büchner, 1889)

**Түгээмэл нэр:** Түвд ов, Тангад овол (Монгол), Przewalski's steppe lemming (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Түвд овын тархац нутгийн 19 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Умард говь, Дорнод говь, Алтайн өвөр говь, Алашань говьд тархана (Соколов, Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна. Түүний популяцийн тооны эрс хэлбэлзэл нь хорогдолд хүргэх нэг шалтгаан байж болзошгүй.

#### 42. *Lagurus lagurus* (Pallas, 1773)

**Түгээмэл нэр:** Овын хөх оготно, хөх ов (Монгол), steppe lemming (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *L. l. altorum*

**Ижил нэр:** *L. abacanicus*, *L. migratorius*, *L. occidentalis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Овын хөх оготны тархац нутгийн 17 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Украин, Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Алтайн өвөр говь, Зүүнгарын говь, Увс нуурын хотгор, Монгол Алтайн Шаргын говьд тэмдэглэгджээ (Соколов, Орлов, 1980).


**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Бусад мэрэгчидтэй нөөцийн төлөөх өрсөлдөөн бий болох боломжтой. Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

### 43. *Lasiopodomys brandti* (Radde, 1861)

**Түгээмэл нэр:** Үлийн цагаан оготно, цайвар үлийч (Монгол), Brandt's vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *L. b. brandtii*, *L. b. hangaicus*

**Ижил нэр:** *L. aga*, *L. hangaicus*, *L. warringtoni* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Үлийн цагаан оготны тархац нутгийн 4 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.


**Бүс нутгийн тархац:** Хангай, Хэнтийн салбар уулсын уулын хээр, Төв Халхын хээр, Дорнод Монгол, Умард говь, Нууруудын хөндийгөөр тархмал (Авирмэд, 2003).

**Ховордлын гол шалтгаан:** Үлийн цагаан оготны популяцийн тоо толгой хэт өсөх үед малын бэлчээрийн ургамлыг цөлмөж, халдварт өвчин тараадаг хөнөөлт зүйл гэж үздэг. Ихэнхдээ мал байнга бэлчиж талхлагдсан нутгийг илүүтэй шүтэн амьдрах тул ийм газарт олшрох нь элбэг тохиолдоно. Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онуудад Бромадиолоне хорыг ашигласан нь мануул (*Otocolobus manul*), шар үнэг (*Vulpes vulpes*), хярс үнэг (*Vulpes corsac*), талын бүргэд (*Aquila nipalensis*), цармын бүргэд (*Aquila chrysaetos*), шилийн сар (*Buteo hemilasius*), идлэг шонхор (*Falco cherrug*) зэрэг зүйлүүдэд ихээхэн хор нөлөө үзүүлсэн. Энэ үйл ажиллагаа одоогоор эдгээр зүйлд нөлөөлсөөр байна (Н. Батсайхан, аман мэдээ). Үлийн цагаан оготны популяцийн хэт олшрох мөчлөг 9-11 жилд тохиодог байна (Dawaa нар, 2005).

**44. *Lasiopodomys mandarinus*** (Milne-Edwards, 1871)

**Түгээмэл нэр:** Үлийн бор оготно (Монгол), Mandarin vole (Англи).

**Ижил нэр:** *L. kishidai*, *L. pullus*, *L. vinogradovi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Үлийн бор оготны тархац нутгийн нэг орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс.

**Бүс нутгийн тархац:** Хангай нурууны зүүн умард нутгаар дайран урсах Орхон, Сэлэнгийн сав, Нууруудын хөндийн зарим нутагт тэмдэглэгдсэн (Соколов, Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**45. *Microtus arvalis*** (Pallas, 1778)

**Түгээмэл нэр:** Бараан оготно (Монгол), common vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. a. obscurus*

**Ижил нэр:** *M. arvensis*, *M. meridianus*, *M. terrestris* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Бараан оготны тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Андор, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Хорват, Польш, Босни

Герцоговин, Унгар, Серб Монтенегро, Словак, Албани, Финланд, Румын, Македон, Латви, Литва, Эстони, Украин, Болгар, Беларусь, Оросын Холбооны Улс, Молдав, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол оронд зөвхөн Монгол Алтай, Хөвсгөлийн уулсаас олдох боломжтой гэж судлаачид (Соколов нар, 1985) үзсэн байдаг. Энэ зүйлийн тархацын талаарх мэдээлэл маш хомс.


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

#### 46. *Microtus fortis* Büchner, 1889

**Түгээмэл нэр:** Өргөөч оготно (Монгол), reed vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. f. michnoi*

**Ижил нэр:** *M. michnoi*, *M. pelliceus*, *M. uliginosus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Өргөөч оготны тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны зүүн хойд хэсэгт Улз голын хөндий, Монгол Дагуурын Хустайн нуруу, Хэнтий нурууны баруун умард нутаг Ерөө голын эх орчим олдсон (Самъяа нар, 2002). Дорнод Монголд Их Хянганы уулсаар тархана.

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

#### 47. *Microtus gregalis* (Pallas, 1779)

**Түгээмэл нэр:** Хэргэлзий оготно (Монгол), narrow-headed vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. g. raddei*, *M. g. angustus*, *M. g. gregalis*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *M. pallasii*, *M. slowzovi*, *M. unguiculatus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Хэргэлзий оготны тархац нутгийн 9 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар хамаарагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Киргизстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун хэсгээс Монгол Алтайн хойд хэсэг, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Дорнод Монгол, Төв Халхын хээрийн бүсээр түгээмэл тархсан.

**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг харахан тогтоогоогүй байна.

#### 48. *Microtus limnophilus* Büchner, 1889



**Түгээмэл нэр:** Зүлгийн оготно (Монгол), Lacustrine vole (Англи).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Зүлгийн оготны тархац нутгийн 24 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаардаг.



**Дэлхийн тархац:** Хятад, Монгол.


**Бүс нутгийн тархац:** Их нуурын хотгор, Нууруудын хөндий, Монгол Алтай, Говь Алтайн нурууны зааг, Алтайн өвөр говь, Зүүнгарын говьд тархана (Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

#### 49. *Microtus maximowiczii* (Schrenk, 1859)

**Түгээмэл нэр:** Ширгийн оготно (Монгол),  
Maximowicz's vole (Англи).

**Ижил нэр:** *M. unguensis* (Wilson, Reeder (1993) нарын  
бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Ширгийн оготны тархац нутгийн 38 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны Хэнтий, Их Хянганы салбар уулсын ойт хээрийн бүсийн ил задгай нутагт тохиолдоно.

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## 50. *Microtus mongolicus* (Radde, 1861)

**Түгээмэл нэр:** Монгол оготно (Монгол), Mongolian vole (Англи).


**Ижил нэр:** *M. baicalensis*, *M. poljakovi*, *M. xerophilus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Монгол оготны тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөлийн Мөнх сарьдаг, Хангайн умард хэсэг, Хэнтий, Их Хянганы уулсын ойт хээрийн бүс, голын хөндий даган байршина. Мөн Монгол Дагуурын хээр, Төв Халхын хээр, Дорнод Монголд тархана (Соколов, Орлов 1980; Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Байгаль болон хүний тавьсан түймрээс шалтгаалж орчны хомсдол нүүрлэх боломжтой боловч энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## 51. *Microtus oeconomus* (Pallas, 1776)

**Түгээмэл нэр:** Мэхээрч оготно (Монгол), root vole, tundra vole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. o. dauricus*, *M. o. altaicus*

**Ижил нэр:** *M. altaicus*, *M. dauricus*, *M. koreni* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Мэхээрч оготны тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаардаг.



**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн Улс, Нидерланд, Герман, Норвеги, Австри, Чех, Швед, Польш, Унгар, Словак, Финланд, Украин, Беларусь, Оросын Холбооны Улс, Казахстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтий нурууд, Их Хянганы салбар уулс, Монгол Дагуурын хээр зэрэг Монгол орны хойд хэсгээр тархсан (Соколов нар, 1985).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## **52. *Myopus schisticolor*** (Lilljeborg, 1844)

**Түгээмэл нэр:** Ойн хөвхөлжин, тайгын хөвдний хөвхөлжин (Монгол), wood lemming (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. s. saianicus*

**Ижил нэр:** *M. middendorfi*, *M. saianicus*, *M. vinogradovi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Ойролцоогоор тархац нутгийн 23 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Норвеги, Швед, Финланд, Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Хангай (Stubbe, Chotolchu, 1968), Хөвсгөлийн Мөнх Сарьдаг уул, Хэнтий нуруугаар тархана (Соколов, Орлов, 1980; Соколов нар, 1985).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## Овог Хулганыхан

### 53. *Apodemus agrarius* (Pallas, 1771)

**Түгээмэл нэр:** Хээрийн хулгана, ангисны галай (Монгол), striped field mouse (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *A. a. mantchuricus*


**Ижил нэр:** *A. coreae*, *A. ognevi*, *A. pallescens* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Хээрийн хулганы тархац нутгийн 52 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Герман, Дани, Австри, Хорват, Польш, Босни Герцоговин, Унгар, Серб, Монтенегро, Словак, Финланд, Грек, Румын, Латви, Литва, Эстони, Украин, Болгар, Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Гүрж, Армен, Азербайжан, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Тайван.

**Бүс нутгийн тархац:** Энэ зүйлийг одоогоор Монгол орны хамгийн баруун хэсэг Их хянганы уулсын зөвхөн Халх, Нөмрөг голоос (Stubbe, Chotolchu, 1968; Дуламцэрэн, 1970) олж тогтоогоод байна.

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 54. *Apodemus peninsulae* (Thomas, 1907)

**Түгээмэл нэр:** Азийн хулгана, модон галай (Монгол), Korean field mouse (Англи).


**Монгол дахь салбар зүйл:** *A. p. preator*

**Ижил нэр:** *A. giliacus*, *A. majusculus*, *A. rufulus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.



**Хамгаалсан байдал:** Азийн хулганы тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаардаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон (Хоккайдо арал).

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий нурууд, Их хянганы уулсаар, Зүүнгарын говь, Монгол Дагуурын ой, ойт хээр, хээрийн бүсээр элбэг тархсан (Соколов, Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Байгаль болон хүний тавьсан түймрээс шалтгаалж орчны хомсдол нүүрлэх боломжтой боловч энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 55. *Micromys minutus* (Pallas, 1771)

**Түгээмэл нэр:** Чигчий хулгана, уран чигчий (Монгол), Eurasian harvest mouse (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. m. ussuricus*

**Ижил нэр:** *M. minimus*, *M. soricinus*, *M. ussuricus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Ойролцоогоор тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаардаг.

**Дэлхийн тархац:** Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Швейцарь, Итали, Дани, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Босни Герцоговин, Унгар, Серб Монтенегро, Финланд, Румын, Македон, Латви, Литва, Эстони, Украйн, Болгар Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Гүрж, Армен, Азербайжан, Хятад, Энэтхэг, Монгол, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Тайван, Япон.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны умард нутгаар нарийн зурвас газарт хязгаарлагдмал тархсан. Монгол Алтай, Хөвсгөл, Хэнтий (Соколов нар, 1985), Их хянганы уулс (Батсайхан, хэвлээгүй мэдээ), Дорнод Монгол, Монгол Дагуурын хээрээр тархсан.

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн тархацын дорнод хэсэгт байгалийн түймэр, малын тэжээл бэлтгэх зорилгоор хадлан хадах зэргээс шалтгаалж амьдрах орчны хомсдол нүүрлэх боломжтой.


## Овог Чичүүлийнхэн

### 56. *Meriones meridianus* (Pallas, 1773)

**Түгээмэл нэр:** Шаргал чичүүл (Монгол), mid-day gerbil, mid-day jird (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. m. psammophilus*, *M. m. buechner*

**Ижил нэр:** *M. heptneri*, *M. roborowskii*, *M. uschtaganicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).




**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Шаргал чичүүлийн тархац нутгийн 17 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Тажикстан, Хятад, Киргизстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны өмнөд нутгийн бүх говь, цөлийн бүс, Монгол Алтайн нуруу, Их нууруудын хотгорт тархсан (Соколов, Орлов, 1980).


**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй амьдрах орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

### 57. *Meriones tamariscinus* (Pallas, 1773)

**Түгээмэл нэр:** Сухайн чичүүл (Монгол), tamarisk gerbil, tamarisk jird (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. t. jaxartensis*

**Ижил нэр:** *M. kokandicus*, *M. satschouensis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын тархац:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй,

B1ab(iii)

**Үнэлгээний үндэслэл:** Энэ ховор зүйл чичүүлд орчны доройтол, хүний дам сүйтгэл аюул



занал учруулж байна. Түүний тархац нутгийн хэмжээ нь 5,000км<sup>2</sup>-аас бага, таваас цөөн байршил нутагт хязгаарлагдмал оршдог, идээшин амьдардаг орчны нөхцөл, чанар нь малд талхлагдсаны улмаас орчны доройтолд орж тархац, идээшил нутаг нь хумигдсаар байгааг харгалзан үзээд В1ab(iii) шалгуураар үнэлэн Устаж болзошгүй хэмээх ангилалд оруулав. Хил залгаа нутгаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшилт тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлдэв.

**Хамгаалсан байдал:** Сухайн чичүүлийн тархац нутгийн 23 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаардаг. Монгол улсын улаан номын удаах хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр бүртгэгджээ (Шийрэвдамба нар, 1997).

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Туркменистан, Узбекистан, Хятад, Киргизстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Зүүнгарын говьд Булган гол, Бодончийн голын адаг, Алтайн өвөр говийн Аж богдын баруун бэл зэрэг цөөн газраас олджээ (Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Амьдрах орчны хомсдол, ялангуяа тэмээ сухайн (*Tamarix ramosissima*) бутыг идэж цөлмөх, талхлах зэргээр бий болж байна. Мөн хүний сүйтгэл, дам нөлөө нь тоо толгойг ховордуулах шалтгаан болсон. Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 58. *Meriones unguiculatus* (Milne-Edwards, 1867)

**Түгээмэл нэр:** Монгол чичүүл, хул чичүүл (Монгол), Mongolian gerbil, Mongolian jird (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. u. unguiculatus*, *M. u. kozlovi*, *M. u. selenginus*. Corbet (1978) эдгээр салбар зүйлийг хүлээн зөвшөөрөөгүй. Монгол дахь салбар зүйлийн ангиллыг нягтлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *M. chihfengensis*, *M. koslovi*, *M. kurauchii*, *M. selenginus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй



**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Монгол чичүүлийн тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Хангайн нурууны өмнөд бие, Хангайн нурууны зүүн хойд хэсгээр урсах Орхон, Сэлэнгийн сав, Төв Халхын хээр, Умард говь, Дорнод говь, Дорнод Монгол зэрэг Монгол орны ихэнх нутгийн хээр, хуурай хээр, цөлжүү хээрт ихэд тархсан (Соколов, Орлов, 1980).



**Ховордлын гол шалтгаан:** Байгалийн болон хүний тавьсан түймэр орчны доройтолд оруулдаг. Малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхлалт бий болж үүний уршгаар орчны доройтол нүүрлэх боломжтой (тодорхой мэдээ шаардлагатай) юм.

### 59. *Rhombomys opimus* (Lichtenstein, 1823)

**Түгээмэл нэр:** Морин чичүүл, морин цөцүүл (Монгол), great gerbil (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *R. o. nigrescens*, Stubbe, Chotolchu (1968) нар уг салбар зүйлийг ялган бичсэн боловч, Corbet (1978) хүлээн зөвшөөрөөгүй. Монгол дахь салбар зүйлийн ангиллыг нягтлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *R. alaschanicus*, *R. nigrescens*, *R. pallidus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй


**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Морин чичүүлийн тархац нутгийн 35 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаардаг.

**Дэлхийн тархац:** Иран, Казахстан, Афганистан, Пакистан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь, Умард говь, Дорнод говь зэрэг Монгол орны өмнөд нутгийн цөл болон цөлөрхөг хээрээр тархана (Соколов, Орлов, 1980). Морин чичүүл говь, цөлийн загт бүлгэмдэлтэй нутагт илүү тархан амьдардаг (M. Stubbe, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй амьдрах орчны доройтол нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандны ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.




## Овог Номингийнхон

### 60. *Myospalax aspalax* (Pallas, 1776)

**Түгээмэл нэр:** Сохор номин (Монгол), false zokor (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. a. hangaicus*

**Ижил нэр:** *M. armandii*, *M. dybowskii*, *M. talpinus*, *M. zokor* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Сохор номингийн тархац нутгийн 18 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.


**Бүс нутгийн тархац:** Монгол орны зүүн хойд хэсгээр, Хангай нурууны зүүн хэсэг, Хэнтий нуруу, Монгол Дагуурын хээрээр тохиолдоно (Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 61. *Myospalax psilurus* (Milne-Edwards, 1874)

**Түгээмэл нэр:** Манжуур номин, Манж номин (Монгол), Transbaikal zokor, Manchurian zokor (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. p. epsilanus*



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Манжуур номингийн тархац нутгийн 31 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их хянганы уулсад Халх, Нөмрөг голын сав газраар тохиолдоно (Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## Баг Туулайтан

### Овог Огдойнхон

#### 62. *Ochotona alpina* (Pallas, 1773)

**Түгээмэл нэр:** Тагийн огдой (Монгол), alpine pika (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *O. a. nitida*, *O. a. changaica*. Гуреев (1964) эдгээр салбар зүйлийг *O. a. alpina*-гийн хэлбэр гэж үзжээ. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *O. changaica*, *O. nitida* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй


**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Тагийн огдойн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Хангай, Хөвсгөлийн уулсаар, Их нууруудын хотгорын хойд, Нууруудын хөндийн хойд нутгаар тархана (Цэвэгмид, Цэнджав, 2004).

**Ховордлын гол шалтгаан:** Монголын өндөр уулсаар хязгаарлагдмал популяци байгаа нь ховордлын шалтгаан болж байна. Ялангуяа дэлхийн дулаарал нөлөөлөх эсэх нь эргэлзээтэй хэвээр байна (А. Smith, аман мэдээ). Арьсыг гадаадад худалдаалах зорилгоор агнадаг байсан бөгөөд энэ зүйлийн хувьд хор уршиг багатай юм (Wingard, Zahler, 2006).



### 63. *Ochotona dauurica* (Pallas, 1776)

**Түгээмэл нэр:** Дагуур огдой (Монгол), Daurian pika (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *O. d. dauurica*, *O. d. altaina*, *O. d. mursaevi*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *O. altaina*, *O. bedfordi*, *O. mursaevi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Дагуур огдойн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны ихэнх нутгаар тархсан (Соколов, Орлов, 1980; Цэвэгмид, Цэнджав, 2004). *O. d. altaina* салбар зүйлийг Их нууруудын хотгорын өрнөд болон өмнөд нутгаас олжээ (Stubbe, Chotolchu, 1968).

**Ховордлын гол шалтгаан:** Урьд нь Орос улсад арьсыг нь худалдаалах зорилгоор агнадаг байсан хэдий ч одоо энэ үйл ажиллагаа зогссон. Малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхлалт бий болж, үүний уршгаар орчны хомсдол нүүрлэж болзошгүй байна (тодорхой мэдээ шаардлагатай). Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онуудад үлийн цагаан оготны (*Lasiopodomys brandti*) тоо толгойг зохицуулахад хэрэглэж буй Бромациолоне химийн хорт бодисонд дам өртөж хорогдох нь бий. Энэ үйл ажиллагаа одоогоор зогссон ч түүний нөлөө бусад зүйлд нөлөөлсөөр байна (Н. Батсайхан, аман мэдээ).

### 64. *Ochotona hyperborea* (Pallas, 1811)

**Түгээмэл нэр:** Асганы огдой (Монгол), northern pika (Англи).




**Монгол дахь салбар зүйл:** *O. h. mantchurica*

**Ижил нэр:** *O. mantchurica*, *O. svatoshi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.



**Хамгаалсан байдал:** Асганы огдойн тархац нутгийн 40 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.


**Бүс нутгийн тархац:** Их Хянганы уулс, Хэнтий нуруу, Монгол Дагуурын хээрийн ойт нутгаар тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Stubbe, Chotolchu, 1971; Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Монголын өндөр уулсаар хязгаарлагдмал популяци байгаа нь ховордлын шалтгаан болж байна. Ялангуяа дэлхийн дулаарал нөлөөлөх эсэх нь эргэлзээтэй хэвээр байна (А. Smith, аман мэдээ). Арьсыг гадаадад худалдаалах зорилгоор агнадаг бөгөөд энэ нь хор уршиг багатай юм (Wingard, Zahler, 2006).

### 65. *Ochotona pallasii* (Gray, 1867)

**Түгээмэл нэр:** Үхэр огдой (Монгол), Pallas's pika (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *O. p. pricei*



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Монгол огдойн тархац нутгийн 17 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун болон өмнөд нутгийн уулсаар, ялангуяа Монгол Алтай, Говийн Алтайн уулсаар ихэд тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980; Цэвэгмид, Цэнджав, 2004).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.


## Овог Туулайнхан

### 66. *Lepus timidus* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Чандага туулай (Монгол), Arctic hare, mountain hare (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *L. t. transbaicalicus*

**Ижил нэр:** *L. alpinus*, *L. borealis*, *L. transbaicalicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд чандага агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Чандага туулайн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагджээ.



**Дэлхийн тархац:** Канад, Гренланд, Исланд, Ирланд, Франц, Их Британи, Герман, Норвеги, Лихтенштейн, Швейцарь, Итали, Австри, Словен, Швед, Польш, Финлянд, Латви, Литва, Эстони, Украин, Беларусь, Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Япон.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтий, Монгол Дагуурын хээр, Их хянганы уулсын ой, хөвч тайгад их тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980).


**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын хэмжээнд уламжлалт анагаах ухаанд мах, арьсыг нь эм бэлдмэлийн түүхий эд болгон худалдах зорилгоор цөөн хэмжээгээр агнадаг.

## 67. *Lepus tolai* Pallas, 1778

**Түгээмэл нэр:** Бор туулай (Монгол), tolai hare (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *L. t. tolai*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *L. brevinasus*, *L. gobicus*, *L. zaisanicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** ‘ДБХХ-ны Улаан дансны ангилал болон шалгуур’ (IUCN, 2001) ашиглан үнэлгээ хийгээгүй болно.

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Бор туулайн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагджээ.



**Дэлхийн тархац:** Иран, Казахстан, Афганистан, Хятад, Монгол (Павлинов нар, 2002).

**Бүс нутгийн тархац:** Монгол орны тагийн бүсээс бусад бүх нутгаар тархана. Цөлөрхөг хээр болон хээрийн өөр өөр хэв шинж бүхий нутгаар элбэг тохиолдоно (Соколов, Орлов, 1980; Цэвэгмид, Цэнджав, 2004).

**Ховордлын гол шалтгаан:** Уламжлалт анагаах ухаанд болон мах, арьсыг нь хэрэглэх үүднээс агнадаг бөгөөд олон улсын хэмжээний худалдаа бага байдаг. Хааяа үнэг (*Vulpes vulpes*), хярс (*Vulpes corsac*) зэрэг ангууч амьтанд тавьсан хавх, урхинд өртөх нь бий.

## Баг Зараатан

### Овог Зарааныхан

#### 68. *Hemiechinus auritus* (Gmelin, 1770)

**Түгээмэл нэр:** Дэлдэн зараа (Монгол), long-eared hedgehog (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *H. a. aegyptius*, *H. a. albulus*, *H. a. holdereri*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *H. alaschanicus*, *H. microtus*, *H. caspicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй


**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Дэлдэн зарааны тархац нутгийн 17 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Араб, Грек, Египет, Кипр, Турк, Израйль, Ливан, Сири, Ирак, Иран, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Киргизстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны өмнөд, баруун болон баруун умард нутгийн цөл, цөлөрхөг хээрийн бүс нутгаар, тухайлбал Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Говь Алтай нуруу, Умард говь, Дорнод говь, Алтайн өвөр говь, Алашань говьд тархан амьдардаг (Соколов, Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Газрын доорхи нөөцийг олборлох (уул уурхай) үйл ажиллагааны улмаас орчны хомсдол нүүрлэх болсон. Хааяа машин тэргэнд дайруулан осолддог.



## 69. *Mesechinus dauuricus* (Sundevall, 1842)

**Түгээмэл нэр:** Дагуур зараа (Монгол), Daurian hedgehog (Англи).

**Ижил нэр:** *M. manchuricus*, *M. przewalskii*, *M. sibiricus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёрдох хэвлэлд ховор зэрэглэлд оруулжээ (Шийрэвдамба нар, 1997). Дагуур зарааны тархац нутгийн 7 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны зүүн умард нутгийн тал ойт хээр, хээр, тухайлбал Их Хянганы нурууны Халх голын сав, Хангайн нурууны зүүн хойд нутгийг дайран урсдаг Орхон, Сэлэнгэ голын сав (Соколов, Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989), Монгол Дагуурын Хээр, Дорнод Монгол хээрт тархана. Их нартын чулуу байгалийн нөөц газрын умард нутагт саяхан тэмдэглэгдэв (Reading нар, 2006).

**Ховордлын гол шалтгаан:** Орон нутагт уламжлалт анагаах ухаанд ашиглах зорилгоор агнадаг. Нөөцийн олборлолтын (уул уурхай) үйл ажиллагаанаас орчны хомсдол нүүрлэсний зэрэгцээ малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхлалт орчны доройтлыг бий болгож байна (тодорхой мэдээ шаардлагатай). Хааяа (ялангуяа хатуу хучилттай зам дээр) машин тэргэнд дайруулан осолддог.


## Баг Шавьж идэштэн

### Овог Атаахайнхан

#### 70. *Crocidura sibirica* Dukelsky, 1930

**Түгээмэл нэр:** Малтаахай, Шивэр жөвүү (Монгол), Siberian shrew (Англи).

**Ижил нэр:** *C. ognevi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Энэ зүйлийн тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагджээ.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Энэ зүйл өмнө нь *C. suaveolens* нэрээр бүртгэгдэж байсан тул түүний тархац нь сүүлд өөрчилсөн зүйлд хамаарах болно. Монгол орны Хангайн нуруу, Алтайн нуруудын салбар уулс хоорондын хөндий, Алтайн өвөр говь цөлийн баянбүрд, цөлөрхөг хээрийн булаг шанд, айлын худаг орчимд, өндөр уулс зэрэг арван байршил нутагт тэмдэглэгджээ (Соколов, Орлов, 1980). Саяхан Алашань говь (2004 онд тэмдэглэсэн), Дорнод говь (2004 онд тэмдэглэсэн), төв Монгол (2005 онд тэмдэглэсэн) болон Нууруудын хөндийгөөс (2005 онд тэмдэглэсэн) олдов (Батсайхан, Stubbe, хэвлээгүй мэдээ).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## 71. *Neomys fodiens* (Pennant, 1771)

**Түгээмэл нэр:** Усч гэрэлзгэнэ (Монгол), Eurasian water shrew (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *N. f. orientis*

**Ижил нэр:** *N. aquaticus*, *N. daubentonii*, *N. orientalis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Усч гэрэлзгэний тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвеги, Лихтенштейн, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Босни Герцеговин, Унгар, Серб Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Болгар, Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс; Киргизстанаас олдох боломжтой гэж үздэг.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны умард нутгийн гол мөрний саваар ихэд тархсан. Хэнтий нуруунд Хараа голд, Монгол Алтайд Ховд голын эх (Соколов, Орлов, 1980), Хангайн нурууны баруун умард нутагт Тэс, Завхан голын сав (Банников, 1954; Дуламцэрэн нар, 1989), Хангайн нурууны дорнод нутагт Орхон, Сэлэнгийн дагуу нутгаас (Соколов нар, 1985) тус тус олджээ. Их нууруудын хотгорын өрнөд нутагт Чоно харайх голд хожуухан тэмдэглэгдсэн (Samiya нар, 1993).

**Ховордлын гол шалтгаан:** Уул уурхай, мод бэлтгэл зэрэг байгалийн нөөц олборлох үйл ажиллагаа ихэссэний уршгаар усны бохирдол, орчны хомсдол, хүний садаа үүсч байна.

## 72. *Sorex caecutiens* Laxmann, 1788

**Түгээмэл нэр:** Дааган атаахай (Монгол), Laxmann's shrew (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. c. caecutiens*

**Ижил нэр:** *S. altaicus*, *S. karpinskii*, *S. macropygmaeus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй


**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Дааган атаахайн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Норвеги, Швед, Польш, Финланд, Латви, Литва, Эстони, Украин, Беларусь, Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс.

**Бүс нутгийн тархац:** Хэнтий, Хангайн нуруу, Хөвсгөлийн хөвч тайга, ойт хээрийн бүс, Монгол Алтайн уулсын умард нутаг, Монгол Дагуурын хээрт тохиолдоно (Соколов, Орлов, 1980; Mallon, 1985; Дмитриев нар, 1992; Самъяа нар, 2002).

**Ховордлын гол шалтгаан:** Уул уурхай, мод бэлтгэл зэрэг байгалийн нөөц олборлох үйл ажиллагаа ихэссэний уршгаар усны бохирдол, орчны хомсдол, хүний садаа зэрэг нь тоо толгой хорогдоход нөлөөлж болзошгүй.



## 73. *Sorex daphaenodon* Thomas, 1907

**Түгээмэл нэр:** Бэсрэг атаахай (Монгол), large-toothed Siberian shrew (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. d. scaloni*


**Ижил нэр:** *S. orii*, *S. sanguinidens*, *S. scaloni* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Бэсрэг атаахайн тархац нутгийн 7 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол. Европт тархан орших боломжтой.


**Бүс нутгийн тархац:** Хангайн нурууны дорнод нутагт Орхон, Сэлэнгийн сав (Chotolchu, Stubbe, 1971; Соколов нар, 1985), Хэрлэн голын дунд урсгал болон эхэнд (Самъяа нар, 2002), Төв Халх, Дорнод Монгол, Монгол Дагуурын хээр, Их Хянганы салбар уулсаар тархсан (Дмитриев, Таракановский, 1984).

**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт мод бэлтгэлээс үүдэлтэй орчны хомсдол бий болсон. Байгалийн болон хүний тавьсан түймэр мөн ховордуулах шалтгаанууд болж байна.

#### 74. *Sorex isodon* Turon, 1924

**Түгээмэл нэр:** Тэгш шүдэт атаахай, тэгш атаахай (Монгол), even-toothed shrew (Англи).

**Ижил нэр:** *S. gravesi*, *S. princeps*, *S. ruthenus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Энэ зүйл атаахайн тархац

нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Норвеги, Швед, Финланд, Оросын Холбооны Улс, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс; Хятадаас олдох боломжтой.

**Бүс нутгийн тархац:** Хэнтий нурууны баруун өмнөд нутгаас Сөгнөгөр голын сав, Хэнтий нурууны дорнод нутагт Зүүнбүрх орчим (Швецов нар, 1980), Хэнтий нурууны баруун нутаг Ерөө голын эхэнд тэмдэглэгдсэн (Самъяа нар, 2002). Мөн Монгол Дагуурын зарим нутгаар тохиолддог. Монгол улс энэ зүйлийн дэлхийн тархацын өмнөд хил нь болдог.


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**75. *Sorex minutissimus* Zimmermann, 1780**

**Түгээмэл нэр:** Өөдсөн атаахай (Монгол), least shrew, miniscule shrew (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. m. tsherskii*, *S. m. caudata*

**Ижил нэр:** *S. barabensis*, *S. minimus*, *S. ussuriensis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Өөдсөн атаахайн тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Норвеги, Швед, Финланд, Эстони, Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтайн уулс, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Хангай болон Хэнтий нуруу, Монгол Дагуурын хээрт бүх биотопод, ялангуяа голын татамд тархсан. Мөн Төв Халхын хээр, Монгол орны зүүн хэсгийн Их Хянганы уулсад тэмдэглэгдсэн байна (Соколов нар, 1985; Дмитриев нар, 1992; Литвинов, Базардорж, 1992).


**Ховордлын гол шалтгаан:** Тархац нутгийн зарим хэсэгт уул уурхай, эрчимтэй мод бэлтгэлээс үүдэн хүний садаа болон орчны хомсдол бий болох боломжтой. Байгалийн болон хүний тавьсан түймэр мөн ховордуулах шалтгаанууд болоод байна.

**76. *Sorex roboratus* Hollister, 1913**

**Түгээмэл нэр:** Тавшгар атаахай, бор атаахай (Монгол), flat-skulled shrew (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. r. roboratus*, *S. r. thomasi*

**Ижил нэр:** *S. aranoides*, *S. platycranius*, *S. vir* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Тавшгар атаахайн тархац нутгийн 10 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Хэнтийд Онон голын савын зарим газар (Chotolchu, Stubbe, 1971), Ерөө голын эх (Самъяа нар, 2002), Хөвсгөл орчим тархсан (Даваа нар, 1973; Литвинов, Базардорж, 1992).


**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт мод бэлтгэлээс үүдэлтэй хүний садаа болон орчны хомсдолд хүргэх боломжтой. Байгалийн болон хүний тавьсан түймэр ховордуулах шалтгаанууд болоод байна.

## 77. *Sorex tundrensis* Merriam, 1900

**Түгээмэл нэр:** Цармын атаахай (Монгол), tundra shrew (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. t. baikalensis*, *S. t. sibiriensis*

**Ижил нэр:** *S. baikalensis*, *S. schnitnikovi*, *S. sibiriensis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Цармын атаахайн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтайн нуруу (Соколов нар, 1985), Их нууруудын хотгор, Хангай нуруу (Дмитриев нар, 1992), Хөвсгөл уулсаар тархсан (Литвинов, 1982; Литвинов, Базардорж, 1992), бөгөөд Хэнтий нурууны дорнод этгээдээс Төв Халхын хээрийг дамжин дорнод Монголын тал хээр, Онон, Хэрлэн голын сав, Монгол Дагуурын Улз голын саваар (Соколов нар, 1985) тус тус тохиолдоно.


**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт мод бэлтгэл зэрэг нөөцийн олборлолын уршгаар орчны хомсдолд хүргэх боломжтой. Байгалийн болон хүний тавьсан түймэр ховордуулах шалтгаанууд болоод байна.

## Овог Чацуулиныхан

### 78. *Talpa altaica* Nikolsky, 1883

**Түгээмэл нэр:** Алтайн чацуулин (Монгол), Siberian mole (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *T. a. suschkini*



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёрдох хэвлэлд (Шийрэвдамба нар, 1997) ховор зэрэглэлээр оруулсан. Чацуулины тархац нутгийн 16 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөл орчмын бүс нутагт хоёр байршлыг тэмдэглэсэн. Мөн Их нууруудын хотгорын умард хэсэгт тохиолдоно (Банников, 1954). Тархацын өмнөд хил нь Тэсийн голын дунд урсгал орчмоор хязгаарлагддаг гэж тэмдэглэжээ (Банников, 1954).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.


## Баг Гар далавчтан

### Овог Багваахайнхан

#### 79. *Eptesicus gobiensis* Bobrinskii, 1926

**Түгээмэл нэр:** Говийн сармаахай, говьсог сарсаахай (Монгол), Gobi big brown bat (Англи).

**Ижил нэр:** *E. centralasiaticus*, *E. kashgaricus*.




**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Говийн сармаахайн тархац нутгийн 17 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Афганистан, Пакистан, Хятад (Шинжан, Шизан), Энэтхэг, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтайн нуруу, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Говь Алтайн нуруу, Хангайн нурууны өмнөд нутаг, Төв Халхын хээрийн өмнөд нутаг, Умард говь, Дорнод говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говьд тохиолдоно (Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Жил дараалсан ган гачиг, булаг, шандны ширгэлт, татралт нь энэ зүйлийн тоо толгой хорогдох шалтгаан хэдий ч, хүний үйл ажиллагаа эсвэл байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна. Их нууруудын хотгорын Чоно харайх голд барьж буй усан цахилгаан станцын далангийн байгууламж нь голын цутгал хүртэлх гольдрил дагууд орчны хомсдол, сүйтгэл бий болгох боломжтой байна. Малын хашаа саравчийг буулгаж, нүүлгэснээс орогнодог үүр, төрмөлийг эвдэж, сүйтгэх зэрэг нь хорогдлын шалтгаан болж байгаа боловч эдгээрийн нөлөөлөл нь бага байна.

## 80. *Eptesicus nilssoni* (Keyserling, Blasius, 1839)

**Түгээмэл нэр:** Умардын сармаахай, умрын сарсаахай (Монгол), northern bat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *E. n. nilssoni*

**Ижил нэр:** *E. japonensis*




**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Умардын сармаахайн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Франц, Бельги, Нидерланд, Герман, Норвеги, Швейцарь, Итали, Австри, Чех, Словен, Швед, Польш, Унгар, Словак, Финланд, Румын, Латви, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Ирак, Гүрж, Иран, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс; Японы арлаас олдох боломжтой.


**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай нурууны баруун умард ойт нутаг, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуурын хээр, Дорнод Монгол зэрэг Монгол орны хойд нутгаар түгээмэл тархсан (Соколов, Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989). Энэ зүйлийн дэлхийн тархацын өмнөд хил Монгол орны ойт нутгийн өмнөд захаар хязгаарлагдана (Стрелков, 1986).

**Ховордлын гол шалтгаан:** Тархац нутгийн зарим газарт дэд бүтцийн хөгжил, байгалийн нөөцийн олборлолт (уул уурхай) зэргийн өсөлтөөс орчны хомсдол нүүрлэж байна. Малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхлалт бий болж ойн нөхөн сэргээлтэд саад учруулж орчны доройтолд хүргэж байгаа нь үүрлэж хоноглоход нөлөөлж байна (тодорхой мэдээ шаардлагатай). Энэ зүйл сармаахай нь бусад хөнөөлт зүйлийн тоо толгойг зохицуулах үйл ажиллагаанд дам өртөх нь бий.

## 81. *Hypsugo savii* (Bonaparte, 1837)

**Түгээмэл нэр:** Борхон турсаахай (Монгол), Savi's pipistrelle (Англи).


**Монгол дахь салбар зүйл:** *H. s. caucasicus*, *H. s. alaschanicus*. Монгол дахь салбар зүйлийн судалгааг гүнзгийрүүлэн хийх шаардлагатай.



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Борхон турсаахайн тархац нутгийн 23 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Марокко, Алжир, Капи Верди, Испани, Франц, Герман, Итали, Тунис, Словен, Грек, Украин, Болгар, Турк, Израйль, Ливан, Гүрж, Иран, Казахстан, Афганистан, Хятад, Энэтхэг, Монгол, Мьянмар, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун өмнөд хэсэг болох Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Нууруудын хөндий, Говь Алтай нуруу, Умард говийн баруун нутаг, Дорнод говь, Алашань говьд тархсан.


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## 82. *Murina leucogaster* Milne-Edwards, 1872

**Түгээмэл нэр:** Цорго хамарт багваахай, ацай (Монгол), greater tube-nosed bat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** Монгол дахь салбарын зүйлийн судалгаа хараахан хийгдээгүй байна.

**Ижил нэр:** *M. hilgendorfi*, *M. rubex*, *M. sibirica* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Цорго хамарт багваахайн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны Хөвсгөл, Баруун умард Хэнтийн тайгын бүсэд хязгаарлагдмал тархан амьдардаг (Б. Шефтель, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 83. *Myotis brandti* (Eversmann, 1845)

**Түгээмэл нэр:** Ойсог багваахай (Монгол), Brandt's bat (Англи).

**Ижил нэр:** *M. aureus*, *M. fujiensis*, *M. gracilis*, *M. sibiricus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг



**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Ойсог багваахайн тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Лихтенштейн, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Швед, Польш, Унгар, Словак, Албани, Грек, Румын, Латви, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Казахстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөл, Хангай, Хэнтий нуруу, Монгол Дагуурын хээр, Дорнод Монгол, Их Хянганы салбар уулсад Халх, Нөмрөг голын сав нутгаар тархсан (Банников, 1954; Соколов, Орлов, 1980; Tinnin нар, 2002).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.



### 84. *Myotis daubentonii* (Kuhl, 1817)

**Түгээмэл нэр:** Уссаг багваахай (Монгол), Daubenton's bat (Англи).



**Монгол дахь салбар зүйл:** *M. d. volgensis*, *M. d. ussuriensis*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Уссаг багваахайн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.




**Дэлхийн тархац:** Ирланд, Португал, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвеги, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Швед, Польш, Унгар, Словак, Финланд, Румын, Латви, Турк, Оросын Холбооны Улс, Хятад, Энэтхэг, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс; Японоос олдох боломжтой.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны умард нутгийн ус, гол бүхий нутгаар нэлээд өргөн тархацтай. Монгол Алтайн нуруу, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Хангай, Хэнтий нуруу, Монгол Дагуурын хээр, Төв Халхын умард хэсэг, Дорнод Монголын хойд нутгаар тархсан (Stubbe, Chotolchu, 1968; Дуламцэрэн, 1970).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгаан нь бага мэдэгдэж байгаа хэдий ч усны мандлаас идэш шүүрч хооллодог тул усны бохирдол, элдэв далангийн байгууламжийн улмаас амьдрах орчин нь хуваагдалд орж болзошгүй.

### 85. *Myotis ikonnikovi* Ognev, 1912

**Түгээмэл нэр:** Иконниковын багваахай (Монгол), Ikonnikov's bat (Англи).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Энэ зүйлийн тархац нутгийн 36 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Их хянганы уулсын умард хэсгээр тархсан (Банников, 1954).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

## 86. *Myotis mystacinus* (Kuhl, 1817)

**Түгээмэл нэр:** Сахалт багваахай (Монгол), whiskered bat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. m. mystacinus*, *M. m. przewalskii*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *M. aureus*, *M. collaris*, *M. przewalskii* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).




**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Сахалт багваахайн тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Ирланд, Португал, Марокко, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвеги, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Польш, Унгар, Словак, Албани, Финланд, Грек, Латви, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Армени, Иран, Афганистан, Пакистан, Хятад, Энэтхэг, Балба, Монгол, Мьянмар, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Малайз, Сингапур, Лаос, Япон; Ливанаас олодох боломжтой.


**Бүс нутгийн тархац:** Монгол оронд нэлээд өргөн тархсан. Хангай, Хөвсгөл, Хэнтий нуруу, Их нуурын хотгор, Нууруудын хөндий (Батсайхан нар, 2004), Алтайн өвөр говь, Алашань говь, Зүүнгарын говь, Монгол Алтай, Говь Алтайн нуруу, Дорнод говьд тархсан (Банников, 1954; Stubbe, Chotolchu, 1968; Соколов, Орлов, 1980; Стрелков, 1983).

**Ховордлын гол шалтгаан:** Тархацын зарим нутагт жил дараалсан ган гачиг, булаг, шандны ширгэлт, татралт нь энэ зүйлийн тоо толгой хорогдох шалтгаан хэдий ч хүний үйл ажиллагаа эсвэл байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна. Усны бохирдол, байгалийн нөөц олборлолт өсөх хэрээр орчны хомсдол нүүрлэх болов.

### 87. *Nyctalus noctula* (Schreber, 1774)

**Түгээмэл нэр:** Бүрэнхийн хонгор багваахай, хонгор бүрэнхийвч (Монгол), noctule (Англи).


**Ижил нэр:** *N. magnus*, *N. rufescens*, *N. velutinus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Дэлхийн тархац:** Португал, Марокко, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Люксембург, Швейцарь, Итали, Дани, Малта,

Австри, Чех, Словен, Польш, Словак, Албани, Грек, Румын, Латви, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Ливан, Израйль, Иран, Казахстан, Оман, Пакистан, Хятад, Энэтхэг, Монгол, Малайз, Вьетнам, Хонконг, Тайваны арал, Япон; Мозамбикаас олодох боломжтой.

**Бүс нутгийн тархац:** Монголд зөвхөн Их нууруудын хотгор, Ховд голын хөндий, Онгоцны улаан уул орчимд тэмдэглэгдсэн (Samiya нар, 1993).



**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 88. *Plecotus auritus* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Жижиг соотон багваахай, жижиг соотгой, бор соотон багваахай (Монгол), brown long-eared bat, brown big-eared bat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *P. a. auritus*, *P. a. wardi*, *P. a. sacrimontis*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *P. communis*, *P. sacrimontis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү). Саяхны морфологи болон генетик судалгааны дүнд Монгол орны *P. auritus* зүйлийн популяцийг *P. ognevi* бие даасан зүйл болгон салгасан бөгөөд салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай (Spitzenberger нар, 2006).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Бор соотон багваахайн тархац нутгийн 10 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Ирланд, Португал, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвеги, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Швед, Польш, Словак, Финланд, Румын, Латви, Украин, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Гурж, Иран, Хятад, Балба, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Хангай, Хэнтий нуруу зэрэг Монгол орны умард нутгаар тархсан (Stubbe, Chotolchu, 1968; Соколов, Орлов, 1980; Spitzenberger нар, 2006). Монгол Дагуурын хээр, Дорнод Монголоос хожуу олджээ (Дорждэрэм, 2004).

**Ховордлын гол шалтгаан:** Одоогоор энэ зүйлийн ховордлын шалтгааныг тодруулах боломж хомс хэдий ч ойрын ирээдүйд байгалийн нөөц олборлолт, мод бэлтгэл эрчимжвэл орчны хомсдол нүүрлэж болзошгүй.

### 89. *Plecotus austriacus* (Fischer, 1829)

**Түгээмэл нэр:** Том соотон багваахай, том соотгой, саарал соотон багваахай (Монгол), grey long-eared bat, grey big-eared bat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *P. a. kozlovi*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *P. ariel*, *P. wardi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү). Саяхны морфологи болон генетик судалгааны дүнд Монгол орны *P. austriacus* зүйлийн популяцийг *P. kozlovi* бие даасан зүйл болгон салгасан бөгөөд салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай (Spitzenberger нар, 2006).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Том соотон багваахайн тархац нутгийн 21 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Ирланд, Португал, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвеги, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Швед, Польш, Словак, Финланд, Румын, Латви, Украин, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Гүрж, Иран, Хятад, Балба, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.




**Бүс нутгийн тархац:** Монгол Алтайн нуруу, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Говь Алтайн нуруу, Их нуурын хотгор, Нууруудын хөндий, Алашань говь, Дорнод говийн баруун хэсгээр тархсан (Соколов, Орлов, 1980). Хангайн нурууны зүүн хэсэг Орхон голын эхээр (Stubbe, Chotolchu, 1968) тохиолдоно.

**Ховордлын гол шалтгаан:** Хүний суурьшил шүтэж байрших нь нэлээд элбэг тул хүний садаа (төрмөл, үүр ноохойг нь эвдэх, хүн эгдүүцэж хороох) ховордуулах шалтгааныг бүрдүүлдэг. Жил дараалсан ган гачиг, булаг, шандны ширгэлт, татралт энэ зүйлийн тоо толгой хорогдуулах шалтгаан хэдий ч хүний үйл ажиллагаа эсвэл байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна.

## 90. *Vespertilio murinus* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Буурал сармаахай (Монгол), particoloured bat (Англи).

**Ижил нэр:** *V. discolor*, *V. luteus*, *V. siculus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).




**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Буурал сармаахайн тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Франц, Их Британи, Нидерланд, Герман, Норвеги, Итали, Дани, Чех, Словен, Швед, Польш, Словак, Финланд, Грек, Латви, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Иран, Афганистан, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс.


**Бүс нутгийн тархац:** Анх 1964 онд Их нууруудын хотгорт Шаргын говиос олж тэмдэглэжээ (Stubbe, Chotolchu, 1968). Монгол орны Хэнтий, Хангай (Tinnin нар, 2002), Нууруудын хөндий (Соколов, Орлов, 1980), Дорнод Монголын Ганга нуур (Дмитриев, Таракановский, 1984), Алашань говь (Дорждэрэм, 2004; Батсайхан, хэвлээгүй мэдээ), Хөвсгөлийн Үүр-Уйлган голын бэлчирт (Dolch нар, хэвлээгүй мэдээ) тархан амьдарна.

**Ховордлын гол шалтгаан:** Хүний суурьшил шүтэж байрших нь нэлээд элбэг тул хүний садаа (төрмөл, үүр ноохойг нь эвдэх, хүн эгдүүцэж хороох) ховордуулах шалтгааныг бүрдүүлдэг. Жил дараалсан ган гачиг, булаг, шандны ширгэлт, татралт энэ зүйлийн тоо толгойг хорогдуулах шалтгаан хэдий ч хүний үйл ажиллагаа эсвэл байгаль орчны өөрчлөлтийн алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна. Цаашид байгалийн нөөцийн олборлол (мод бэлтгэл) эрчимжвэл орчны доройтолд орж болно.

**91. *Vespertilio superans* Thomas, 1899**

**Түгээмэл нэр:** Дорнын сармаахай (Монгол), Asian particolored bat (Англи).

**Ижил нэр:** *V. anderssoni*, *V. motoyoshii*, *V. orientalis* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номын хоёрдох хэвлэлд ховор зэрэглэлд оруулжээ (Шийрэвдамба нар, 1997). Дорнын сармаахайн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Тайван, Япон.

**Бүс нутгийн тархац:** Дорнод монголын хээрт (Stubbe, Chotolchu, 1968; Соколов, Орлов, 1980) Хэрлэн, Халх гол, Буйр нуурын орчимд (Банников, 1954; Соколов, Орлов, 1980; Дорждэрэм, 2004) энэ зүйл сармаахай тус тус тэмдэглэгджээ.

**Ховордлын гол шалтгаан:** Хүний суурьшил шүтэж байрших нь нэлээд элбэг тул хүний садаа (төрмөл, үүр ноохойг нь эвдэх, хүн эгдүүцэж хороох) ховордуулах шалтгааныг бүрдүүлдэг. Цаашид байгалийн нөөцийн олборлол (мод бэлтгэл) эрчимжвэл орчны доройтолд орж болно.

## Баг Махчтан


### Овог Мийнхэн

#### 92. *Felis silvestris* Schreber, 1775

**Түгээмэл нэр:** Цоохондой мий (Монгол), wild cat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *F. s. shawiana*

**Ижил нэр:** *F. ferus*, *F. kozlovi*, *F. libyca* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү). Евроазийн, Африкийн популяциудын ангилал зүй, мөн *F. libyca* болон *F. silvestris* зүйлүүдийн ангилал зүй болон удам төрлийн холбоо нь тодорхойгүй хэвээр байна.



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт II-т орсон

(UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай (2000) хуулийн дагуу 2001 онд гарсан тогтоолоор (Засгийн газрын тогтоол №264) ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Алтанзул, 2005), Ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтад орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Энэ зүйлийн тархац нутгийн 19 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Бүх Европоор, Төв Ази, Африкаар тархсан (Nowak, 1991).

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтайн Шаргын говь, Умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь зэрэг цөл, цөлөрхөг тал хээрийг хамарсан өргөн уудам нутагт алаг цоог тархсан (Банников, 1954). Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дорнод говь, Алашань говиор тархсан (Дуламцэрэн нар, 1989). Дэлхийн тархалтын зүүн хойд хил нь Монгол юм.


**Ховордлын гол шалтгаан:** Гэрийн мууртай эрлийзжиж зэрлэг муурийн цэвэр генийг бууруулж байгаа нь ховордлын шалтгаан гэж үзэж байна. Мөн гэрийн муур энэ зүйлтэй газар нутгийн болон идэш бологчийн төлөө өрсөлдөж, халдварт өвчнийг дамжуулдаг. Арьсыг нь ашиглах зорилгоор бага хэмжээгээр агнадаг, үнэг (*Vulpes vulpes*), хярс (*Vulpes corsac*), шилүүсэнд (*Lynx lynx*) тавьсан хавх занганд орж үхдэг.

### 93. *Lynx lynx* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Еврази шилүүс, буурал шүлүүс (Монгол), Eurasian lynx (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *L. l. isabellina*


**Ижил нэр:** *L. isabellina*, *L. kozlovi*, *L. vulgaris* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн Монголын популяцийн тоо толгойн өөрчлөлтийн талаарх баттай судалгаа хомс байна. Энэ зүйлийн тархац нутгийн хүрээнд их хэмжээгээр агнадаг байна. Цаашид популяцийн талаарх мэдээ баримт их хуримтлагдан, үүний зэрэгцээ хамгааллын арга хэмжээ авахгүй байвал энэ зүйлийг А шалгуураар дахин үнэлэн ховордлын ангиллыг өөрчилж болох юм. Хил залгаа нутгаас мэдэгдэхүйц нүүдэл суурьшилт тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.



**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт II-г орсон (UNEP-WCMC, 2006). *L. l. isabellina*-г Монгол улсын амьтны аймгийн тухай (2000) хуулийн дагуу 2001 онд гарсан тогтоолоор (№264) ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Алтанзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Засгийн газар олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 1,800 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Евразийн шилүүсийн тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Испани, Франц, Герман, Норвеги, Швейцарь, Итали, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Унгар, Серб, Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Латви, Литва, Македон, Эстони, Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Молдав, Ирак, Гүрж, Армен, Иран, Азербайжан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Монгол, Бутан, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс.

**Бүс нутгийн тархац:** Монгол оронд өргөн тархсан боловч тархалт нь жигд бус. Ихэнхдээ Хөвсгөлийн тайгын бүсэд тархсан. Ялангуяа Дархад, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумдын ойг бүсэд илүү элбэг тохиолдоно (Дуламцэрэн, 1970). Говийн өмнөд хэсгийн цөлийн уулсад байдаг цөөн зүйлүүдийн нэг юм.

**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын хэмжээгээр арьсыг худалдаалдаг учраас хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг. Хамгийн ихээр агнаж байсан үе болох 1958 оноос 1960 оны хооронд жилд 350 шилүүс агнаж байжээ (Stubbe, 1965). Мөн гол идэш


бологчид болох янгир ямаа (*Capra sibirica*) болон Монгол тарвага (*Marmota sibirica*) нь цөөрсөн ба гэрийн нохойн дайралтанд өртдөг. Тархац нутгийн зарим хэсэгт байгалийн баялгийн нөөцийн олборлол, ялангуяа мод бэлтгэл болон нил тайралт хийсний улмаас орчны хомсдол, доройтол явагдах боломжтой байна.

#### 94. *Otocolobus manul* (Pallas, 1776)

**Түгээмэл нэр:** Мануул мий (Монгол), Pallas's cat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *O. m. manul*

**Ижил нэр:** *O. ferrugineus*, *O. mongolicus*, *O. nigripectus*, *O. satuni* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** Монгол орны энэ зүйлийн популяцийн чиг хандлагын тухай мэдээлэл хомс байна. Энэ зүйлийн нийт тархац нутгийн хүрээнд их хэмжээгээр агнадаг байна. Цаашид популяцийн талаарх мэдээ баримт хуримтлагдан, үүний зэрэгцээ хамгааллын арга хэмжээ авахгүй байвал энэ зүйлийг А шалгуураар дахин үнэлэн ховордлын ангиллыг өөрчилж болох юм. Хил залгаа нутгаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээ хэвээр үлдэв.



**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт II-т оруулсан, 2005 онд зургаан бодгаль амьдаар нь экспортлосон (UNEP-WCMC, 2006). Засгийн газар олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 70 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Мануул мийн тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Армен, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикистан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Монгол.


**Бүс нутгийн тархац:** Монгол орны тайгын бүсээс бусад нутагт тархсан бөгөөд таг, цөлийн бүсээр ховор тохиолдоно. (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын хэмжээнд арьсыг нь худалдаалдаг тул хараа хяналтгүй агнаснаар энэ зүйлийн тоо толгой буурсан гэж үздэг. Арьс бэлтгэлийн 1958- аас 1960 оны хоорондох дүнгээс үзэхэд жилд 5,500 ширхэг гэсэн тооцоо байна (Stubbe, 1965). Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онуудад үлийн цагаан оготны (*Lasiopodomys brandti*) тоо толгойг зохицуулахад хэрэглэж буй Бромадиолоне химийн хорт бодисонд дам өртөж хорогдох нь бий. Энэ үйл ажиллагаа одоогоор зогссон ч бусад зүйлд нөлөөлсөөр байна (Н. Батсайхан, аман мэдээ). Гэрийн нохойн дайралтанд өртдөг, зарим жил өвлийн цаг агаар нэлээд хүнд нөлөө үзүүлдэг.

## 95. *Uncia uncia* (Schreber, 1775)

**Түгээмэл нэр:** Цоохор ирвэс (Монгол), snow leopard, ounce (Англи).

**Ижил нэр:** *U. irbis*, *U. schneideri*, *U. uncioides* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Устаж болзошгүй, С2а(i)

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, С1

**Үнэлгээний үндэслэл:** Монголын популяцийг 2000 онд 500-аас 1,000 бодгаль гэж тоолсон байна (McCarthy, Chapron, 2003). Nowak (1991) *Uncia uncia* зүйлийн нэг үе удмын хугацааг



долоон жил гэж тогтоожээ. Энэ зүйлийн жижиг популяци нь дараагийн хоёр үе удмын хугацаанд 20 хувь буурна гэж дүгнээд С1 шалгуураар үнэлэн устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт I-д орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн 7.1д (2000) нэн ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Ариунзул, 2005). 1972 оноос хойш агнахыг хуулиар хориглосон, 1995 оны ан агнуурын тухай хуулиар нэн ховор зүйлийн жагсаалтанд оруулсан (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Ирвэсийн тархац нутгийн 18 орчим хувь (McCarthy, Chapron, 2003) нь улсын тусгай хамгаалалтай 10 газрын дэвсгэрт ордог (McCarthy 2000).

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Монгол, Бутан.

**Бүс нутгийн тархац:** Энэ зүйл тархацынхаа бүх нутагт ховор. McCarthy (2000) Монгол дахь ирвэсний нийт тархацын талбайг 103,000км<sup>2</sup> гэж тооцоолсон. Алтайн өвөр говийн төв хэсэг, Говь Алтайн хойд хэсгээр нягтшил ихтэй байдаг. Хөвсгөл болон Хангайн нуруунд тохиолдох боловч энэхүү байршилд тогтмол тааралдах нь ховор, харин 1960-аад онд үзэгдэж байсан (McCarthy, Chapron, 2003). Монгол дахь ирвэсний тархалт нь ирвэсний гол идэш болох янгир ямаа (*Capra sibirica*), аргаль хонины (*Ovis ammon*) тархацтай нягт холбоотой (Мунхцог, 2006).

**Ховордлын гол шалтгаан:** Арьс болон ясыг Хятадын ардын эмнэлэгт барын ясны оронд ашиглах зорилгоор хууль бусаар агнадаг (Liao, Tan, 1988). Мөн махыг нь эмийн түүхий эд болгодог. Монгол, Хятадад худалдаалагддаг ирвэсний арьсны метр тутам нь 250-аас их ам.доллараар үнэлэгддэг байна (Wingard, Zahler, 2006). Идэш бологч туруутан амьтад ховордсоноос тэжээлийн хомсдол ихсэж байгаа нь ховордох гол шалтгаан болж байна. Зарим газар гэрийн мал руу дайрдаг учраас санаатай агнадаг.


## Овог Чонынхон

### 96. *Canis lupus* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Саарал чоно (Монгол), grey wolf, timber wolf (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. l. lupus*


**Ижил нэр:** *C. albus*, *C. ater*, *C. chanco* гэх мэт (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** ШУА-ийн судалгаагаар 1980 онд Монголын популяци 30,000 бодгаль гэж тооцоолсон байна. Саяхны судалгаагаар Монголд 10,000-аас бага бодгаль байж болох юм гэж үзсэн (Mech, Voitani, 2004) боловч эдгээр үнэлгээ хангалттай биш бөгөөд одоогийн тоог нарийвчлан тогтоох өргөн цар хүрээтэй судалгаа хийх шаардлагатай байна. Энэ зүйлийн популяцийн нягтшил, тархац, эзлэн амьдрах нутгийн хэмжээг тодорхойлох популяцийн судалгаа хийгдээгүй байна (Wingard, Zahler, 2006). Nowak (1991) чонын нэг үе удмын хугацааг зургаан жил гэж тогтоожээ. Популяцийн хэмжээний бууралт нь ихэнхдээ хараа хяналтгүйгээр агнах, халдварт өвчинд нэрвэгдэх шалтгаанаас үүсэлтэй юм. Энэ зүйлийн тоо толгой буурч буй нь тодорхой боловч хэдий хэмжээгээр буурч буйг тодорхойлох нь нэлээд төвөгтэй байна. Одоогоор энэ зүйл Ховордож болзошгүй гэсэн ангилалд байгаа ч нарийвчилсан судалгаа хийж дахин үнэлвэл Эмзэг гэсэн ангилалд оруулах шаардлагатай. Цаашилбал А шалгуураар Устаж болзошгүй ангилалд ч орж болзошгүй юм. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.



**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт II-т орсон. Экспортлосон хэмжээ 2005 онд 150 арьс, гавлын яс байна (UNEP-WCMC, 2006). Засгийн газраас олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 225 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Монголд саарал чоно хамгаалах хууль, эрх зүйн арга хэмжээ аваагүй ч тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан. Тусгай хамгаалалтай газрын чоныг хамгаалах нь ховор бөгөөд мал болон зэрлэг амьтдыг хамгаалах зорилгоор зориуд агнуулдаг.

**Дэлхийн тархац:** Голдуу Ази, Европ, Америкийн Нэгдсэн улсын хойд хэсэг, Канадын онгон зэрлэг зэлүүд нутгаар тархжээ (Mech, Voitani, 2004).

**Бүс нутгийн тархац:** Монголын бүх нутагт хааяагүй тархмал бөгөөд халиун буга (*Cervus elaphus*), бор гөрөөс (*Capreolus pygargus*) нутагладаг Хэнтий, Хөвсгөлийн зэлүүд ой тайга, цагаан зээр (*Procapra gutturosa*) элбэгтэй Дорнод тал хээр, аргаль хонь (*Ovis ammon*), янгир ямааны (*Capra sibirica*) бэлчээр бүхий уулархаг нутагт илүү элбэг (Шагдарсүрэн, 1966; Дуламцэрэн, 1970). Хүн ам нягтаар суурьшсан газрын орчим тохиолдохгүй.

**Ховордлын гол шалтгаан:** Арьсыг нь худалдаалах, бүх эрхтэнг (хэл, хэвлийн эрхтэн, шагай, шүд зэрэг) ардын эмнэлэгт ашигладагаас ихээхэн агнах болсон нь, мөн спорт агнуураар агнаж байгаа нь ховордуулах гол шалтгаан болж байна (Mech, Boitani, 2004; Wingard, Zahler, 2006). Энэ зүйл нь гэрийн мал руу байнга довтолж идэшээ болгодог учраас малын дайсан гэж үздэг. Монгол оронд 949 анчдаас авсан судалгаагаар 40 гаруй хувь (321) нь чоно агнадаг гэсэн байна (Wingard, Zahler, 2006). Хамгийн ихээр 1933 онд 18,000 ширхэг чоно агнасан гэж үздэг (Scharf нар, 2003) ба 1942-оос 1960 онд бэлтгэсэн чонын арьсны тоо жилд дунджаар 5,827 ширхэг болж байжээ (Stubbe, 1965). Энэ байдал харьцангуй тогтвортойгоор үргэлжилж 2003 онд Монголын зах зээлд 4,900 чонын арьс зарагдсан байна. Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэгээс 2004 онд үндэсний хэмжээнд судалгаа явуулахад 20,000-30,000 чоно агнагдсан байна, эндээс харахад хараа хяналтгүй агналтын түвшин хэтэрсэн байна (Wingard, Zahler, 2006). Хамуу, шүдний парвовирус, нүд сохрох, галзуу зэрэг өвчнүүдэд өртөмтгий (Mech, Boitani, 2004).

### 97. *Cuon alpinus* (Pallas, 1811)

**Түгээмэл нэр:** Шар цөөвөр, шарнад цөөвөр (Монгол), Asiatic wild dog (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. a. hesperius*.

**Ижил нэр:** *C. clamitans*, *C. grayiformes*, *C. rutilans* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Устаж болзошгүй, C2a(i)

**Бүс нутгийн үнэлгээ:** Бүс нутгийн хэмжээнд утсан

**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт II-т орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн 7.1-д (2000) нэн ховор зүйлд (Бадам, Ариунзул, 2005), Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор амьтны жагсаалтанд оруулсан (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор, устаж байгаа зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Урьд тархаж байсан нэлээд нутгууд нь улсын тусгай хамгаалалтай газруудад хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Турк, Оросын Холбооны Улс, Казахстан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Монгол, Бангладеш, Бутан, Мьянмар, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Тайланд, Малайз, Индонез, Лаос, Камбож, Вьетнам.

**Бүс нутгийн тархац:** 1930-аад онд уг зүйлийг утсан гэж үзсэн байна (Банников, 1954). Харин Өмнөговийн Зөөлөн ууланд 1969 онд хавханд орсон тохиолдол нь уг зүйлийн хамгийн сүүлчийн нотолгоо болно. Одоогоор зөвхөн Алтайн өвөр говь, Хөвсгөлийн уулс, Умард говь, Алашань говь, Дорнод говьд тохиолдож магадгүй юм.


**Ховордлын гол шалтгаан:** Гэрийн малын дайсан учраас санаатайгаар агнадаг.

## 98. *Nyctereutes procyonoides* (Gray, 1834)

**Түгээмэл нэр:** Загал элбэнх (Монгол), raccoon dog (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *N. p. ussuriensis*

**Ижил нэр:** *N. albus*, *N. koreensis*, *N. viverrinus* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу)



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Засгийн газрын тогтоолоор олзворын агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 270 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Элбэнхийн тархац нутгийн 10 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Франц [нутагшуулсан], Нидерланд [нутагшуулсан], Герман [нутагшуулсан], Норвеги [нутагшуулсан], Швейцарь [нутагшуулсан], Австри [нутагшуулсан], Чех [нутагшуулсан], Швед [нутагшуулсан], Польш [нутагшуулсан], Унгар [нутагшуулсан], Словак [нутагшуулсан], Финланд [нутагшуулсан], Румын [нутагшуулсан], Латви [нутагшуулсан], Литва [нутагшуулсан], Эстони [нутагшуулсан], Украин [нутагшуулсан], Оросын Холбооны Улс, Беларусь [нутагшуулсан], Молдав [нутагшуулсан], Казахстан [нутагшуулсан], Хятад, Монгол, Вьетнам, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон; Узбекистанаас олдох боломжтой.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны дорнод бүс нутгийн Их хянганы уулс, Халх, Нөмрөг голын савд тохиолдоно. Түүнчлэн Хэнтий нурууны зүүн бие, Монгол Дагуур, Төв Халхын хээрээр дайран урсдаг Улз, Онон, Хэрлэн, Дөч голын сав нутгаар тархана. Мөн Дорнод Монголын Хөх нуур, Дорнод говийн зүүн хойд нутагт тэмдэглэгджээ. Энэ зүйлийн тархац нь Монгол орны зүүн хэсгийн холимог ойн бүсийн бутархаг өндөрлөг газар дагуу тэлэн тархаж байна.


**Ховордлын гол шалтгаан:** Одоогоор мах, үслэг арьсных нь хэрэгцээ бага байгаа ч хараа хяналтгүй агнаж байна. Бага нягтшилтай популяцид агнуур нэлээд хүчтэй нөлөөлж байна. Гэрийн нохойд бариулахаас гадна саркоптик хамуунд (*Sarcoptes scabies*) өртдөг (Kauhala, Saeki, 2004).

## 99. *Vulpes corsac* (Linnaeus, 1768)

**Түгээмэл нэр:** Хярс үнэг, хярс, хярас (Монгол), corsac fox (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *V. c. scorodumovi*

**Ижил нэр:** *V. kalmkorum*, *V. nigra*, *V. scorodumovi*, *V. turkmenica* (Wilson, Reeder, 1993)



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** Монгол орноор нэлээд өргөн тархсан зүйл бөгөөд тархац нутгийн хэмжээнд хараа хяналтгүй агналт их байгаа (Wingard, Zahler, 2006)

ба одоогийн популяцийн талаарх мэдээ алга байна.

Хэрэв популяцийн талаарх мэдээлэл хуримтлагдвал

ойрын ирээдүйд А шалгуурыг ашиглан дахин үнэлэн

ховордлын ангилалд оруулж магадгүй юм. Nowak (1991) энэ зүйлийн нэг үе удмын

үргэлжлэх хугацааг дөрвөн жил гэж тодорхойлсон. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц

нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр

үлдээв.

**Хамгаалсан байдал:** Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх


хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрсөн (БОЯ, 2005). Засгийн газрын тогтоолоор олзвор

агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 55 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол

улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг

байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Хярсны тархац

нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны улс, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Тажикстан, Хятад, Киргизстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны ихэнх нутгаар өргөн тархсан бөгөөд хээр, цөлөрхөг хээрийн нутгуудад ихээр тохиолддог. Хэнтий, Хөвсгөлийн тайгаас бусад ойт хээрийн

бүс ба задгай хээрт өргөн тархсан (Дуламцэрэн нар, 1989).

**Ховордлын гол шалтгаан:** Үслэг арьс, мах зэрэг бүтээгдэхүүн нь бага үнэтэй ч хараа

хяналтгүй агнуур газар авсаар байна. Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт

2001, 2002, 2003 онуудад үлийн цагаан оготны (*Lasiopodomys brandti*) тоо толгойг

зохицуулахад хэрэглэж буй Бромациолоне химийн хорт бодисонд дам өртөж хорогдох нь

бий. Гэсэн хэдий ч энэ үйл ажиллагаа одоогоор зогссон ч бусад зүйлд нөлөөлсөөр байна

(Н. Батсайхан, аман мэдээ). Байгалийн нөөцийн олборлолтын (уул уурхай) идэвхтэй

үйл ажиллагаа өссөнөөс амьдрах орчны хомсдол бий болж байна. Гэрийн нохойнд

дайруулахаас гадна галзуу өвчинд нэлээд өртөмтгий (Гептнер нар, 1967).


## 100. *Vulpes vulpes* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Шар үнэг (Монгол), red fox (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *V. v. daurica*

**Ижил нэр:** *V. alba*, *V. barbarus*, *V. fulvus*

(Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** Монгол орноор нэлээд өргөн тархсан зүйл бөгөөд тархац нутгийн хэмжээнд хараа хяналтгүй агналт их байгаа (Wingard, Zahler, 2006) ба одоогийн популяцийн талаарх мэдээ алга байна. Хэрэв популяцийн талаарх мэдээлэл хуримтлагдвал ойрын ирээдүйд А шалгуурыг ашиглан дахин үнэлэн ховордлын ангилалд оруулж магадгүй юм. Nowak (1991) энэ зүйлийн нэг үе удмын хугацаа дөрвөн жил гэж бичсэн байна. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.



**Хамгаалсан байдал:** Аравдугаар сарын 21-ээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Засгийн газрын тогтоолоор олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 70 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Шар үнэгний тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Зүүн өмнөд тропикын бүсээс бусад Евроази, Африкийн хойд хэсэг, Канад, Америкийн Нэгдсэн улсын ихэнх хэсэг (Nowak, 1991).

**Бүс нутгийн тархац:** Монгол оронд хааяагүй өргөн тархсан боловч сийрэг нягтшилтай. Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутгаар, Хангай нурууны баруун өмнөд болон зүүн хойд хэсэг, Орхон, Сэлэнгэ голын сав, Дорнод Монголын хээрээр, Монгол Алтай, Говийн Алтай нуруугаар их элбэг тохиолдоно (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980; Dawaа нар, 1982).


**Ховордлын гол шалтгаан:** Арьсыг нь олон улсын зах зээлд худалдаалдаг учраас хараа хяналтгүй агнуур нь ховордуулах гол шалтгаан болж байна. Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онуудад үлийн цагаан оготны (*Lasiopodomys brandti*) тоо толгойг зохицуулахад хэрэглэж буй Бромадиолоне химийн хорт бодисонд дам өртөж хорогдох нь бий. Энэ үйл ажиллагаа одоогоор зогссон хэдий ч бусад зүйлд нөлөөлсөөр байна (Н. Батсайхан, аман мэдээ). Мөн галзуу өвчинд (Macdonald, Reynolds, 2004) болон саркопстик хамуунд өртөмтгий (Newman нар, 2002).

## Овог Суусрынхан

### 101. *Arctonyx collaris* Cuvier, 1825

**Түгээмэл нэр:** Мангис дорго, хумс зорх (Монгол), hog badger (Англи).

**Ижил нэр:** *A. consul*, *A. obscurus*, *A. taxoides* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** Энэ зүйлийн тархац нутгийн нэг орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт орсон.



**Дэлхийн тархац:** Хятад, Энэтхэг, Монгол, Бутан, Мьянмар, Тайланд, Малайз, Индонез, Лаос, Камбож, Вьетнам.


**Бүс нутгийн тархац:** Уг зүйлийн арьсыг Монгол орны зүүн хэсгээс 1980-иад онд олсон (Stubbe нар, 1998).

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 102. *Gulo gulo* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Нохой зээх (Монгол), wolverine (Англи).

**Ижил нэр:** *G. arctos*, *G. borealis*, *G. luteus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Эмзэг, А2с

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн. Популяцийн чиг хандлага болон ховордлын шалтгааны талаарх илүү нарийн мэдээлэл хуримтлагдвал дахин ангилан Ховордож болзошгүй гэсэн ангилалд оруулах магадлал бий.



**Хамгаалсан байдал:** Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Нохой зээхийн тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн Улс, Норвеги, Швед, Финланд, Эстони, Оросын Холбооны Улс, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Хэнтий, Хөвсгөлийн ойт хээр, тайгын бүсэд тохиолдоно (Банников, 1954; Дуламцэрэн 1970). Хангай нурууны хойд хэсэг, Монгол Дагуурын хээр, Монгол Алтайн уулсад хааяа үзэгддэг (Дуламцэрэн нар, 1989).

**Ховордлын гол шалтгаан:** Монгол орны нөхцөлд нохой зээхийн ховордлын шалтгаан тодорхойгүй байна. Гэрийн мал руу довтлох болон хавх занганд орсон амьтдыг иддэг, агнуурын холбогдолтой шувуу хөхтөн амьтдыг хороодог тул хортой гэж үздэг.

### 103. *Lutra lutra* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Голын халиу (Монгол), Eurasian otter (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** Монгол дахь салбар зүйлийн судалгааг хараахан хийгээгүй байна.

**Ижил нэр:** *L. indica*, *L. kutab*, *L. splendida* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт I-д орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн 7.1-д (2000) нэн ховор зэрэглэлд оруулж хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Халиуг агнахыг 1930 оноос хойш хуулиар хориглосон. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар нэн ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор, нэн ховор зэрэглэлд тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Халиуны тархац нутгийн 12 орчим хувь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Энэ зүйлийн түүхэн тархац нь Евразийн ихэнх газар нутагт хамрагдана (Nowak, 1991).

**Бүс нутгийн тархац:** Монголын умард хэсгийн Хөвсгөл, Хангай, Хэнтий нуруу (Mallon, 1985), Монгол Алтайн баруун хойд хэсгийн ой тайгат уулсын голууд, зүүн хязгаарын Их хянганы уулс, Халх голын савд (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Tsagaan, 1975; 1977; Соколов, Орлов, 1980; Stubbe нар, 1989) өмнө нь тархаж байжээ. XIX, XX зууны турш эрчимтэй агнаснаас популяцийн тоо толгой буурсан, 1995 онд зөвхөн цөөн зүйл Хөвсгөлийн хойд хэсэг, Шишгэдэд Тэнгис голын бэлчирээс улсын хил хүртэлх зэлүүд зах хязгаар нутаг (Samjaa нар, 1998), Баруун Хэнтийн Ерөө голын савд (Цэнджав, 2005)

олджээ. Хангайн нурууны хойд хэсгийн Тэс, Хөвсгөлийн уулсын Эг, Хуримт голуудын савд хааяа үзэгддэг (Stubbe нар, 1998).


**Ховордлын гол шалтгаан:** Арьсыг нь дотооддоо хэрэглэхээс гадна олон улсын хэмжээнд худалддаг учраас хууль бусаар агнадаг. Одоогоор нөөцийн олборлолт (уул уурхай) ихэссэнээс энэ зүйлийн амьдардаг усны системийг бохирдуулж байна гэж үзсэн.

#### 104. *Martes foina* (Erxleben, 1777)

**Түгээмэл нэр:** Суусар булга (Монгол), beech marten (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. f. intermedia*

**Ижил нэр:** *M. domestica*, *M. intermedia*, *M. rosanowi* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай (2000) хуулийн дагуу 2001 онд (Засгийн газрын тогтоол № 264) ховор зэрэглэлд багтаасан (Бадам, Ариунзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулинд ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Суусрын тархац нутгийн 21 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Португал, Испани, Франц, Нидерланд, Герман, Лихтенштейн, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Хорват, Польш, Босни Герцеговин, Унгар, Серб, Монтенегро, Словак, Албан, Грек, Румын, Македон, Украин, Болгар, Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Молдав, Гүрж, Армэн, Иран, Азербайжан, Казахстан, Туркменистан, Афганистан, Пакистан, Хятад, Киргизстан, Балба, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Монгол Алтай, Говийн Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Хангайн өвөр хэсэг, Нууруудын хөндий, Умард говь, Дорнод говийн умард хэсгийн уул толгодоор өргөн тархмал (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Chotolchu нар, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Арьсыг нь дотоодод хэрэглэхээс гадна олон улсын хэмжээнд худалдаалдагаас хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг. Өвөлжөөнд нөөцөлсөн идэшний махийг идэх тул хавх, занганд орж эндэх нь элбэг.

## 105. *Martes zibellina* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Ойн булга (Монгол), sable (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. z. sajanensis*, *M. z. princeps*, *M. z. averini*. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *M. brachyura* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Эмзэг, АЗсд

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн арьс өндөр үнэтэй бөгөөд монголын популяци агналтаас үүдэн буурсан билээ. Энэ зүйлийн популяцийн талаарх мэдээлэл маш бага байгаа ч 1966 оноос 1968 оны хооронд Төв Хэнтийд 1,000 га-д 11.7 бодгалийн нягтшилтай байсан (Stubbe, Chotolchu 1968) ба

1970-аад онд энэ бүс нутагт 10,000 бодгаль байна гэж үнэлсэн (Хотолхүү, 1976). Nowak (1991) энэ зүйлийн нэг үе удмын хугацааг долоон жил гэж бичжээ. Популяцийн бууралт нь дараагийн гурван үе удамд 30 хувь буурна гэж үзсэн. Иймээс АЗсд шалгуураар үнэлэн Эмзэг гэсэн ангилалд оруулсан. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** 1953 оноос 2000 оны хооронд агнахыг хориглосон байв. Одоо аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Ойн булгын тархац нутгийн 20 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Финланд, Оросын Холбооны Улс, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөл, Хэнтий, Монгол алтайн баруун умард тайга, ойт уулсаар (Банников, 1954; Хотолхүү, 1976; Хотолхүү, 1980) тархмал. *M. z. sajanensis* Хөвсгөлийн уулсын зүүн хэсгээр, *M. z. princeps* Хэнтий нуруу, Монгол Дагуурын хээр, *M. z. averini* Монгол Алтайн нуруугаар тархсан.

**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын хэмжээнд арьсыг худалдаалдагаас хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг. Хэнтий, Хөвсгөл, Саяаны уулсаас 1910-аас 1920 оны хооронд 4,000-5,000 ширхэг булганы арьс бэлтгэсэн байна (Намнандорж, 1976). 1920-иод оны сүүлчээс агналт нь буурч 1927-оос 1929 оны хооронд жилд 300-500 ширхэг булга агнасан байна (Банников, 1954). Нөөцийн олборлолоос (мод бэлтгэл) үүдэлтэй амьдрах орчны хомсдол нэлээд ноцтой ховордуулах шалтгаан болж байна. Байгалийн болон хүний тавьсан түймэр орчны доройтолд оруулж байгаа нь энэ зүйлийг ховордуулах бас нэг аюул бөгөөд ялангуяа хаврын цагт төрөх үеэр үүр нь түймэрт өртдөг (M. Stubbe, аман мэдээ).

**106. *Meles meles*** (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Халзгай дорго (Монгол), Eurasian badger (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. m. leptorhynchus*.  
Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай.

**Ижил нэр:** *M. alba*, *M. heptneri*, *M. vulgaris* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Есдүгээр сарын 1-нээс арваннэгдүгээр сарын 1 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Засгийн газраас олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 70 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Доргоны тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт орсон.



**Дэлхийн тархац:** Европ, Ази, зүүн тийш Япон хүртэл, өмнө тийш Палестин, Иран, Төвд, Хятадын өмнөд нутаг (Corbet, 1978).

**Бүс нутгийн тархац:** Монгол орны төв болон умард нутаг Монгол Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий нуруудын ой тайга, ойт хээр, хээрийн бүсэд (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980; Stubbe нар, 1998) ихэд тархсан. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Дорнод говь, Дорнод Монголд алаг цоог тохиолддог ч тархалтын өмнөд хил нь тодорхойгүй байна.


**Ховордлын гол шалтгаан:** Ардын эмнэлэгт бүх эрхтэн, арьсыг нь ашигладагаас хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг. Агнуурын бэлтгэлээр 1958-аас 1960 оны хооронд жилд 1,500-аас 1,800 бодгаль агнагдаж байжээ (Stubbe, 1965). Бүс нутгийн хэмжээнд агнадаг бөгөөд олон улсын хэмжээнд бага хэмжээгээр худалдаалдаг (Wingard, Zahler, 2006). Гэрийн нохойн дайралтанд хаяа өртөнө.

### 107. *Mustela altaica* Pallas, 1811

**Түгээмэл нэр:** Солонго үен (Монгол), mountain weasel, alpine weasel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. a. raddei*

**Ижил нэр:** *M. alpina*, *M. birulai*, *M. raddei* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Аравдугаар сарын 21-нээс

дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Солонгоны тархац нутгийн 9 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт орсон.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Пакистан, Хятад, Энэтхэг, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны төв болон зүүн хэсгийн ой, тал хээрийн бүсэд элбэг тохиолддог (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980). Монгол Алтай, Хангай, Хөвсгөлийн тайга, ой хээрийн бүсийн хэсэгт тааралдах боловч ховор үзэгддэг.


**Ховордлын гол шалтгаан:** Гэнэтийн эндэл ховордох гол шалтгаан болдог бөгөөд ондоотор (*Ondatra zibethicus*) гэх мэт зүйлүүдэд тавьсан хавх занганд ордог. Агналт нь мөн ховордуулах шалтгааны нэг бөгөөд 1959, 1960 онд жилд 1000 бодгаль агнасан байна (Stubbe, 1965). Одоогоор агналт нь буурч байгаа бөгөөд олон улсын хэмжээнд бага хэмжээгээр худалдаалагдсаар байна (Wingard, Zahler, 2006).

### 108. *Mustela erminea* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Цагаан үен (Монгол), stoat, ermine (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. e. lymani*, *M. e. mongolica*

**Ижил нэр:** *M. alascensis*, *M. herminea*, *M. vulgaris* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.



**Хамгаалсан байдал:** Цагаан үений тархац нутгийн 10 орчим хувь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн Улс, Ирланд, Португал, Испани, Франц, Их Британи, Белги, Нидерланд, Герман, Норвеги, Лихтенштейн, Швейцарь, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Босни Герцеговин, Унгар, Серб Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Литва, Эстони, Украин, Болгар, Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Молдав, Гүрж, Азербайжан, Казахстан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Монгол, Япон, Шинэ Зеланд [нутагшуулсан].

**Бүс нутгийн тархац:** Монгол орны төв болон баруун хойд нутгаар элбэг, зүүн хэсгийн тал нутгаар ховор тархсан (Банников 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980).

**Ховордлын гол шалтгаан:** Орон нутаг болон олон улсын хэмжээнд арьсыг худалдаалдагаас агнадаг. Энэ зүйлийг 1958 оноос 1960 оны хооронд жилд 860-1,750 бодгалийг агнасан байна (Stubbe, 1965). Олон улсын хэмжээнд арьсыг нь худалдаалах явдал тохиолдсоор байгаа тул үлэмж бага хэмжээтэй байна (Wingard, Zahler, 2006).

### 109. *Mustela eversmannii* Lesson, 1827

**Түгээмэл нэр:** Өмхий хүрэн, өмхий үен (Монгол),  
steppe polecat (Англи).


**Ижил нэр:** *M. larvatus*, *M. lineiventer*, *M. tiarata*  
(Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам,  
тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ  
буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Өмхий хүрний тархац нутгийн  
12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт  
хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Чех, Польш, Серб Монтенегро, Словен, Румын, Украин, Болгар, Беларусь, Оросын Холбооны Улс, Молдав, Казахстан, Хятад, Монгол; Гүрж, Армени, Азербайжан, Туркменистан, Узбекистан, Тажикстан, Киргизстан зэрэг улсуудад байх боломжтой.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун өмнөд хэсгээс бусад бүх нутагт тархана. Хэнтий, Хөвсгөл, Хангай нурууны зарим хэсгийн тагийн болон ой, Монгол Дагуурын ойт хээрт тохиолдоно. (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980). Хээрийн бүсэд элбэг, цөлөрхөг хээрийн задгай нутгуудад бага тохиолдоно.

**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын болон орон нутгийн хэмжээнд арьсыг худалдаалах зорилгоор бага хэмжээгээр агнадаг. Агнуурын бэлтгэлээр 1958 оноос 1960 оны хооронд 6,000 гаруй бодгалийг агнасан байна (Stubbe, 1965). Бусад зүйлд тавьсан хавх занганд хаяа өртдөг.

### 110. *Mustela nivalis* Linnaeus, 1766

**Түгээмэл нэр:** Хотны үен (Монгол), least weasel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. n. kerulenica*,


**Ижил нэр:** *M. alpinus*, *M. mictrous*, *M. typicus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Хотны үенгийн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Палеарктик (Ирланд, Арабын хойг, Арктикийн арлуудаас бусад), Япон; Неарктикт Аляск (АНУ), Канад, Америкийн Нэгдсэн Улс, Шинэ Зеланд [нутагшуулсан] (Wilson, Reeder, 1993).

**Бүс нутгийн тархац:** Монгол орны төв болон умард нутгаар нэлээд өргөн тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970), Дорнод Монголын тал хээр нутагт элбэг бөгөөд Хангайн нурууны баруун өмнөд хэсэг, Улаанбаатар хотын ойр орчимд тохиолддог.

**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

### 111. *Mustela sibirica* Pallas, 1773

**Түгээмэл нэр:** Ойн солонго, модны үен (Монгол), Siberian weasel (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. s. sibirica*


**Ижил нэр:** *M. horsfieldii*, *M. manchurica*, *M. peninsulae* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Ойн солонгоны тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Пакистан, Хятад, Энэтхэг, Балба, Монгол, Бутан, Мьянмар, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Тайланд, Лаос, Вьетнам, Тайван.

**Бүс нутгийн тархац:** Хэнтий, Хангай, Хөвсгөл орчим, Алтайн нурууны баруун хойд хэсгийн ойт нутгуудаар тархсан. Мөн Монгол Дагуурын хээрээр тархсан (Сүхбат, Шагдаржав, 1990).


**Ховордлын гол шалтгаан:** Олон улсын хэмжээнд арьсыг худалдаалдагаас бага хэмжээгээр хараа хяналтгүй агнадаг. Ойн булгатай (*Martes zibellina*) идэш тэжээл, байршил нутгийн төлөө өрсөлддөг. Байгалийн болон хүний тавьсан түймрээс үүдэлтэй орчны доройтол ховордох шалтгааны нэг болно.

## 112. *Vormela peregusna* (Güldenstädt, 1770)

**Түгээмэл нэр:** Эрээн хүрнэ (Монгол), marbled polecat (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *V. p. pallidior*

**Ижил нэр:** *V. euxina*, *V. negans*, *V. ornata* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.



**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай (2000) хуулийн хэрэгжилттэй

уялдан 2001 онд гарсан Засгийн газрын тогтоолоор (№ 264) ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Ариунзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зүйл зэрэглэлээр тус тус бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Эрээн хүрний тархац нутгийн 19 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Серб Монтенегро, Грек, Румын, Македони, Украин, Болгар, Турк, Оросын Холбооны Улс, Ливан, Израйль, Сири, Гүрж, Ирак, Армени, Иран, Азербайжан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Умард говь, Алашань говь, Дорнод говийн хээр, хуурай хээрээр элбэг, цөл, цөлөрхөг хээрээр цөөн тохиолдоно (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980; Chotolchu нар, 1989; Дуламцэрэн нар, 1999).

**Ховордлын гол шалтгаан:** Бусад зүйлд тавьсан хавх занганд хааяа өртөнө.


## Овог Баавгайнхан

### 113. *Ursus arctos* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Хүрэн баавгай (Монгол), brown bear (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *U. a. baikalensis*, *U. a. gobiensis* (доор тодорхой үнэлэгдсэн).

**Ижил нэр:** *U. baikalensis*, *U. collaris*, *U. dalli* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Мэдээлэл дутмаг

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байна.

**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт II-т орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн



тухай (2000) хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 2005 онд гарсан Засгийн газрын тогтоолоор (№ 248) ховор зүйлийн жагсаалтад оруулсан байна. Наймдугаар сарын 1-нээс арваннэгдүгээр сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Засгийн газар олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 2,250 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Хүрэн баавгайн тархац нутгийн 21 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт орсон.

**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн Улс, Испани, Франц, Норвеги, Итали, Австри, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Босни Герцеговин, Серб Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Эстони, Украйн, Болгар, Беларусь, Турк, Оросын Холбооны Улс, Сири, Ирак, Гүрж, Иран, Азербайжан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Монгол, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Япон.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөл орчим, Хэнтий нурууны зүүн бие, Монгол Дагуурын хээрийн Улз, Онон гол, Монгол алгайн баруун хойд хэсэг, Их хянганы салбар уулс зэрэг тайга, ойт уулсаар тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980).


**Ховордлын гол шалтгаан:** Хүний нөлөөнөөс улбаалан амьдрах орчин өөрчлөгдөж байгаа нь ховордуулах гол шалтгаан болж байна. Олон улсын хэмжээнд ардын эмнэлэгт бүх эрхтнийг нь хэрэглэдэг учраас хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг. Монголд баавгайн доньдыг худалдаалдгаас хараа хяналтгүй болон хууль бусаар голдуу агнаж байна (Wingard, Zahler, 2006).

#### 114. *Ursus arctos gobiensis* Sokolov and Orlov, 1992

**Түгээмэл нэр:** Мазаалай, мазаалай баавгай (Монгол), Gobi bear (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** Монгол улсын шинжлэх ухааны хүрээлэнгийн 1943 оны судалгаагаар албан ёсоор тусгай хэлбэр гэж үзсэн (Банников, 1954), мөн Соколов, Орлов нар (1992) *Ursus gobiensis* гэсэн бие даасан зүйл гэж тодорхойлсон боловч энэ тодорхойлолт нь судалгааны цөөн объект дээр морфологийн шалгуураар гаргасан дүгнэлт тул асуудалтай хэвээр байна (Schaller нар, 1993; McCarthy, 1999). Энэ салбар зүйлийг *U. a. pruinosus* Blyth, 1854 гэж дахин тодорхойлсон ч хожим нь энэ салбар зүйлийн газарзүйн тархацанд Монгол орон багтаагүй ба цөөн тоотой толгойн ясанд хийсэн хронологийн судалгааны үр дүн ялгаатай гарсан зэргээс буруу тодорхойлогдсон нь тогтоогдсон. Соколов, Орлов нар 1980 онд энэ салбар зүйлийг *U. a. isabellinus* гэж үзсэн байв. *U. a. isabellinus*

(Horsfield, 1826) салбар зүйлийн тархац нутгаас саяхан хийсэн генетик судалгаагаар Монголын мазаалайг энэ салбар зүйлийн хэлбэр гэж үзсэн бөгөөд *U. a. gobiensis* салбар зүйл нь уг салбар зүйлийг дагалдах синоним байх боломжтой (Galbraith нар, санал). Энэ зүйлийн ангилал зүйн статусыг цаашид ДНХ-ийн нарийвчилсан судалгаагаар тогтоох болно. Гэвч *U. a. isabellinus* болон *U. a. gobiensis* популяцийн симпатрик буюу парпатрик байдал байхгүйгээс Мазаалай баавгайг одоогоор морфологийн шалгуураар үндэслэн салбар зүйл гэж тогтсон (H. Reynolds, аман мэдээ).



**Олон улсын үнэлгээ:** Устаж байгаа, D•• ДБХХ-ны шийдвэр болон ангилал зүйн статусыг хүлээж байна

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж байгаа, D

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн популяци нь маш бага бөгөөд 25-аас 40 бодгалийн хооронд байна (Batsaikhan нар, 2004). Энэ зүйлийн популяцийн хэмжээ 1970 оноос хойш тогтвортой үлдсэн хэдий ч жижиг популяцид тохиолддог инбрийдинг болон үржлийн хэмжээ бага байдаг зэрэг ховордлын хэд хэдэн шалтгаан байна. 50-иас бага үржлийн бодгалиас бүрдсэн популяци учраас D шалгуураар үнэлэн Устаж байгаа гэсэн зэрэглэлд оруулсан. Энэ салбар зүйлийн бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээсэн бөгөөд Монголын эндемик зүйл гэж үздэг.

**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт I-д орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуульд (2000) 7.1-д нэн ховор зүйл гэж хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай хуулиар 1953 оноос хойш агнахыг хориглосон бөгөөд 1995 оны хуулиар нэн ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987, Шийрэвдамба нар, 1997). Энэ зүйлийн тархац нутгийн 82 орчим хувь нь Говийн их дархан газрын А хэсэгт орсон.

**Дэлхийн тархац:** Бие даасан салбар зүйл мөн гэдэг нь тодорхойлогдвол Монголын эндемик зүйл болно.

**Бүс нутгийн тархац:** Мазаалай баавгайн тархац нутаг нь Алтайн өвөр говиос зүүн тийш Тост уул (Банников, 1954) хүрч байсан хэдий ч одоо Алтайн өвөр говийн өмнөд хэсгээр Атас богд, Шар хулс, Цагаан богд уулсын баянбүрдээр хязгаарлагдмал тархсан (McCarthy, 1999). Хааяа (тархацын зурагт тусгагдаагүй) Говь гурван сайхан байгалийн цогцолборт газарт орж ирэн (Нэмэгт болон орчмын нутаг) мал руу дайрсан тохиолдол гарсан (R. Reading, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Орчны өөрчлөлт, халдварт өвчин мэтийн биотик хүчин зүйлүүдэд эмзэг мазаалай баавгайд жижиг популяцид байдаг олон сөрөг нөлөө (инбридинг, үржлийн эрчим бага гэх мэт) тохиолддог. Тархац нутгийн хэмжээнд популяци хоорондын тусгаарлалтын түвшин болон генетик солилцооны талаар бага судлагдсан популяци улам багасах төлөвтэй байна (McCarthy, 1999). Хүний идэвхитэй үйл ажиллагаа нь Говийн их дархан газар А хэсгийн баянбүрдүүд орчмын замыг хаасан ч, тэр шийдвэрийг хэрэгжүүлэх нь төвөгтэй байгаа, хүний үйл ажиллагаа мазаалай баавгайн ховордох шалтгааны нэг болж байна (McCarthy, 1999). Жил дараалсан ган, хуурайшилт, баянбүрдийн ус ширгэж байгаа зэрэг нь энэ зүйлийг ховордуулах шалтгаан хэдий ч байгаль орчны өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна. Говийн их дархан газар хийгдсэн мониторингийн судалгаагаар 1992 оноос хойш энд ган гачиг болж, жилийн хур тунадас нь 100 мм-ээс 50 мм хүртэл буурсан байна (Мижиддорж, 2006; Н. Reynolds, аман мэдээ, Говийн их дархан газрын дарга Б. Мижиддорж, ШУА-н Л. Амгалан нарын гаргасан мэдээг ашиглав).



## Баг Туурайтан

### Овог Адууныхан

#### 115. *Equus ferus przewalskii* (Groves, 1886)

**Түгээмэл нэр:** Тахь, тахь адуу (Монгол), Przewalski's horse, Asiatic wild horse, Mongolian wild horse (Англи).

**Ижил нэр:** *Equus caballus przewalskii*, *Equus przewalskii*. Тахь адуу бол гэрийн адуутай (*Equus caballus* Boddaert, 1785) өвөг нэг бөгөөд тахь адуу нь гэрийн адуутай үржилд орж төл гаргах чадвартай (Ryder нар, 1978; Trommerhausen-Smith нар, 1979). Гэвч генетик судалгаагаар тахь адуу нь гэрийн адуунаас нэлээд ялгаатай байв (Ryder, 1994). Oakenfull нарын (2000) генетик судалгаагаар тахь адуу нь адуутай үржилд орж байсан ба адуутай удам төрлөөр ойр холбоотой боловч тэдгээрийн хооронд хромсомын тоо нь өөр байсан учраас тахийг бие даасан зүйл гэж үзэх ёстой гэжээ.



**Олон улсын үнэлгээ:** Устаж байгаа D<sup>•</sup>, одоо ДБХХ-ны Адуу судлаачдын бүлгийн үнэлгээг хүлээж байна.

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж байгаа, D

**Үнэлгээний үндэслэл:** 1960 оноос хойш Байгальд утсан гэсэн ангилалд байсныг 1996 онд сүүлийн үнэлгээг хийсэн бөгөөд Хустай БЦГ, Тахийн тал, Хомын талд сэргээн нутагшуулалт амжилттай явагдаж тоо толгой өссөнөөр энэ зүйлийг дахин үнэлэхэд хүргэсэн. Одоогоор популяци дахь үржлийн бодгаль 250-иас их, байгальд чөлөөтэй амьдарч байгаа гэж үнэлсэн. Энэ зүйлийг устаж болзошгүй ангилалд оруулж болох хэдий боловч ховордлын доод ангиллаар ангилахын өмнө таван жилийн дээд ангилаар орсон байхыг шаарддаг. Иймээс тахийг одоо Устаж байгаа гэсэн ангилалд оруулсан бөгөөд хэрэв тоо толгойн чиг хандлага тогтвортой байвал Устаж болзошгүй ангилалд орох боломжтой. Энэ зүйл нь гэрийн адуутай эрлийзжиж генийн олон янз байдал нь хомсдож, халдварт өвчний уршгаар хорогдож байна. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт I-д орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн 7.1-д (2000) нэн ховор зэрэглэлээр орсон (Бадам, Ариунзул, 2005). Монгол оронд 1930 оноос хойш агнахыг хуулиар хориглосон. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор гэсэн зэрэглэлээр тус тус орсон (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Тархацын бүх нутаг нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Энэ зүйлийн тархалт урьд цагт Евразийн ихэнх нутгийг хамарч байсныг Франц, Испанийн хадны сүг зургууд гэрчилдэг. Дэлхийн хэмжээнд хуучин тархац нутгийн хэд хэдэн газарт одоогоор тахийг сэргээн нутагшуулах хөтөлбөр явагдаж байна. Одоогоор Украин [сэргээн нутагшуулсан], Казахстан [сэргээн нутагшуулсан], Хятад [сэргээн нутагшуулсан], Монголд [сэргээн нутагшуулсан] популяциуд бий. Энэ зүйл түүхэн тархац нутагтаа зэрлэгээр амьдарч байгаа цорын ганц нутаг бол Монгол орон юм. Иймээс Монголын эндемик зүйл гэж үздэг. Учир нь тодорхой үед өнгөрсөн зууны эхний хагас хүртэл зэрлэгээр энэ газар нутагт оршин амьдарч байсан нь баталгаатай.

**Бүс нутгийн тархац:** Байгальд устахын өмнөх хамгийн сүүлчийн тохиолдол нь 1969 онд Зүүнгарын говийн Тахийн шар нуруу орчим харагджээ (Paklina, Pozdnyakova, 1989). Уугуул нутагт нь сэргээн нутагшуулах ажлыг Монголд 1994 онд Зүүнгарын говийн Тахийн Тал байгалийн нөөц газарт, Хустай байгалийн цогцолбор газарт тус тус эхлүүлсэн (King, Gurnell, 2005). Их нууруудын хотгорын Хар ус нуурын байгалийн цогцолбор газрын орчмын бүс болох Хомын талд 2004 онд гурав дахь нутагт сэргээн нутагшуулах үйл ажиллагааг хийж байна (С. Feh, аман мэдээ).

**Ховордлын гол шалтгаан:** Гэрийн адуутай эрлийзжих нь ховордох гол шалтгаан бөгөөд гэрийн адуутай голлон бэлчээрээр өрсөлдөж, бусад малтай өрсөлдөх боломжтой. Маш жижиг популяцийг хэд хэдэн үе удмаар үржүүлж байгаа тохиолдолд генийн олон янз байдлын хомсдолд орох аюул бий. Сэргээн нутагшуулахад амьтны хүрээлэнгээс тахь тээж ирсэн *Babesia equi*, *B.caballi* болон боом (*Streptococcus equi*-аар халдварлах) зэрэг халдварт өвчнөөр өвчлөх нь мөн ховордлын гол шалтгаан болж байна (Roberts нар, 2005). Энэ зүйлийн популяцийн өсөж олшрох үндэс болсон унагыг саарал чоно иддэгээс тоо толгой нь хорогддог (Шийрэвдамба нар, 1997; М. Stubbe, аман мэдээ).

## 116. *Equus hemionus* Pallas, 1775

**Түгээмэл нэр:** Хулан, хулан адуу (Монгол), Asiatic wild ass (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *E. h. hemionus*, *E. h. luteus* гэдэг ч одоогоор эдгээр салбар зүйлийг синоним гэж үздэг (Oakenfull нар, 2000). Монголын ШУА болон ДБХХ-ны Адуу судлалын хэсгийн хамтарсан салбар зүйлийг тодорхойлох молекуль генетикийн судалгаа хийгдэж байна (Feh нар, 2002).



**Ижил нэр:** *E. bedfordi*, *E. castaneus*, *E. finschi*, *E. luteus* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).

**Олон улсын үнэлгээ:** *E. hemionus* Эмзэг, А3bcd ба С1 үнэлэгдсэн. *E. h. hemionus*, *E. h. luteus* Эмзэг, С1 нарийвчлагдан үнэлэгдсэн.

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, А4abd

**Үнэлгээний үндэслэл:** Популяци 2003 онд 19,000-20,000 бодгалиас бүрдэж байна гэж үнэлсэн (Б.

Лхагвасүрэн, аман мэдээ) бөгөөд хараа хяналтгүй агнаснаас орчны хомсдол, доройтол,



үржлийн идэвх муудах зэргээс тоо толгой нь буурч байна. Nowak (1991) нэг үе удмын хугацаа нь 10 жил гэж тогтоосон. Хууль бусаар жилд 3,000 гаруй хулан агнадаг (Wingard, Zahler, 2006). Үүнээс үзэхэд жилд 5 хувь буурч, өнгөрсөн 20 жилийн хугацаанд жилд 60 гаруй хувь буурсан байна. Популяцийн бууралт нь мэдэгдэж байгаа бөгөөд дараагийн гурван үе удмын хугацаанд 50 хувь буурна гэж үзэж энэ зүйлийг А4abd шалгуураар үнэлэн устаж болзошгүй ангилалд оруулсан. Хятадтай хил залгаа популяци өргөжих боломж бага гэж үзсэн ба бүс нутгийн шалгуурын үнэлгээг өөрчлөлгүй хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** *E. hemionus* зүйл ХЗОХК-ын Хавсралт II-т, *E. h. hemionus*, *E. h. luteus* ХЗОХК-ын Хавсралт I-д тус тус орсон байна (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуульд (2000) өөрчлөлт оруулан (2001, засгийн газрын тогтоол № 264) ховор зэрэглэлээр (Бадам, Ариунзул, 2005), Монгол улсын ан агнуурын 1995 оны хуулиар ховор зэрэглэлд тус тус оруулсан (БОЯ, 1996). Монголд 1953 оноос хойш агнахыг хориглосон (Шийрэвдамба нар, 1997). 2002 онд Нүүдэллэдэг зүйлийн конвенцын (НЗК) Хавсралт II-т орсон. Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Хулангийн тархац нутгийн 29 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутагт орсон. Засгийн газраас 1999 онд энэ зүйлийг хамгаалах зорилгоор Говийн бага дархан газрын Б хэсэг (Зүүнгарын говь), Загийн ус байгалийн нөөц газар (Умард говь) зэрэг хоёр тусгай хамгаалалтай газрыг байгуулсан (Feh нар, 2002).

**Дэлхийн тархац:** Урьд нь Ойрх Дорнодод Арабын хойг, Бага Ази болон Баруун хойд Энэтхэгт байсан бол одоо эдгээр нутгуудад утсан. Одоо Израиль [сэргээн нутагшуулсан], Саудын Араб [сэргээн нутагшуулсан], Иран, Казахстан [сэргээн нутагшуулсан], Туркменистан [сэргээн нутагшуулж буй популяци багтсан], Узбекистан [сэргээн нутагшуулсан], Хятад (Шинжиан мужийн хойд хэсэг; R. Reading, аман мэдээ), Энэтхэг, Монгол (Feh нар, 2002).

**Бүс нутгийн тархац:** Монгол орны хамгийн баруун хэсгээс хамгийн зүүн хойд хэсэг болох Монгол-Орос-Хятадын хил хүртэлх говь цөлийн болон хээрийн бүсэд өргөн тархалттай байсан байна (Feh нар, 2002). Тэр цагаас хойш түүний тархац болон тоо толгой нь багасах үйл явц үргэлжилсээр байжээ (Банников, 1981). Одоо Монгол орны өмнөд хэсгийн говийн нутгуудаар тодруулбал Алтайн өвөр говь, Умард говь, Алашань говь, Зүүнгарын говьд (Reading нар, 2001), Дорнод говийн Их нартын чулуу байгалийн нөөц газрын хойд хэсгээр тархсан (Reading нар, 2006). Саяхны судалгаагаар сүүлийн 20-25 жилийн хугацаанд хулан адууны популяци хуучин тархацаасаа хойш болон зүүн тийш тэлэн шилжиж төмөр зам гаталж Сайншанд хүртэл тархаж байгааг харуулсан (Kaczensky нар, хэвлэлтэнд). Монгол орны өмнөд хэсгийн Зүүнгарын говьд Говийн их дархан газрын Б хэсэгт, Алтайн өвөр говьд Говийн их дархан газрын А хэсэгт чухал популяциуд бий (Feh нар, 2002; Stubbe нар, 2005b; Kaczensky нар, хэвлэлтэнд).

**Ховордлын гол шалтгаан:** Зарим нутагт арьс, махыг нь худалдаалахаар хууль бусаар агнадаг (Duncan, 1992; Stubbe нар, 2005b). Малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхлалд орох боломжтой (тодорхой мэдээ шаардлагатай), байгалийн нөөцийн олборлолт (уул уурхай), хүн ам суурьшсанаас (баянбүрд, задгай усны ойролцоо) амьдрах орчин нь доройтож, хомсдож байна. Улаанбаатар-Бээжингийн чиглэлийн төмөр замын болон Хятад-Монголын хилийн зурвасын торон хашаагаар амьдрах орчныг нь тусгаарлаж жам ёсны шилжилт хөдөлгөөнийг нь саатуулж байна. (Kaczensky нар, хэвлэлтэнд). Нөөцийн олборлолт авто зам барих шинэ төлөвлөгөө хойшид аюул учруулах боломжтой.

## Баг Туруутан

### Овог Гахайнхан

#### 117. *Sus scrofa* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Зэрлэг гахай (Монгол), wild boar (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. s. raddianus*, *S. s. nigripes*


**Ижил нэр:** *S. barbarus*, *S. ferus*, *S. japonica* (Wilson, Reeder (1993) нарын бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн популяцийн талаарх мэдээлэл дутмаг, агнуурын хэмжээ их өндөр, эрлийзжилт болон орчны доройтол зэрэг аюул нүүрлэж байна. Nowak (1991) энэ зүйлийн нэг үе удмын хугацааг дөрвөн жил гэж тогтоосон.



Популяцийн бууралтанд хараа хяналтгүй агналт нөлөөлж, хэрэв популяцийн талаарх мэдээлэл хуримтлагдвал энэ зүйлийг А шалгуураар дахин үнэлэн ховордлын ангилалд оруулах боломжтой. Хил залгаа нутгаас *S. s. sibirica* салбар зүйлийн популяциас цөөнгүй бодгаль нүүдэллэн ирэх боломжтой ч энэ популяцийн агнуурын дарамт нь тодорхой бус байгаас бүс нутгийн шалгуурын үнэлгээг өөрчлөлгүй хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай 2000 оны хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2001 (№264) онд гарсан Засгийн газрын тогтоолоор *S. s. nigripes*-ийг ховор зүйл зэрэглэлээр хамгаалсан. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Есдүгээр сарын 1-нээс арванхоёрдугаар сарын 1 хүртэл агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Засгийн газраас олзны агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 225 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд *S. s. nigripes* салбар зүйлийг ховор зэрэглэлээр тус тус бүртгэсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Зэрлэг гахайн тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

**Дэлхийн тархац:** Энэ зүйлийн түүхэн тархалт нь Евразийг бүхэлд нь хамарч байсан. Одоогоор дэлхийн олон оронд нутагшуулсан (Nowak, 1991).

**Бүс нутгийн тархац:** Монгол орны баруун хэсгээр *S. s. nigripes* салбар зүйл Их нууруудын хотгор, Монгол Алтайн баруун хэсгээр тархсан. *S. s. raddeanus* салбар зүйл нь Хангай, Хөвсгөл, Хэнтий, Монгол Дагуурын хээр, Их хянганы уулсаар тохиолдоно.


**Ховордлын гол шалтгаан:** Үндэсний болон орон нутгийн хэмжээнд махыг нь хүнсэнд хэрэглэх зорилгоор хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг нь энэ зүйлийн ховордуулах гол шалтгаан юм. Малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхлалт, байгалийн болон хүний тавьсан түймэр зэргийн уршгаар орчны доройтолд орж байна. Тархац нутгийн зарим хэсэгт байгалийн нөөцийн олборлол (ой мод ашиглалт) нь орчны хомсдолд оруулж байна. Гэрийн гахайтай эрлийзжих боломжтой бөгөөд тодорхой судалгаа шаардлагатай.

## Овог Тэмээнийхэн

### 118. *Camelus bactrianus ferus* Przewalski, 1878

**Түгээмэл нэр:** Хавтгай, хавтгай тэмээ (Монгол), Bactrian camel, wild camel (Англи).

**Ижил нэр:** *C. ferus* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу). Хавтгай тэмээ гэрийн тэмээнээс ялгаатай тусдаа зүйл байж магадгүй гэдгийг генетек судалгааны урьдчилсан дүн харуулсан (Нап нар, 2002) бөгөөд ангилал зүйн статусыг гүйцэд тогтоохын тулд нарийвчилсан судалгаа шаардлагатай байна.




**Олон улсын үнэлгээ:** Устаж байгаа, A3de болон A4ade

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, C1

**Үнэлгээний үндэслэл:** Монголын популяцийн хэмжээ нь 463 +/-92 үржлийн бодгалиас бүрддэг гэж үнэлсэн (Адъяа, Довчиндорж, 2005). Энэ зүйл одоо орчны хомсдол, халдварт өвчин, бохирдол, эрлийзжилт, цаг уурын тохиромжгүй нөхцөл зэрэг олон зүйлээс ховордож байна. Nowak (1991) нэг үе удмын хугацааг хорин жил гэж тодорхойлсон. Жижиг популяцитай энэ зүйлд үзүүлж буй дээрх нөлөөнүүд дараагийн хоёр үе удамд 20 хүртэлх хувиар үргэлжлэн буурна гэж тооцоод C1 шалгуураар үнэлж Устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн (2000) 7.1-д нэн ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Хавтгай тэмээг агнахыг 1930 оноос хуулиар хориглосон бөгөөд ан агнуурын тухай 1995 оны хуулиар нэн ховор зүйлийн жагсаалтанд оруулсан (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Нүүдэлдэг зүйлийн конвенцид (НЗК) нүүдэг зүйл гэж тэмдэглэсэн. Хавтгай тэмээний тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалтай газарт орсон.



**Дэлхийн тархац:** Хятад, Монголын нутаг дэвсгэрт хавтгай тэмээний дөрвөн жижиг хязгаарлагдмал популяци оршин амьдарч байна. Үүнд Хятадын Гансу мужийн Гашуун говийн популяци; Хятадын Шинжан мужийн Таклимакан цөлд буй популяци (энэ популяци маш ихээр цөөрсөн, одоо бараг устсан); Хятадын Аржиншань уулын умард бэл, түүнтэй хил залгаа Лоб нуурын Хавтгайн байгалийн нөөц газарт байрших популяци; Монголын Хятадтай хил залгаа орших Говийн их дархан газрын А хэсгийн популяциуд (Reading нар, 1999; Mix нар, 2002; Wang нар, 2002) хамаарна.

**Бүс нутгийн тархац:** Энэ зүйлийн тархац нутаг нь Алтайн өвөр говийн (Mix нар, 2002) Эдрэнгийн нурууны бэлээс Шивээт улаан, Хөх төмөртийн нуруу, улсын хил хүртэл тархсан (Адъяа нар, 2004; Адъяа, Довчиндорж, 2005).

**Ховордлын гол шалтгаан:** Гэрийн тэмээтэй эрлийзжих нь ховордох гол шалтгаан болж байна. Эрлийзжилт ямар түвшинд байгаа нь тодорхойгүй байгаа ч малчдын тэмээ хавтгайтай эвцэлдээнд ордог талаар тодорхой мэдээлэл байдаг (R. Reading, аман мэдээ). Гэрийн тэмээ нь Говийн их дархан газрын А хэсгийн нутагт нэвтэрч буй үзэгдэл олон удаа тохиолдож байгаа нь халдварт өвчин тархах, эрлийзжих боломжийг бүрдүүлж болох юм (Walzer, Kaczensky, 2005). Байгалийн нөөцийн олборлол (алт олборлол), хүний сөрөг нөлөөлөл, орчны хомсдол зэрэг нь хойшид хавтгай тэмээнд нөлөөлөх боломжтой (J. Hare, аман мэдээ). Алтны уурхайд төмрийн хүдрийг ялгахад циант калийг ашигласнаас усны нөөцийг нь циантаар бохирдуулж байна (Hare, 2006). Хятад, Монголын хилийн дагуух торон хашаа хавтгайн нүүдэл, хөдөлгөөнд саад болж улмаар Хятадын популяцитай генийн солилцоонд орох байдлыг тусгаарлаж байна. Баянбүрдүүд байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагаанаас болж хуурайшиж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Мөн байгалийн давтамжаар уст цэгүүд цөөрч байгаа эсэх нь тодорхойгүй байна (R. Reading, аман мэдээ). Хавтгай тэмээний ботго руу саарал чоно халддаг нь жижиг популяцийг бууруулах шалтгаан гэж үздэг (M. Stubbe, аман мэдээ).

## Овог Тугалмайтныхан

### 119. *Capra sibirica* (Pallas, 1776)

**Түгээмэл нэр:** Янгир ямаа (Монгол), Siberian ibex, Asiatic ibex (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** Алтайн янгир *C. s. sibirica* Говийн янгир *C. s. hagenbecki*. Олон судлаачид эдгээр салбар зүйлүүдийг синионим гэдэг бөгөөд ангилал зүйг нарийвчлан судлах шаардлагатай (Mallon нар, 1997; Shackleton, 1997).


**Ижил нэр:** *C. altaica*, *C. hagenbecki*, *C. wardi* гэх мэт олон ижил нэрнүүд байдаг (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу). Янгир ямаа нь бусад ямааны зүйлээс салбарласан эсэх нь одоог хүртэл тодорхойгүй байгаа бөгөөд зарим судлаачид *Capra [ibex] sibirica* нэрийг баримталдаг (Shackleton, 1997), Мөн Гептнер нарын (1961) бүтээлийг баримтлан Wilson, Reeder нар (1993) энэ зүйлийг салангид гэж үзсэн.

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Ховордож болзошгүй

**Үнэлгээний үндэслэл:** Монгол улсын улаан номонд Монгол орны янгир ямааны нийт популяци нь 80,000 орчим бодгаль байна (Шагдарсүрэн нар, 1987) гэж үнэлсэнээс хойш популяцийн тоо толгой нөөцийн төлөөх өрсөлдөөн, орчны хомсдол, хараа хяналтгүй агналт зэргээс үүдэн буурсаар байна гэж үзсэн байна (Mallon нар, 1997). Nowak (1991) уг зүйлийн нэг үе удмын хугацааг долоон жил гэж тогтоосон. Энэ зүйлийн одоогийн популяци болон тархац нь ховордож болзошгүй ангилалд ороход хангалттай баталгаа болж байна. Хэт агналтын улмаас популяци дараагийн гурван үе удамд 30-40 гаруй хувиар буурна гэж үзэн хэрэв хамгаалалтын арга хэмжээ авахгүй бол А шалгуураар дахин үнэлэхэд хүргэж болохоор байна. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай 2000 оны хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2001 (№264) онд гарсан Засгийн газрын тогтоолоор ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005), Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор амьтны жагсаалтанд оруулсан (БОЯ, 1996). Монгол улсын засгийн газраас олзвор ан агнах зөвшөөрлийн үнэлгээг Алтайн янгирт 800 ам. доллар, Говийн янгирт 720 ам. доллараар тус тус тогтоожээ. Засгийн газраас 2005 онд 260 ширхэг янгир агнах зөвшөөрлийг хуваарилсан байна (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Янгирын тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар орсон.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Узбекистан (Shackleton, 1997), Афганистан, Пакистан, Хятад (Гансу, Шинжан), Тажикстан (Wilson, Reeder, 1993), Энэтхэг (Химикал Прапеш; Жамму-Кашмир), Киргизстан, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Говь алтайн баруун өмнөд болон зүүн хэсэг, Хангайн нуруу, Хөвсгөлийн уулсаар байршина (Банников, 1954; Дуламцэрэн, 1977). Монгол орны төв болон зүүн хэсгийн нутагт тасархайтсан популяциуд байдаг ч одоогоор энэ зүйл нь Умард говийн зүүн хэсгээс олдсон бөгөөд Алашань говийн Хүрх уул ба Алтайн өвөр говийн хадархаг уулсаар тархсан (Mallon нар, 1997). Хэнтий нуруунд, Дархан цаазат Богд Хан ууланд 1980-аад онд жижиг популяци нутагшуулах ажиллагааг амжилттай хэрэгжүүлжээ. Энэ зүйл нь Их нартын чулуу байгалийн нөөц газрын хойд хэсэгт саяхан тэмдэглэгдсэн (Reading нар, 2006). *C. s. hagenbecki* салбар зүйл нь Алтайн өвөр говь, Говь Алтайн нуруугаар тархсан, *C. s. sibirica* салбар зүйл нь үндсэн тархацын хойд хэсгээр Монгол Алтайн нурууны хойд хэсгээр тархсан (Fedosenko, Blank, 2001).

**Ховордлын гол шалтгаан:** Бүс нутагт мах болон арьсыг худалдаалах, гадаадын анчдад агнуулдагаас хууль бус болон хяналтгүй агнах нь ховордлын гол шалтгаан болсоор байна. Зарим нутагт малын тоо толгой өсөж бэлчээрийн талхлалт бий болсноор орчны доройтол үүсэж ус, бэлчээр байршил нутгаар хавчигдаж, малтай өрсөлдөж байна (тодорхой мэдээ шаардлагатай). Байгалийн нөөцийн олборлолт (уул уурхай) ихэссэнээс орчны хомсдол, доройтолд хүргэж байна. Зуд турхантай өвөл цаг уурын нөхцөлүүд популяцид нэлээд хохирол учруулж байна.

## 120. *Gazella subgutturosa* (Güldenstädt, 1780)

**Түгээмэл нэр:** Хар сүүлтий (Монгол), goitered gazelle, black-tailed gazelle (Англи).


**Монгол дахь салбар зүйл:** *G. s. hillieriana*. Монгол дахь салбар зүйлийн ангиллын талаарх нарийвчилсан судалгаа шаардлагатай.

**Ижил нэр:** *G. mongolica*, *G. hillieriana*, *G. gracilicornis* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу).

**Олон улсын үнэлгээ:** Эмзэг, A2ad

**Бүс нутгийн үнэлгээ:** Эмзэг, A3cde

**Үнэлгээний үндэслэл:** Энэ зүйлийн Монголын тархац болон популяцийн хэмжээ 1940 оноос 1960 оны хооронд 30 хувиар буурсан байна (Lkhagvasuren нар, 2001). Популяцийн хэмжээг 1990-ээд онд нийт популяци 60,000 орчим бодгалиас тогтож байна гэж үнэлсэн (Амгалан, 1995). Популяцийн бууралтанд нөлөөлж байгаа гол шалтгаан нь замбараагүй, хяналтгүй агналт боловч орчны доройтол, нөөцийн өрсөлдөөн, хүний санаатай үйлдэл зэрэг нь бас нөлөөлж байна. Nowak (1991) энэ зүйлийн нэг үе удмын хугацааг таван жил гэж тогтоосон. Дээрх шалтгааны нөлөөнөөс болж популяцийн бууралт дараагийн гурван үе удамд 30 хувь буурна гэж үзээд уг



зүйлийг A3cde шалгуураар үнэлж Эмзэг гэсэн ангилалд орууллаа. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай хууль (2000), Засгийн газрын тогтоолоор (2001 оны №264) ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар энэ зүйлийг ховор зэрэглэлд оруулсан (БОЯ, 1996). Засгийн газраас агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 450 ам.доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Хар сүүлтийн тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Турк, Сири, Саудын Араб, Бахрайн, Йордан, Ирак, Йемен, Иран, Азербайжан, Казахстан, Арабын Нэгдсэн Эмират улс, Оман, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Киргизстан, Хятад, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Нэлээд уудам тархацтай боловч нягтшил нь бага байдаг. Одоо Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Дорнод говь, Алашань говьд элбэг тархсан (Банников, 1954; Соколов, Орлов, 1980; Амгалан, 1984, 1986; Lkhagvasuren нар, 1999).

**Ховордлын гол шалтгаан:** Олзвор агнуураас гадна махыг нь ашиглах зорилгоор хууль бусаар агнаж байгаа нь ховордох гол шалтгаан юм. Энэ зүйл ус бага хэрэглэдэг хэдий ч малын тоо толгой өссөнөөс үүдэн баянбүрд ашиглах өрсөлдөөн бий болсноор бэлчээрийг доройтуулж болзошгүй (тодорхой судалгаа шаардлагатай). Одоогоор нөөцийн олборлол (уул уурхай) нь орчны хомсдолд ноцтой нөлөөлөөгүй ч хэрэв идэвхтэй үргэлжилбэл зарим газар хүний садаа зэргээс шалтгаалж уг зүйл ховордож болзошгүй.


## 121. *Ovis ammon* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Аргаль хонь, архар (Монголын Алтай, Казах хэл), argali (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** Алтайн аргаль хонь *O. a. ammon*, Говийн аргаль хонь буюу Монгол аргаль хонь *O. a. darwini* гэсэн хоёр салбар зүйл бий гэж өмнө нь үздэг байсан. Гэвч аргаль хонины генетикийн сүүлийн үеийн судалгаагаар Монгол орны бүх аргаль хонь нэг салбар зүйлд хамаарна гэж үзсэн (Tserenbataa, 2003; Tserenbataa нар, 2004).

**Ижил нэр:** *O. altaica*, *O. argali*, *O. blythi* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс илүү тодорхой харна уу).

**Олон улсын үнэлгээ:** Эмзэг, A2cde зэрэглэлээр үнэлэгдсэн. Говийн аргаль хонь (*O. a. darwini*) нь Устаж болзошгүй, C1; Алтайн аргаль хонь (*O. a. ammon*) нь Эмзэг A2cde болон C1 гэсэн нарийвчилсан үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн.



**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, A2acde болон A3cde

**Үнэлгээний үндэслэл:** Популяцийн тоо толгой 1975 онд 50,000 бодгаль, 1985 онд өсөж 60,000 бодгаль болсон бөгөөд харин 1994 онд популяцийн хэмжээ ихээхэн буурч 20000 орчим бодгаль болсон (Reading нар, 1997), 2001 онд 13,000-15,000 бодгаль болж үргэлжлэн буурсаар байна (Амгаланбаатар нар, 2002). Үүнээс үзэхэд популяцийн хэмжээ өнгөрсөн 26 жилд 72 хувь буурсан байна (Zahler нар, 2004). Nowak (1991) энэ зүйлийн үе удмын хугацааг таван жил гэж тогтоосон. Хараа хяналтгүй агнуур болон орчны хомсдол, доройтол, нөөцийн төлөөх өрсөлдөөн бий болсоны улмаас өнгөрсөн гурван үе удмын хугацаанд 50 хувь буурсан гэж A2acde шалгуураар үнэлээд устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Хэрэв дараагийн гурван үе удмын хугацаанд популяци нь үргэлжлэн буурвал энэ зүйлийг A3cde шалгуураар үнэлэн устаж болзошгүй гэсэн ангилалд оруулж болно. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай хуулинд (2000) өөрчлөлт оруулж (2001) (засгийн газрын тогтоол №264) ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Агнахыг 1953 оноос хойш хуулиар хориглосон. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). ХЗОХК-ын Хавсралт II-т орсон. ХЗОХК-ын зөвшөөрлөөр экспортлосон хэмжээ 2005 оны байдлаар; 80 ширхэг агнасан эвэртэй аргаль хонь болон 44 ширхэг арьс, эвэртэй (UNEP-WCMC, 2006). Монгол улсын засгийн газраас гадаадын анчдад 18000 ам. доллар болон 9000 ам. доллараар агнах зөвшөөрлийн бичгийг өгдөг (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр тус тус орсон (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Аргаль хонины тархац нутгийн 14 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Узбекистан, Афганистан, Киргизстан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Балба, Монгол, Бутан. Алтайн аргаль хонь Хятад, Монгол, Оросын Холбооны Улс, Говийн аргаль хонь Хятад, Монголоос олдсон.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны зүүн хэсгээс бусад нутгаар тасархайтсан байдлаар тэгш өндөрлөгүүд, хадан цохио, уулс, дов толгодоор тааралддаг байсан. Энэ тархац нь өнгөрсөн хэдэн арван жил нэлээд тасархайтсан байна (Mallon нар, 1997; Amgаланбаатар, Reading, 2000; Амгаланбаатар нар, 2002; Amgаланбаатар нар, 2002). Одоогоор энэ зүйл говийн бүсийн умард хэсгээс, хээр, ойт хээр, уулын тайгын өмнөд хэсэг хүртэлх Монгол Алтай, Говийн Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Алашань говь, Дорнод говийн бэсрэг уулсаар тархсан (Банников, 1954; Соколов, Орлов, 1980; Fedosenko, Blank, 2005). Мөн Төв халхын зарим уулс, Хан хөхийн нуруу, Хангайн нуруу, Хөвсгөлийн Арсайн гол орчим тасархайтсан популяциуд бий (Дуламцэрэн, 1970; Соколов, Орлов, 1980; Reading нар, 1997; Reading, 2000; Адъяа, Төмөрсүх, 2001; Amgаланбаатар нар, 2002; Fedosenko, Blank, 2005).


**Ховордлын гол шалтгаан:** Хууль бус агнуур, эврийн төлөөх гадаадын анчдын тогтвортой бус (тооцоонд үндэслээгүй) агнуур энэ зүйлийн ховордлын гол шалтгаан болж байна (Amgаланбаатар нар, 2002). Түүний ховордлын зэргийг үл тоомсорлосноос угалзын олзвор агнуурын зөвшөөрлийн тоо өссөөр байгаа (Zahler нар, 2004) ба ШУА-аас тогтоосон хэмжээнээс даваад байна (Zahler нар, 2004; Wingard, Zahler,

2006). Хууль бус агнуурын ихэнх хувийг нохойтой агналт эзэлж байна (Reading нар, 2003; 2005). Жил дараалсан ган, зудаас болж аргаль хонь ихээр хорогдож байна. Мөн малын тоо толгой өссөнөөр бэлчээр нутаг нь хумигдаж, талхлагдаж буй нь ховордлын шалтгааны нэг болж байна. Байгалийн нөөцийн олборлолтын (уул уурхай) үйл ажиллагаа ихэссэнээс орчны хомсдол бий болж байгаа бөгөөд эдгээр нь аргаль хонинд ямар нөлөөлөл үзүүлж буйг нарийвчлан судлах шаардлагатай байна (Reading нар, 1997; 2003; 2005; Wingard, 2005).

## 122. *Procapra gutturosa* (Pallas, 1777)

**Түгээмэл нэр:** Цагаан зээр (Монгол), Mongolian gazelle (Англи).


**Ижил нэр:** *P. altaica*, *P. orientalis* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, A4cde

**Үнэлгээний үндэслэл:** Одоогоос 80 жилийн өмнө 4,75 саяас их гэж үнэлэгдсэн (Milner-Gulland and Lkhagvasuren, 1998). 1978, 1979 онуудад 250,000-аас 270,000 болон 250,000 толгой зээрээс тус тус тогтож (Цагаан, 1980; Sokolov, Lushchekina, 1997), 1980 онд ган гачиг болон өвчний улмаас ойролцоогоор 150,000-180,000 болон буурсан. 1981 онд популяцийн тоо толгой өсч 300,000-аас 400,000 хооронд тоологдсон байна (Луцкекина нар, 1983). Хамгийн сүүлд үндэсний хэмжээнд хийсэн судалгаагаар 2002 онд Дорнод Монголын цагаан зээрийн тоо толгойг 800,000-900,000 гэж үнэлжээ (Olson нар, 2005). Өнгөрсөн 20 жилд 180,000-аас (Луцкекина, 1990) 2,67 саяд хүрч популяци нэлээд хэлбэлзэж байв (агаарын судалгааны тооллогоор стандарт алдаа 472,000 гарсан). Судалгааны арга зүй болон чиглэлүүд өөр байснаас популяцийн үнэлгээ нэлээд зөрж байсныг анхаарах нь зүйтэй (Milner-Gulland, Lkhagvasuren, 1998). Популяцийн одоогийн хэмжээг нарийвчлан тогтоох буурьтай судалгаа шаардлагатай байна. Хэдий тийм ч 2000 оны байдлаар энэ зүйлийн тархац ХХ зууны дунд үеийн тархацын дөрөвний нэгээс бага байна (Lkhagvasuren нар, 2001). Одоогийн популяцийн хэмжээ нь хараахан сайн тогтоогдоогүй бөгөөд хараа хяналтгүй агнуур болон орчны хомсдол, хуваагдал, доройтол, нөөцийн төлөөх өрсөлдөөн, хүний садаа зэргүүд нь энэ зүйлийн тоо толгойг бууруулахад нөлөөлж байна гэж үздэг. Нэг үе удмын үргэлжлэх хугацааг таван жил гэж ойролцоо зүйлээр жишин гаргав. 1996 оноос 2011 оны хооронд популяци дээрх шалтгаануудаас 50 гаруй хувиар буурна гэж үзээд энэ зүйлийг A4cde шалгуураар үнэлэн устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.



**Хамгаалсан байдал:** Агнуурыг 1932 оноос хяналттай явуулж байсан ба бүс нутгийн хэмжээнд албаны хэрэгцээнд агнах тоо хэмжээг тогтоож ирсэн байна. Жил бүрийн

есдүгээр сарын 1-нээс арванхоёрдугаар сарын 1 хүртэл агнахыг хуулиар зөвшөөрсөн (БОЯ, 2005). 1995 оны Агнуурын тухай хуулиар цагаан зээрийг техникээр агнахыг хориглосон ба хэрэв хууль бусаар агнавал нэг бүрийн үнэ нь 30-40 ам.доллар гэж тогтоосон. Засгийн газар олзворын ангийн зөвшөөрлийн үнэлгээг 90 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Цагаан зээрийн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Хятад, Монгол

**Бүс нутгийн тархац:** Урьд нь Монгол орны цөлөрхөг хээр болон хээрийн бүсээр тархаж, тархац нутгийн хэмжээ нь 780,000 орчим км<sup>2</sup> байсан байна (Банников, 1954). Монгол орны төв болон өмнөд хэсгүүдэд популяци хуваагдсан байна (Lkhagvasuren нар, 2001). Монгол орны Дорнод Монгол, Төв Халх, Умард говь, Дорнод говь, Нууруудын хөндийн зүүн хэсгээр тархсан. Монгол орны зүүн хойд хэсэг болох Дорнод аймагт өвөлждөг, мөн Хэнтий нурууны зүүн болон өмнөд хэсэгт өвөлждөг гэсэн саяхны мэдээ бий (K. Olson, аман мэдээ). Их нууруудын хотгорын Хомын талын хээрт 1980 оны сүүлчээр 1990 оны эхээр Монгол орны зүүн хэсгийн популяциас тэтгэгддэг тусгаарлагдсан популяци байсан. Цагаан зээр байнга нэг газар удаан байдаггүй шилжин нүүдэг учир тархац өссөн эсвэл эрс ялгаатай мэт сэтгэгдэл төрүүлдэг (Дуламцэрэн нар, 1989).

**Ховордлын гол шалтгаан:** Албан ёсны агнуурын тооноос хууль бус агнуурын хэмжээ давж, өргөн цар хүрээгээр агнаж байгаа нь ховордлын гол шалтгаан юм (Lkhagvasuren, Milner-Gulland, 1997). Milner-Gulland, Lkhagvasuren (1998) нарын гаргасан агнуурын загвар нь нэг сая толгой бүхий популяциас жилд 60,000 толгойг агнах даацтай гэж үзсэн ч одоогоор агнасан хэмжээ нь 300 гаруй хувиар давж байна (Wingard, Zahler, 2006). Дорнод Монголд 1977 оны өвөл 70,000 орчим цагаан зээр бэлтгэсэн байсан (Sokolov, Lushchekina, 1997) бол 2004 онд нийт 250,000 зээр агнасан байна (Wingard, Zahler, 2006). Улаанбаатар Бээжингийн чиглэлийн галт тэрэгний замын давхар хашлага нь Монгол орны зүүн хэсэг дэх гол популяцийг хувааж байгаа нь байдлыг улам хурцатгаж байна. Орос Монголын, Хятад Монголын хилийн зурвасын дагуух хашаа нь тодорхой жил, улирлаар соргог бэлчээрт хүрэхэд саад болдог (Takahaiko нар, 2005). Цагаан зээрийн тархацын зарим нутагт нөөцийн олборлолт (ялангуяа газрын тос) өсөж байгаа нь ховордуулах шалтгааны нэг болж байна. Хүн, малын нягтшил ихтэй газруудад өрсөлдөөн болон шүлхий, хөлийн өвчнүүд гэх мэт халдварлах өвчин байдаг нь ховордуулах шалтгааны тоонд орж байна. (Schaller, Lkhagvasuren, 1998; Campos-Arceiz нар, 2004). Зарим зудтай өвөл энэ зүйл цагаан зээр ихээхэн хорогддог.

### 123. *Saiga tatarica* (Linnaeus, 1766)

**Түгээмэл нэр:** Бөхөн, Татаар бөхөн (Монгол), saiga antelope (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *S. t. mongolica*. *S. t. tatarica* нь өнгөрсөн 40 жилд Монголд бүс нутгийн хэмжээнд устсан гэж үздэг (Дулмаа, Шагдарсүрэн, 1973; Lkhagvasuren нар, 2001).

**Ижил нэр:** *S. colus*, *S. mongolica*, *S. saiga*, *S. scythica* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу).

**Олон улсын үнэлгээ:** Устаж байгаа, A2a; *S. t. mongolica* салбар зүйл нь Устаж болзошгүй, A2ad болон C1 болон 2a(ii) хэмээн нарийвчлан үнэлэгдсэн байна.


**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, A2acde

**Үнэлгээний үндэслэл:** Монгол улсын ШУА-ийн Биологийн хүрээлэн, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн жил бүрийн судалгаагаар Монголын нийт популяци 1998 онд 2,950-иас өсөж 2000 онд 5,240 бодгальд хүрсэн байна (Дуламцэрэн, Амгалан, 2003).

Монголд хоёр тусгаарлагдсан популяци байдаг бөгөөд Шаргын говийн популяци 2001 онд 1,600-3,000 бодгаль, Манханы популяци 35 орчим бодгаль гэж үнэлсэн байна (Mallon, Kingswood, 2001). Монголын нийт популяци 2002 онд ойролцоогоор 1,020; 2003 онд 750 болж буурсан бөгөөд одоогийн популяци нь 2004 оны байдлаар 800 бодгаль болсон (WWF, 2004; Zahler нар, 2004). Саяхны судалгаагаар 2005 онд нийт популяци 1,500 бодгалиас тогтож байна гэж үнэлсэн (Л. Амгалан, аман мэдээ). Nowak (1991) Татаар бөхөнгийн нэг үе удмын хугацааг таван жил гэж тогтоосон. Тиймээс энэ зүйл цаг уурын зарим нөхцлөөс, орчны доройтол, нөөцийн төлөөх өрсөлдөөн, хараа хяналтгүй агнуур (бага түвшинд тохиолдоно) зэргээс өнгөрсөн гурван үе удмын хугацаанд 50 гаруй хувиар буурсан гэж үзэн A2acde шалгуураар үнэлэн устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Мөн байгаль орчны өөрчлөлт хэсэгчлэн явагдаж, популяцийн тоо толгойн огцом хэлбэлзэл, бэлчээрийн талхлалт, агналт зэрэг нэмэлт нөлөөгөөр байгалийн тоо толгойгоо барьж чадахгүйд хүргэж байна. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын Хавсралт II-т орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн (2000) 7.1-д нэн ховор зэрэглэлд хоёр салбар зүйлийг оруулсан (Бадам, Ариунзул, 2005). 1930 оноос хойш агнахыг хуулиар хориглосон бөгөөд Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулинд нэн ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор зэрэглэлд хоёр салбар зүйл тус тус орсон (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Монгол бөхөнгийн тархац нутгийн 24 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт орсон.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Туркменистан, Узбекистан, Монгол. *S. t. mongolica* Монголын эндемик, *S. t. tatarica* Монгол, Украйнд бүс нутгийн хэмжээнд устсан.



**Бүс нутгийн тархац:** *S. t. tatarica* Монгол орны баруун хэсгийн Зүүнгарын говьд олдож байсан (Банников, 1954; Дулмаа, Шагдарсүрэн, 1973; Lkhagvasuren нар, 2001). Одоо *S. t. mongolica* Монгол орны баруун хэсэгт хуучин тархац нутгийн зөвхөн 20 хувь-д нь тусгаарлагдсан хоёр жижиг популяци байдаг. Популяцийн ихэнх нь (90 хувь) Говь Алтай нурууны хойд хэсгийн цөлөрхөг хөндий болох Шаргын говьд 2000 км<sup>2</sup> тархац нутгийг хамарч байна. Нөгөө популяци нь Шаргын популяциас хойш 200 км-т Хар ус нуурын өмнөд хэсэг дэх Манхан элсэнд 200 орчим км<sup>2</sup> тархац нутгийг хамарч байна (Дуламцэрэн, Амгалан, 1995). Их нууруудын хотгорын Хүйсийн говь, Хүрэн талын орчмоор тааралдана (Лущекина, Дуламцэрэн, 1997; Дуламцэрэн, Амгалан, 2003). Энэ зүйлийн нийт тархац нутаг нь ойролцоогоор 13000км<sup>2</sup>.


**Ховордлын гол шалтгаан:** Популяци маш цөөн тооны бодгальтай учраас зуд гэх мэт байгалийн гэнэтийн үзэгдлүүдэд өртөмтгий байдаг (Lkhagvasuren нар, 2001). Бусад зүйлтэй харьцуулбал Монголд агналт харьцангуй бага түвшинд байгаа ч агналт хийх явдал нь маш цөөн бодгальтай популяцид нэлээдгүй нөлөөлнө (Lkhagvasuren нар, 2001). Эрэгчний эврийг ардын эмнэлэгт ашиглах зорилгоор хууль бусаар агнаж байгаа нь хүйсийн харьцааг алдагдуулж байна (Zevogmid, Dawaa, 1973). Малын тоо толгой өссөнөөс амьдрах орчны хомсдол, доройтол бий болж, популяцийн хэмжээг бууруулах дам шалтгаан болдог гэж үзэж байна. Мал бэлчээр, усны нөөцийг эзэмшсэнээс нөөцийн төлөө өрсөлдөөнийг бий болгож байна гэж үздэг ч цаашид нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай (Дуламцэрэн, Амгалан, 1995; Zahler нар, 2004). Малаас халдварт өвчин, паразит (*Pallasiomyia antilopum* зэрэг паразит ялаа) халддаг нь энэ зүйлийг ховордолд хүрэх бас нэг аюул болдог.

## Овог Хүдрийнхэн

### 124. *Moschus moschiferus* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Хүдэр, баданга хүдэр (Монгол), Siberian musk deer (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *M. m. moschiferus* (Цэнджав, 2002 бүтээлээс нарийвчлан харна уу). Хүдрийн бүлгийн ангилал нь бүрэн гүйцэд шийдэгдээгүй хэвээр байна. Энэ зүйлийн голдуу *Cervidae* овогт багтаадаг.



**Олон улсын үнэлгээ:** Эмзэг, A1acд

**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, A3d

**Үнэлгээний үндэслэл:** Монгол орны популяцийн хэмжээ 1970 онд 60,000-80,000-д хүрсэн байна (Дуламцэрэн, 1977). ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс 1986 онд 6 аймгийн 63 сумын нутагт тооллого явуулж Монголын нийт популяци 44,000 бодгаль гэж үзсэн (Дуламцэрэн, 1989). Түүнээс хойш популяци нь буурсаар 1990-ээс 2000 оны байдлаар нэг удаагийн популяцийн судалгаанд нягтшил нь 1км<sup>2</sup>-д 1,2-оос



0,2 болтлоо буурсан байна (Цэнджав, Бүжинханд, 2000; Цэнджав, 2002). Nowak (1991) хүдэрийн нэг үе удмын хугацааг зургаан жил гэж тогтоосон. Хараа хяналтгүй агналт нь энэ зүйлийн популяцийн буурах шалтгаан болж дараагийн гурван үе удмын хугацаанд 50 хувь хүртэл буурна гэж үзээд, энэ зүйлийг АЗд шалгуураар үнэлэн устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Оросын популяциас дэмжигдэх боломжтой ч хууль бус агнуур газар аваад байна. Тиймээс бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг өөрчлөгдөөгүй хэвээр үлдээсэн. Хэрэв энэ зүйлийн агналтыг багасгах хамгааллын үйл ажиллагааг явуулахгүй бол Устаж байгаа гэсэн ангилалд ороход ойрхон байна.

**Хамгаалсан байдал:** ХЗОХК-ын II хавсралтад орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн (2000) 7.1-д нэн ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Ариунзул, 2005). Агнахыг 1953 оноос хойш хуулиар хориглосон. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар нэн ховор амьтдын жагсаалтанд орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын удаах хэвлэлд нэн ховор зэрэглэлд бүртгэсэн (Шийрэвдамба нар, 1997). Хүдэрийн тархац нутгийн 13 орчим хувь улсын тусгай хамгаалалтай газарт орсон.

**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Афганистан, Пакистан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Монгол, Бутан, Мьянмар, Вьетнам, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (Цэнджав, 2002).

**Бүс нутгийн тархац:** Монгол алтайн хойд хэсгийн ойт нутаг (Тогтохбаяр нар, 2000) Хөвсгөл, Хэнтийн тайгын ойт хэсгээр, Хангайн уулсын зарим нутаг (Сосорбарам, 1970; Дуламцэрэн, 1977; Дуламцэрэн нар, 1989), Хан хөхийн уулсын баруун хойт хөвчөөр тархсан (Дуламцэрэн нар, 1989; Wemmer, 1998; Цэнджав, 2002).

**Ховордлын гол шалтгаан:** Гирээний заарыг авахын тулд хууль бус болон хараа хяналтгүй агнах нь ховордох гол шалтгаан болж байна. 1990 оноос 2001 оны хооронд хууль бусаар болон бэлтгэлээр 25,000 толгой бие гүйцсэн гирээг агнасан гэсэн үнэлгээ бий (Homes, 2004). Хүдрийн заарыг авахын тулд нас, хүйс ялгалгүй дөрвөөс таван хүдэр агнадаг гэж үнэлсэн (Green, 1987). Одоо сүрчгийг синтетик эдээр хийдэг нь илүү нийтлэг болсон бөгөөд үйлдвэрийн аргаар заараар сүрчиг хийх нь буурч байгаа хэдий ч ардын эмнэлэгт амьсгалын болон зүрх судасны өвчинг анагаахад ашигладаг тул өндөр үнэтэй хэвээр байна. Байгалийн нөөцийн олборлол (уул уурхай, мод бэлтгэл) нь одоогоор орчны хомсдолд эрчимтэй нөлөөллөөгүй ч хүний үйл ажиллагаанаас болж энэ зүйл ховордож байна. Амьдрах орчны хуваагдал мөн ховордлын шалтгааны нэг болж байна (Цэнджав, Бүжинханд, 2000).

## Овог Бугынхан

### 125. *Alces alces* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Хандгай, молцог хандгай (Монгол), moose (Англи, Хойд америкийн популяци) elk, Eurasian elk (Англи, Евразийн популяци).

**Монгол дахь салбар зүйл:** Хар мөрний молцог хандгай *A. a. cameloides*, Шивэр молцог хандгай *A. a. pfizenmayeri* (Geist, 1998 харна уу).

**Ижил нэр:** *A. americanus*, *A. columbae*, *A. pfizenmayeri* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй


**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж болзошгүй, A2cd, A3d

**Үнэлгээний үндэслэл:** Монгол оронд хар мөрний молцог хандгайн ганцхан жижиг популяци байдаг. Нөмрөгийн дархан газарт 2004 онд 73 бодгаль байсан (К. Olson, аман мэдээ). Харин Монгол орны шивэр молцог хандгай тоо толгойгоор нэлээд олон бөгөөд Хангай, Хэнтийд 1989 онд 10,000 гэж тоологдсон ба энэ нь популяцийн 70 хувь юм.

Популяцийн тоо толгой буурч байгаа нь мэдэгдэж байгаа бөгөөд 1926 оноос 1985 оны хооронд 1,5 сая тонн хандгайн эвэр Орос улсад экспортлосон байна (Wingard, Zahler, 2006). Nowak (1991) энэ зүйлийн үе удмын хугацааг есөн жил гэж тогтоосон. Орчны хомсдол, бохирдол, хараа хяналтгүй агнуураас шалтгаалан өмнөх гурван үе удмын туршид популяци 50 гаруй хувь буурсан гэж үзээд энэ зүйлийг A2cd шалгуураар үнэлэн Устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Тоо толгой буурсан бусад том хөхтөн амьтдын адил анчид болон худалдаачдын тоо өссөнөөс энэ зүйлийг агнах нь ихсэж байна (Pratt нар, 2004). Иймээс дараагийн 3 үе удмын хугацаанд ч үргэлжлэн буурна гэж үзээд энэ зүйлийг A3d шалгуураар үнэлэн устаж болзошгүй гэсэн ангилалд оруулсан. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн хуулийн 7.1-д хоёр салбар зүйлүүдийг нэн ховор зэрэглэлд бүртгэн хамгаалсан байна (2000) (Бадам, Ариунзул, 2005). Агнахыг 1953 оноос хуулиар хориглосон. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар нэн ховор, ховор зэрэглэлээр тус тус орсон (БОЯ, 1996). Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор зэрэглэлд бүртгэсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Хандгайн тархац нутгийн 20 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт, Хар мөрний молцог хандгайн бүх тархац нутаг нь Нөмрөгийн дархан цаазат газарт орсон.

**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн Улс, Норвеги, Чех, Словен, Хорват, Швед, Польш, Унгар, Словак, Финланд, Румын, Латви, Литва, Эстони, Украин, Беларусь, Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол. Хар мөрний молцог хандгай нь



Оросын Холбооны улс, Хятад, Монгол орны зүүн хэсгээр нутагладаг, Шивэр молцог хандгай нь Евроазийн бүх нутагт тархжээ (Hundertmark нар, 2002).

**Бүс нутгийн тархац:** Хар мөрний молцог хандгай нь зөвхөн Монгол орны зүүн хэсэгт Их хянганы уулс, ихэнхдээ Халх, Нөмрөг голуудын ай саваар тархацтай (Shagdarsuren, Stubbe, 1974; Шийрэвдамба нар, 1997). Шивэр молцог хандгай нь Монгол орны Хэнтий, Хөвсгөлийн тайга, Онон, Хэрлэн, Туул, Хараа, Ерөө, Минж голуудын ай саваар голдуу тохиолдоно. Мөн Хөвсгөлд Хорьдил сарьдаг, Цагаан уул, Их далбай голуудын саваар үзэгдэнэ. Хангай нурууны хойд хэсэг болох Бүтээлийн нуруу, Бүрэнгийн нурууны зүүн хэсэг газруудад тааралддаг (Банников, 1954; Гептнер нар, 1961; Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Ардын эмнэлэгт мах, арьс, эвэр, хошуу зэрэг нь үнэт түүхий эд болдог учраас хууль бусаар агнадаг. Уул уурхайн үйл ажиллагаанаас болж усны нөөц бохирдож (алтны уурхай болон эрдэс олборлол), энэ зүйлийг орчны хомсдолд оруулж байна. Бусад том хөхтөн амьтадтай нөөцийн төлөөх өрсөлдөөнд ордог нь мөн ховордох шалтгаан болж байгаа бөгөөд ховордлын шалтгааныг тодорхой судлах шаардлагатай.

## 126. *Capreolus pygargus* (Pallas, 1771)

**Түгээмэл нэр:** Бор гөрөөс (Монгол), Siberian roe deer, eastern roe deer (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *C. p. tianschanicus*

**Ижил нэр:** *C. bedfordi*, *C. ochracea*, *C. ferghanicus* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу).



**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Үнэлгээний үндэслэл:** Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Есдүгээр сарын 1-нээс арванхоёрдугаар сарын 1 хүртэл агнахыг хуулиар зөвшөөрдөг (БОЯ, 2005). Засгийн газар олзворын агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 550 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Бор гөрөөсний тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаардаг.



**Дэлхийн тархац:** Оросын Холбооны Улс, Казахстан, Хятад, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс.

**Бүс нутгийн тархац:** Монгол орны ойн бүсийн нийт нутгаар тархсан (Банников, 1954; Соколов нар, 1982; Дуламцэрэн нар, 1989) тухайлбал Дорнод Монголын хилийн бүсэд орших Лхачинвандан уулын орчимд, Хангай нуруу, Хөвсгөлийн Дархад, Хэнтий нуруу, Их хянганы уулс, Монгол алтай нурууны зүүн хойд хэсэгт тархсан.

**Ховордлын гол шалтгаан:** Орон нутгийн хэмжээнд мах, эврийг нь ашиглах зорилгоор хараа хяналтгүй агнадаг. Одоогоор ховордох шалтгаан бага байгаа ч малын тоо толгойн өсөлтөөс бэлчээрийн талхлалт болон нөөцийн олборлолтын идэвхтэй үйл ажиллагааны уршгаас орчны доройтол, хүний садаа нүүрлэх боломжтой.

### 127. *Cervus elaphus* Linnaeus, 1758

**Түгээмэл нэр:** Халиун буга (Монгол), red deer (Англи, Евразийн популяци), wapiti (Англи, Америкийн популяци).

**Монгол дахь салбар зүйл:** *C. e. sibiricus*. Энэ мэдээний зорилгод нийцүүлэн Монголын бүх халиун бугыг энэ салбар зүйл гэж үзсэн. Зарим судлаачид *C. e. alashanicus*, *C. e. songaricus*, *C. e. xanthopygus*, *C. e. wachei* гэх мэт хэд хэдэн өөр өөр салбар зүйл бий гэж үздэг. Бусад судлаачид Азийн бүх бугыг *C. e. canadensis* тай ижил үзсэн (Geist, 1998, харна уу).

**Ижил нэр:** *C. alashanicus* *C. hagenbecki* *C. maral* (Wilson, Reeder, нарын (1993) бүтээлээс тодорхой харна уу).

**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй


**Бүс нутгийн үнэлгээ:** Устаж байгаа, A2acd, A3d

**Үнэлгээний үндэслэл:** Засгийн газрын тооллогоор 1986 онд 115,000 км<sup>2</sup> нутагт 130,000 бодгаль байсан (Дуламцэрэн нар, 1989) бол 2004 онд 15 аймагт 8,000-аас 10,000 бодгаль болж сүүлийн 18 жилийн дотор 92 хувь буурсан байна (Zahler нар, 2004). Nowak (1991) энэ зүйлийн үе удмын хугацааг зургаан жил гэж тогтоосон.

Хараа хяналтгүй агналт, мөн орчны хомсдолоос өмнөх гурван үе удмын хугацаанд популяци 80 гаруй хувь буурсанаас A2acd шалгуураар үнэлэн Устаж байгаа гэсэн ангилалд оруулсан. Мөн дээрх шалтгаанууд ялангуяа хараа хяналгүй агналт зэргээс популяци дараагийн гурван үе удмын хугацаанд үргэлжлэн буурна гэж үзээд A3d шалгуураар үнэлэн Устаж байгаа гэсэн ангилалд оруулсан. Оросын Холбооны Улсын популяциас сэлбэгдэх боломжтой боловч уг популяцийн статус болон агнуурын дарамтын талаарх тодорхой мэдээ шаардлагатай байна. Бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийг (2000) (засгийн газрын тогтоол №264) өөрчлөн (2001) ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Алтанзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулинд ховор зүйлийн жагсаалтанд оруулсан (БОЯ, 1996). Популяцийн тоо толгой буурч байгаа боловч агналтын зөвшөөрлийн тоог гаргаагүй байна (Wingard, Zahler, 2006). Халиун бугын тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт орсон.

**Дэлхийн тархац:** Голарктик: Канадын өмнөд хэсэг, Америкийн Нэгдсэн улсын ихэнх хэсэг, Мексикийн хойд хэсэг, баруун хойд Африк, баруун болон зүүн Европ, Бага Ази,



Сибирийн өмнөд хэсэг, Кавказ, Төв ази, Хятадын хойд болон баруун хэсэг, Гималайн бүс нутаг, Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улс (Nowak, 1991)

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөл, Хангай, Хэнтий нурууд, Их хянганы уулс, Монгол алтайн Говь Алтайн нуруу (Дуламцэрэн, 1989), тархацын зүүн урд нутагт 18-р зуунд ойтой байсан уул толгодоор нутагшуулсан тусгаарлагдсан популяци бий (Соколов нар, 1982; Дуламцэрэн нар, 1989).


**Ховордлын гол шалтгаан:** Энэ зүйлийн ховордлын гол шалтгаан нь хууль бус агналт юм. Одоогоор 1 кг эвэрний арилжааны үнэ ойролцоогоор 60-100 ам. доллар хүрдэг байна. Бас эврээр хийсэн бусад бүтээгдэхүүн болон бугын чив, засаа, согооны сүүл зэрэг эрхтэн ардын эмнэлэгт үнэ хүрдэг (Zahler нар, 2004; Wingard, Zahler, 2006). Дэд бүтцийн хөгжил, нөөцийн олборлолын (уул уурхай) үйл ажиллагаа зэргээс шалтгаалж орчны хомсдол, амьдрах орчны хуваагдал, хүний садаа зэрэг нь ховордуулах шалтгаан болж байна.

## 128. *Rangifer tarandus* (Linnaeus, 1758)

**Түгээмэл нэр:** Цаа буга, буган цаа (Монгол), reindeer, caribou (Англи).

**Монгол дахь салбар зүйл:** *R. t. valentinae*

**Ижил нэр:** *R. caribou*, *R. valentinae*, *R. granti* (Wilson, Reeder нарын (1993) бүтээлээс нарийвчлан харна уу). Тэжээвэр популяци зэрлэг популяциасаа генетикийн хувьд ялгаатай (Geptner нар, 1961).




**Олон улсын үнэлгээ:** Анхааралд өртөхөөргүй

**Бүс нутгийн үнэлгээ:** Эмзэг, D1

**Үнэлгээний үндэслэл:** Монгол орны популяци 1,000-аас бага бодгиалиас бүрддэг. Энэ зүйлийг хараа хяналтгүй ихээр агнаж байгаа нь аюул учруулж байгаа ч орчны доройтол, халдварт өвчин, эрлийзжилт зэрэг удаах аюул нүүрлэж байна. Энэ жижиг популяцийг D1 шалгуураар үнэлэн эмзэг гэсэн ангилалд оруулсан. Хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн (2000) 7.1-д *R. t. valentinae* салбар зүйлийг нэн ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Агнахыг 1953 оноос хойш хуулиар хориглосон. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулинд нэн ховор жагсаалтанд орсон (БОЯ, 1996), Монгол улсын улаан номын хоёр удаагийн хэвлэлд нэн ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997). Цаа бугын тархац нутгийн 13 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.



**Дэлхийн тархац:** Канад, Америкийн Нэгдсэн улс, Гринланд, Норвеги, Финланд, Оросын Холбооны улс, Монгол.

**Бүс нутгийн тархац:** Хөвсгөлийн уулсын Жодог, Хэвэн, Залуу үүр голын эх орчим, Бяранга, Тэнгис, Шарга голын эх орчмын өндөр уулын тайгын нутгаар тархмал (Банников, 1954; Намнандорж, 1976; Базардорж, Сүхбат, 1984; Литвинов, Базардорж, 1992).

**Ховордлын гол шалтгаан:** Арьс, махыг нь ашиглах зорилгоор хууль бус, хараа хяналтгүй агналт эрс ихэссэн нь популяцийн бууралтанд эрс нөлөөлж ховордуулах гол шалтгаан болж байна. Зарим газар малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхлалт бий болсоны уршгаар орчны доройтол нүүрлэж байна (тодорхой мэдээ шаардлагатай). Мөн малаас бурцоллөз зэрэг өвчнүүд амархан халдварладаг байна. Гэрийн тэжээвэр цаа бугатай эрлийзжих нь боломжит аюул бий бөгөөд эрлийзжилт ямар түвшинд байгаа нь тогтоогдоогүй байна.

## НОМ ЗҮЙ

- Адъяа, Я. (2000). *Монгол тарвага. Биологи, экологи, хамгаалал, ашиглалт*. ADMON Printing, Улаанбаатар.
- Адъяа, Я., Төмөрсүх, Ж. (2001). Хорьдол Сарьдагийн дархан газрын аргалийн популяци, түүний судалгаа. *Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл*. 23: 33-38.
- Адъяа, Яд., Рыдинг, Р.П., Блюмер, Э., Микс, Х., Мижиддорж, Б., Чойжин, С. (2004). Хавтгай тэмээний (*Camelus bactrianus ferus Przewalski, 1883*) сүүлийн үеийн судалгааны тойм. Я. Адъяа, К.Улыкпан (ред.) *Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм*. Хурлын илтгэлийн эмхтгэл. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Даян Дэлхийн Байгаль Орчны Сан, Их Говийн экосистем ба түүний шүхэр зүйлийг хамгаалах төсөл, Улаанбаатар, Монгол. 38-45
- Адъяа, Яд., Довчиндорж, Г. (2005). Хавтгай тэмээний (*Camelus bactrianus*) популяцийн экологийн судалгаанаас. *Шинжлэх Ухааны Академийн Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 25: 44-49.
- Амгалан, Л. (1984). Зүүнгарын говьд хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) байршин сүрэглэх онцлог. *Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 19: 208-213.
- Амгалан, Л. (1986). Монгол орны хар сүүлт зээрийн (*Gazella subgutturosa*) тархац, тоо толгойн одоогийн байдал. *Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 21: 15-19.
- Амгалан, Л. (1995). Монгол орны хар сүүлт зээрийн тархац, тоо толгойн хэлбэлзэл (*Gazella subgutturosa*). *Шинжлэх Ухааны Академи Биологийн хүрээлэн Биологи-30 эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хураангуй*, Улаанбаатар, 56 х
- Амгаланбаатар, С., Рийдинг, Р.П., Дуламцэрэн, С., Онон, Ё., Түмэнцэцэг, Ш., Батсүх, Н. (2002). Монгол орны аргаль хонины (*Ovis ammon*) тархацыг газар зүйн мэдээллийг ашиглан үнэлсэн дүн. *Шинжлэх Ухааны Академийн Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 24: 26-34
- Аваадорж (2005). Монголын хөдөө аж ахуй газар тариалангийн хөгжил; түүхэн хөгжил, одоогийн байдал, ирээдүйн чиг хандлага. 2005 оны 'Биологийн олон янз байдал болон Мал аж ахуйн хөгжил' сэдэвтэй олон улсын хоёр өдрийн конвенцийн тайлангаас, хэвлэгдээгүй материал. Улаанбаатар.
- Бадам, Х. Ариунзул, Я. (эмхэтгэгч, редактор) (2005). *Амьтан, ургамлын холбогдолтой хууль тогтоомжийн эмхтгэл*. Байгаль Орчны Яам. Улаанбаатар. 248 х.
- Байгаль Орчны Яам (БОЯ) (1996). *Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр*. Байгаль Орчны Яам, Улаанбаатар. 143 х.

- Байгаль Орчны Яам (БОЯ) (2005). Ан агнуурын тухай хууль. Бадам, Х. Ариунзул, Я. (ред.) *Амьтан, ургамлын холбогдолтой хууль тогтоомжийн эмхтгэл*. Байгаль Орчны Яам. Улаанбаатар. 140-145.
- Банников, А.Г. (1954). *Млекопитающие Монгольской Народной Республики*. Труды Монгольской комиссии, вып. 53. Академия наук СССР. Москва. 669 с.
- Банников, А.Г. (1981). *Кулан*. Лесная промышленность, Москва. 120 с.
- Батболд, Ж. (1996). Монгол орны тарваганы нөөцийг зохистой ашиглах онол аргазүйн үндэс. *Монгол Улсын Их Сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг*, 3(121): 21-34
- Батсайхан, Н., Лхагвасүрэн, Д., Самъяа, Р. (2004). Их говийн дархан газрын жижиг хөхтөн амьтад. Я. Адъяа, К. Улыкпан (ред.) *Алтайн өвөр говийн экосистемийн зарим судалгааны тойм*. Хурлын илтгэлийн эмхтгэл. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Даян Дэлхийн Байгаль Орчны Сан, Их Говийн Экосистем ба түүний шүхэр зүйлийг хамгаалах төсөл, Улаанбаатар, Монгол. 95-105.
- Базардорж, Д., Сүхбат, Х. (1984). *Хөвсгөл аймгийн ан амьтан, агнуурын аж ахуй*. Эрх чөлөө хэвлэлийн газар. Мөрөн.
- Бобринский, Н.А., Кузнецов, Б.А., Кузякин, А. П. (1965). *Определитель млекопитающих СССР*. Просвещение. Москва
- Гептнер, В.Г., Насимович, А.А., Банников, А.Г. (ред) (1961). *Млекопитающие Советского Союза. Том 1. Парнокопытные и Непарнокопытные*. Вышшая Школа, Москва. 423-441.
- Гептнер, В.Г., Наумов, Н.П., Юргенсон, М.В., Слудский, А.А., Чиркова, А.Ф., Банников А.Г. (ред) (1967). *Млекопитающие Советского Союза, Том 2., Вып 1. Хишник*. Высшая школа, Москва. 1003 с.
- Гуреев, А.А. (1964). Заяцеобразные, *Фауна СССР, Млекопитающие*. Том 3. вып 10: 276 с Изд. Наука, Ленинград.
- Даваа, Н. (1972). Урт сүүлт зурамны идэш тэжээлийн тухай асуудалд. *Монгол Улсын Их Сургуулийн Эрдэм Шинжилгээний бичиг* 40. 53-55.
- Даваа, Н., Базардорж, Д., Литвинов, Н.И., Баасанхүү, Л., Чулуунбаатар, Л., Дорждавга, Т. (1973). К фауне млекопитающих Прихубсугульа. *Природные условия и ресурсы Прихубсугульа*. 2. 174-192.
- Дмитриев, П.П., Таракановский, А.А. (1984). К фауне мелких млекопитающих Юго-восточных предгорий Хэнтэя (МНР). *Зоологический Журнал* 63 (11): 1748-1750.
- Дмитриев, П.П., Швецов, Ю.Г., Дуламцэрэн, С. (1992). *Млекопитающие Хангайского нагорья*. Наука, Москва. 192 х.

- Дорждэрэм, С. (2004). *Монгол орны сарьсан багваахай (Chiroptera: Vespertilionidae) газар зүйн мужаар тархах төлөв байдал*. Бакалаврын ажил. Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар. 78 х.
- Дуламцэрэн, С. (1968). БНМАУ-ын хөхтөн амьтдын ангилал, зүйлийн бүрэлдэхүүний асуудал. *Биологийн Хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний бүтээл*. 2: 77-92.
- Дуламцэрэн, С. (1970). *Монгол орны хөхтөн амьтан тодорхойлох бичиг*. Шинжлэх Ухаан Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 241 х.
- Дуламцэрэн, С. (1977). *Хэнтий, Хангайн ойн туурайтан амьтны экологи, агнуурын холбогдлын зарим асуудал*. Дэд эрдэмтний зэрэг горилсон диссертацийн хураангуй. Улаанбаатар.
- Дуламцэрэн С. (1989). Хангай хэнтийн ойн туруутны экологи. Дуламцэрэн С., Цэнджав, Д., Авирмэд, Д. (ред.) *БНМАУ-ын амьтны аймаг, Хөхтөн амьтан*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 43-92.
- Дуламцэрэн, С., Цэнджав, Д., Авирмэд, Д. (1989). *БНМАУ-ын амьтны аймаг, Хөхтөн амьтан*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 160 х.
- Дуламцэрэн, С., Амгалан, Л. (1995). Монгол бөхөнгийн (*Saiga tatarica mongolica*, Bannikov) тархац, байршил, тоо толгойн одоогийн байдал. *Говийн Их Дархан Газрын байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг*. Хурлын илтгэлийн эмхтгэл. 46-51.
- Дуламцэрэн, С., Дашзэвэг, Г., Тогтохбаяр, Д. (1999). Эрээн хүрний (*Vormela peregusna* Guld, 1770) тархацын тухай шинэ мэдээ. *Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 1: 141-143.
- Дуламцэрэн, С., Амгалан, Л. (2003). Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*). *Биологийн Хүрээлэнгийн бүтээл*. № 24: 64-70.
- Дуламцэрэн, С. (2003). Дэлэнтний ангилал зүй, ангилбарын монгол нэрс. *Монголын нэр томъёоны комиссын мэдээ*. № 148: 75 х.
- Дулмаа, А., Шагдарсүрэн, О. (1973). *БНМАУ-ын агнуурын амьтан ба ан хамгаалал*. ШУА-ийн хэвлэлийн газар Улаанбаатар. 252 х.
- Литвинов, Н.И. (1982). Мелкие млекопитающие Баян-Гольского стационара. В кн: *Природные условия и ресурсы Прихубсугулья*. Иркутск. 59-71.
- Литвинов, Н.И., Базардорж, Д. (1992). *Млекопитающие Прихубсугулья МНР*. Изд. Иркутского Университет. Иркутск. 128 с.

- Лущекина А.А., Неронов В.М., Шурхал, А.В. (1983). *Структура ареала, внутривидовая изменчивость и вопросы рационального использования запасов монгольского дзерена*. Прикладные аспекты программы ЮНЕСКО 'Человек и биосфера'. Москва. 134-146.
- Лущекина, А.А. (1990). *Эколого-географические основы охраны и рационального использования дзерена в МНР*. Автореферат докторской (PhD) диссертаций. Москва. 20 с.
- Лущекина, А.А., Дуламцэрэн, С. (1997). Монгольская сайга: современный статус и перспективы сохранения. *Известия Российской Академии Наук, (Серия Биологии)* 2: 177-185.
- Мижиддорж, Б. (2006). Мазаалай баавгайн экологи, биологи болон хамгааллын асуудал. Докторын диссертаци. Монгол улсын их сургууль. Улаанбаатар. 31 х.
- Мунхцог, Б. (2006). *Биология, экология и охрана ирбиса (Uncia uncia Schreber, 1775)*. Автореферат диссертации на соискание учёной степени кандидата биологических наук, (Ph.D), МГУ, Улаанбаатар.
- Намнандорж, О. (1976). *БНМАУ-ын дархан газар, ан амьтан*. ШУА-ийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 189 х.
- Орлов, В.Н., Мальгин, В.М. (1988). Новый вид хомячков - *Cricetulus sokolovi sp. n.* (Rodentia, Cricetidae) из Монгольской Народной Республики. *Зоологический Журнал*. 67(2): 304-308.
- Павлинов, И.Я., Крускоп, С.В., Варшавский, А.А., Борисенко, А.В. (2002). *Наземные звери России. Справочник-определитель*. КМК. Наука, Москва. 299 с.
- Рачковская, Е. И. (1993). Растительность гобийских пустынь монголий. Наука, Санкт-Петербург. 132 с.
- Самьяа, Р., Батсайхан, Н., Шефтель, Б.И., Цэрэндаваа, П., Амарсайхан, С., Мюленберг, М. (2002). Ерөө голын эх орчмын жижиг хөхтний зүйлийн баялаг, биотопоор байрших онцлог. Монгол ба хил залгаа зарим нутгийн хөхтний судалгаа. *Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэнгийн бүтээл*. 24: 141-148.
- Соколов, В.Е., Орлов, В.Н. (1980). *Определитель млекопитающих МНР*. Наука. Москва. 351 с.
- Соколов, В.Е., Данилкин, А.А., Дуламцэрэн, С. (1982). Современное распространение и численность лесных копытных в Монголии. В кн: *Зоологические исследования в МНР*. Москва. 18: 37-56.
- Соколов В.Е., Швецов, Ю.Г., Литвинов, Н.И. (1985). *Мелкие млекопитающие лесов МНР (Insectivora, Chiroptera, Lagomorpha, Rodentia)*. Наука. Москва. 102 с.

- Соколов В.Е., Шенброт, Г.И. (1987). Новый вид емуранчика - *Stylodipus sungorus sp.n* (Rodentia, Dipodidae) из Западной Монголии. *Зоологический Журнал* 66(4): 579-587.
- Соколов, В.Е., Лобачев, В.С., Орлов, В.Н. (1996). *Млекопитающие Монголии, Тушканчик: Euchoreutinae, Cardiocraniinae, Dipodinae*. Изд. Наука, Москва. 271 с.
- Соколов, В.Е., Лобачев, В.С., Орлов, В.Н. (1998). *Млекопитающие Монголии, Тушканчики: Dipodinae, Allactaginae*. Изд. Наука, Москва. 206 с.
- Сосорбурам, Х. (1970). Хангайн гурван аймгийн агнуурын амьтад, түүний ашиглалт. *Биологийн Ухааны Хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний бүтээл* 5: 120-130.
- Стрелков, П.П. (1983). Усатая ночница (*Myotis mystacinus*), и ночница брандта (*Myotis brandti*) в СССР и взаимоотношения этих видов. *Зоологический Журнал* 62(2): 259-270.
- Стрелков, П.П. (1986). Гобийский кожанок (*Eptesicus gobiensis* Bobrinskoу, 1926) новый вид рукокрылых фауны палеарктики. *Зоологический Журнал* 65(7): 1275-1279.
- Сүхбат, Х., Шагдаржав, Д. (1990). *Ан агнуур*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 122 х.
- Тогтохбаяр, Д., Буянцог, Б., Мөнхцог, Б. (2000). Хүдрийн тархац. *Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 22: 245-246.
- Хотолхүү, Н. (1976). Хэнтийн булганы тархац, байршил, тоо толгой. *Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 10: 106-124
- Хотолхүү, Н. (1980). Хэнтийн булганы популяцийн бүтцийн асуудал. *Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 15: 122-127
- Цагаан, С. (1980). Цагаан зээрийн тархац байршил, сүргийн бүтэц, тоо нөөцийн байдал. *Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 15; 128-139.
- Цэвэгмэд, Д., Цэнджав, Д. (2004). *Монгол орны туулайтан*. Жинст харгана хэвлэлийн компани, Улаанбаатар. 268 х.
- Цэгмид, Ш. (1969). *Монгол орны физик газарзүй*. Монголын ШУА-ийн хэвлэлийн газар, Улаанбаатар.
- Цэнджав, Д., Бүжинханд, Ч. (2000). Баданга хүдэрийн одоо ба ирээдүй (*Moschus moschiferus* L., 1758). *Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 22: 91-94.
- Цэнджав, Д. (2002). *Монгол орны баданга хүдэр (Moschus moschiferus L., 1758)*. Жинст харгана хэвлэлийн компани, Улаанбаатар. 262 х.

- Цэнджав, Д. (2005). Голын халиу (*Lutra lutra* L., 1758) шинэ нутгаас олдов. *Биологийн Хүрээлэнгийн бүтээл* 25: 333.
- Цэрэндаш, С. (2005). 'Хөдөө аж ахуй ба Байгаль хамгаалал' сэдэвтэй 2005 оны олон улсын уулзалт хурал. Улаанбаатар.
- Шагдарсүрэн, О. (1966). *Монгол орны агнуурын амьтад*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар.
- Шагдарсүрэн, О (ред.), Жигж, С., Цэнджав, Д., Дуламцэрэн, С., Болд, А., Мөнхбаяр, Х., Дулмаа, А., Эрдэнэжав, Г., Өлзийхутаг, Н., Лигaa, У., Санчир, Ч. (1987). *БНМАУ-ын улаан ном*. Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газар. Улаанбаатар. 181 х.
- Швецов Ю.Г., Дмитриев П.П., Дуламцэрэн, С., Авирмэд, Д. (1980). Млекопитающие Восточного Хангая. А. И. Черепанов (ред) В кн: *Фауна и Экология позвоночных Сибири*. Новосибирск, 31-57.
- Шенброт, Г.И. (1991). Ревизия подвидовой систематики пятипалых тушканчиков рода *Allactaga* фауны СССР. *Тр. зоол. ин-та АН СССР*. Т. 243. С. 42-58
- Шенброт, Г.И., Соколов, В.Е., Гептнер, В.Г., Ковальская, Ю.Г. (1995). *Млекопитающие России и сопредельных регионов*. Тушканчикообразные. М.: Наука. С 1-573
- Шийрэвдамба, Ц., Шагдарсүрэн, О., Эрдэнэжав, Г., Амгалан, Л., Цэцэгмаа, Ц. (ер. ред.) (1997). *Монгол улсын улаан ном*. АМОН хэвлэлийн газар. Улаанбаатар. 388 х.
- Amgаланbaatar, S. and Reading, R.P. (2000). *Altai Argali*. In: R.P. Reading and B. Miller (eds.) *Endangered Animals: Conflicting Issues*. Greenwood Press, Westport. Pp 5-9.
- Amgаланbaatar, S., Reading, R.P., Lkhagvasuren, B. and Batsukh, N. (2002). Argali Sheep (*Ovis ammon*) Trophy Hunting in Mongolia. *Pirineos* 157: 129-150.
- Baillie, J.E.M. and Groombridge, B. (Compilers and Editors) (1996). *1996 IUCN Red List of Threatened Animals*. IUCN, Gland and Cambridge.
- Batbold, J. (2002). The problems of management of marmots in Mongolia. In: K.B. Armaitage and V.Y. Rumiantsev (eds.) *Holarctic marmots as a factor of biodiversity, proceedings of the third international conference on marmots*. Cheboksary. pp. 68-75. (In English and Russian)
